



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР



# УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САНХҮҮЖИЛТИЙН СТРАТЕГИ



## ТАЛАРХАЛ

Энэхүү төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгааны явцад дэмжлэг үзүүлсэн Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газарт талархал илэрхийлье.

Дор дурдсан байгууллагуудын удирдлага, ажилтнуудад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж, шаардлагатай тоо мэдээ, мэдээллийг хуваалцсанд бид талархаж байна.

Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, тус хэлтсийн Төсөл, хамтын ажиллагааны тасаг,
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс,
- Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар,
- Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газар, Эдийн засгийн статистикийн газар,
- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар, Төсвийн хөрөнгө оруулалтын газар, Хөгжлийн санхүүжилтийн газар,
- Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар,
- Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс,
- Улаанбаатар хотын Хөгжлийн Корпорац,
- Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар.

### Судалгааны баг



## ХУРААНГУЙ

Монгол Улсын Засгийн газар нь Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) болон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (ТХҮБ)-ыг хэрэгжүүлэх амлалт авсан. Манай улсын өмнө тулгарч буй санхүү, эдийн засгийн хүндрэлүүд нь эдгээр хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд тодорхой саад бэрхшээл учруулж байна. Төрийн удирдлагын өнөөгийн тогтолцоо нь санхүүгийн нөөцийг үр ашигтай ашиглаж, үр дүнтэй байлгаж төдийлөн чадахгүй байна. Хөгжлийн санхүүжилтийн орчин олон улсын түвшинд өөрчлөгдөж, илүү өрсөлдөөнтэй, санхүүжилтийн шинэ боломжууд гарч ирж байна.

Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн судалгаа нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд ямар нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг ашиглаж болох, шинэ болон одоо байгаа санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн үр дүнтэй ашиглах, ТХҮБ болон нийслэлийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн асуудлуудыг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогын болон институцийн шинэчлэлийн уялдааг сайжруулахад ашиглах зөвлөмж болох юм.

Энэхүү судалгааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь Улаанбаатар хотын эдийн засаг, санхүүгийн өнөөгийн байдал, нийслэлийн 2007-2016 оны санхүүгийн урсгалын зураглал, нийслэлийн захиргааны удирдлагын бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээ ба хариуцлагын талаарх дүн шинжилгээ, ирээдүйн санхүүгийн урсгалын судалгаа, хөрөнгө оруулалтын төслүүдийн үр ашигт байдал, нийслэлийн хөгжлийн төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлалын санал, Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн стратегийг боловсруулахад чиглэсэн зөвлөмж зэрэг юм.

Энэхүү судалгааны хүрээнд тодорхойлсон асуудлуудад үндэслэн дараах чиглэлээр зөвлөмж өгсөн болно. Үүнд:

1. Хууль, эрх зүйн орчныг сайжруулах,
2. Төслийн хөрөнгө оруулалтын удирдлага, менежментийг сайжруулах,
3. Улаанбаатар хотын төсөвт томоохон хэмжээний тогтмол татварыг бий болгох,
4. Хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмбэлэх тодорхой аргачлал тогтоож хэрэгжүүлэх,
5. Хөрөнгө оруулалт, хөгжлийн санхүүжилтийн хэрэгцээнд хөрөнгө босгох шинэлэг механизм, арга хэрэгслийг бий болгох зэрэг болно.

Дээрх зөвлөмжөөс Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, хотын төсөвт томоохон хэмжээний тогтмол татварыг бий болгох, мөн түүнчлэн хөрөнгө босгох шинэлэг механизм, арга хэрэгслийг бий болгох зэрэг нь дунд хугацаанд хэрэгжүүлэх бодлогын чанартай арга хэмжээ юм. Харин төслийн хөрөнгө оруулалтын удирдлага, менежментийг сайжруулах, хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмбэлэх аргачлал тогтоон хэрэгжүүлэх нь харьцангуй богино хугацаанд Нийслэлийн удирдлага бие даан хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээ юм.

## ТОВЧИЛСОН ҮГ

АХБ	Азийн хөгжлийн банк
БИДШ	Бодлого, институтийн дүн шинжилгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Татварын ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ESOMAR	Бүх гишүүдээр хүлээн зөвшөөрөгдсөн судлаач, мэдээллийн шинжээчдийн ёс зүйн дэлхийн стандарт
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
НЭЗБТХ	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль
ОНТҮГ	
ОУВС	Олон улсын валютын сан
СЯ	Сангийн яам
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТТХ	Төсвийн тухай хууль
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны тусламж

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1: Санхүүгийн урсгалын ангилал

Хүснэгт 2.1: Хууль эрх зүйн үндсэн орчин

Хүснэгт 2.2: Монгол Улсын хүн ам (мянган хүнээр)

Хүснэгт 2.3: Монгол Улсын ДНБ-д Улаанбаатар хотын эзлэх хувийн жин салбараар (хувь)

Хүснэгт 2.4: Улаанбаатар хотын төсвийн нэгтгэл (тэрбум төгрөгөөр)

Хүснэгт 2.5: Улаанбаатар хотын төсвийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)

Хүснэгт 2.6: Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн судалгаа, 2013-16 он (сая төгрөг)

Хүснэгт 2.7: Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, 2013-16 он (сая төгрөг)

Хүснэгт 2.8: Улаанбаатар хот болон дүүргүүдийн орон нутгийн хөгжлийн

сангийн зарцуулалтын судалгаа, 2013 он (сая төгрөгөөр)

Хүснэгт 2.9: Шилжилт хөдөлгөөний мэдээлэл, Улаанбаатар хот, сүүлийн 10 жилээр

Хүснэгт 2.10: Улсын төсвөөс Улаанбаатар хотын төсөвт шилжүүлсэн болон Улаанбаатар хотод хийсэн хөрөнгө оруулалтын судалгаа (сая төгрөг)

Хүснэгт 2.11: Гадаадын зээл, тусламжийн хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжих төслийн 2017 оны санхүүжилт (сая төгрөг)

Хүснэгт 2.12: Концессын гэрээгээр хийсэн хөрөнгө оруулалт, 2015-16 он (сая төгрөг)

Хүснэгт 2.13: Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд хийсэн шинжилгээ

Хүснэгт 2.14: Хөтөлбөрийн үйл ажиллагаанд тулгуурласан үнэлэлт

Хүснэгт 2.15: Үндэсний цэцэрлэгт хүрээлэн төслийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Хүснэгт 3.1: ТХЗ-той хамгийн их уялдсан төсөл, хөтөлбөрүүдэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, сая төгрөгөөр

Хүснэгт 3.2: Илэрсэн зөрчлийн ангиллын судалгаа, сая төгрөгөөр

Хүснэгт 3.3: Илэрсэн зөрчлийн судалгаа, сая төгрөгөөр, хувиар

Хүснэгт 4.1: Төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь оноо өгч, тооцоолох загвар

Хүснэгт 4.2: Үзүүлэлт, онооны хүснэгт

### Шигтгээ

Шигтгээ 2.1: Хөрөнгө оруулалтын төслийн санал боловсруулахад тавигдах шаардлага

## ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

- Дүрслэл 1.1: Баримт бичигт дүн шинжилгээний судалгааны арга
- Дүрслэл 1.2: Улаанбаатар хотыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, түүний бүтэц
- Дүрслэл 2.1: Хөрөнгө оруулалтын төсөв боловсруулж, батлах үйл ажиллагааны процесс
- Дүрслэл 2.2: Нийслэлийн нэгдсэн төсвийн орлого, 2006-2016 онд
- Дүрслэл 2.3: Нийслэлийн нэгдсэн төсвийн бүтцийн харьцуулалт
- Дүрслэл 2.4: Улсын болон Улаанбаатар хотын дотоодын нийт бүтээгдэхүүн, харьцуулснаар
- Дүрслэл 2.5: Нийслэлийн татварын орлогын бүтцийн харьцуулалт
- Дүрслэл 2.6: Нийт зарлагын бүтцийн харьцуулалт, 2006-2016 онд
- Дүрслэл 2.7: Нийслэлийн урсгал зардлын бүтцийн харьцуулалт, 2006-2016 онд
- Дүрслэл 2.8: Нийслэлийн төсвийн үндсэн үзүүлэлтүүд харьцуулснаар, 2006-2016 он
- Дүрслэл 2.9: ДНБ-д эзлэх Засгийн газрын нийт ХАЁТ ба нэг хүнд ногдох хэмжээ, ам доллароор, 2015 оны тогтмол үнээр
- Дүрслэл 2.10: Төсөвт байгууллагаар дамжуулан дэд бүтцийн төсөлд үзүүлэх санхүүжилтийн загварчлал
- Дүрслэл 2.11: Засгийн газрын байгууллагуудын үүрэг
- Дүрслэл 2.12: Төсөл, хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн харилцан хамаарал
- Дүрслэл 3.1: Төслүүдийн Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан байдал
- Дүрслэл 3.2: Нийслэлийн хөрөнгө оруулалтын шинэчилсэн тогтолцоо
- Дүрслэл 3.3: Бодлого тодорхойлоход иргэд, олон нийтийн оролцоог хангах дэс дараалал
- Дүрслэл 3.4: Төлөвлөлтийн процесс
- Дүрслэл 3.5: Зөрчлийн ангилал тус бүрийн нийт илэрсэн зөрчилд эзлэх хувь
- Дүрслэл 3.6: Илэрсэн зөрчлийн судалгаа, байгууллагаар, сая төгрөгөөр, хувиар
- Дүрслэл 3.7: ХАЁТ-ийн салбаруудын хуваарилалт, 2016 оноор
- Дүрслэл 4.1: Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоо
- Дүрслэл 4.2: Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн санхүүжилтийн схем
- Дүрслэл 4.3: Эмээлтийн үйлдвэр технологийн паркын санхүүжилтийн схем
- Дүрслэл 4.4: Бодлого тодорхойлоход иргэд, олон нийтийн оролцоог хангах дэс дараалал

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт хүснэгт 1. Улаанбаатар хотын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний цаглабар, хяналтад баримтлах шалгуур

Хавсралт хүснэгт 2. Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн саналын баталгаажуулалтын судалгаа

Хавсралт хүснэгт 3. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын шинэчилсэн жагсаалтын харьцуулалт

Хавсралт хүснэгт 4. Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, сая төгрөг, 2010-2015 он, салбараар

Хавсралт хүснэгт 5. Улаанбаатар хотын дотоодын нийт бүтээгдэхүүн, сая төгрөг, 2010-2015 он, салбараар

Хавсралт хүснэгт 6. Улсын ДНБ-д Улаанбаатар хотын эзлэх хувийн жин, сая төгрөг, 2010-2015, салбараар

Хавсралт хүснэгт 7. Улаанбаатар хотын төсвийн татварын орлогын дэлгэрэнгүй судалгаа, мянган төгрөгөөр, 2006-2016

Хавсралт хүснэгт 8. Улаанбаатар хотын төсвийн зарлага, санхүүжилтийн дэлгэрэнгүй судалгаа, 2006-2016

Хавсралт хүснэгт 9. "Ухаалаг Улаанбаатар" хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх судалгааны асуулга

Хавсралт 10. Ухаалаг Улаанбаатар хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд

Хавсралт 11. Улаанбаатар хотын хөгжлийн төслүүдийн улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилттой уялдсан байдлыг харьцуулан үнэлэх матриц

Хавсралт 12.1 Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн төсвийн нэгтгэл

Хавсралт 12.2 Тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн эхний 10 төслүүдийн мэдээлэл

Хавсралт 12.3 Төсөл хэрэгжүүлэх хугацааны судалгаа (эрэмбэлэгдсэн эхний 10 төслүүд)

Хавсралт 12.4 Төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх салбар (эрэмбэлэгдсэн эхний 10 төслүүд)

Хавсралт 12.5. Төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь үнэлж эрэмбэлсэн үнэлгээний нэгтгэл

Хавсралт 12.6. Төслүүдийн товч мэдээлэл, кодчиллол

## АГУУЛГА

ТАЛАРХАЛ.....	2
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ.....	3
ТОВЧИЛСОН ҮГ.....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	5
Шигтгээ.....	5
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ.....	6
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ.....	7
БҮЛЭГ 1. УДИРТГАЛ.....	10
1.1 Оршил.....	10
1.2 Судалгааны зорилго.....	10
1.3 Судалгааны цар хүрээ, гол асуултууд.....	11
1.4 Судалгааны арга зүй, мэдээллийн эх сурвалж.....	11
1.5 Улаанбаатар хотын хөгжлийн бодлого.....	13
БҮЛЭГ 2. УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	14
2.1. Санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо.....	14
2.1.1 Хууль эрх зүйн орчин: Холбогдох хуулиуд.....	14
2.1.2 Төсвийн хүрээ: Улаанбаатар хотын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт.....	16
2.1.3 Хөрөнгө оруулалтын төсөв боловсруулж, батлах үйл ажиллагааны доголдол.....	17
2.2 Санхүүжилтийн механизм, эх үүсвэрүүд.....	19
2.2.1 Улаанбаатар хотын хүн ам.....	19
2.2.2 Улаанбаатар хотын эдийн засаг.....	19
2.2.3 Улаанбаатар хотын төсөв.....	20
2.2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалт.....	31
2.2.5 Гадаадын зээл, тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалт.....	32
2.2.6 Улаанбаатар хотын орон нутгийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгийн удирдлага.....	34
2.2.7 Зардлаа нөхсөн байх зарчим.....	35
2.2.8. Санхүүжилтийн бусад эх үүсвэрүүд.....	36
2.3. Хотын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд тулгардаг сорилтууд.....	39
2.3.1 Төсвийн алдагдал, ядуурал.....	39
2.3.2 Дотоодын зах зээл дэх эх үүсвэрийн хязгаарлагдмал байдал.....	40
2.3.3 Төсөл хөгжүүлэх, зөв бүтэц боловсруулах чадавх.....	40
2.3.4 Төслийн санхүүгийн чадавхгүй байдал.....	41
2.3.5 Институтийн чадавх сул: Засгийн газар, холбогдох агентлагуудын чиг үүргийн давхцал.....	41
2.3.6 Хотын менежментийн үр ашиг, чадавх.....	42
2.3.7 Мэдээллийн хүртээмж.....	42
2.4 Хөрөнгө оруулалтын төслийн үр ашигт байдал.....	42
2.5. Бүлгийн дүгнэлт.....	52
БҮЛЭГ 3. САНХҮҮЖИЛТИЙН СТРАТЕГИ.....	53



<b>3.1 Улаанбаатар хотын хөгжлийн зорилтыг хангахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүд ба ТХЗ-уудын уялдаа</b> .....	53
<b>3.2 Төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт</b> .....	54
<b>3.3 Стратеги 1: Санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх</b> .....	57
3.3.1 Дэд стратеги: Хууль эрх зүйн орчныг сайжруулах .....	58
3.3.2 Дэд стратеги: Хөрөнгө оруулалтын удирдлага, тогтолцооны шинэчлэл .....	59
3.3.3 Дэд стратеги: Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн тогтолцоонд иргэд, олон нийтийн оролцоог хангах .....	61
3.3.4 Дэд стратеги: Улаанбаатар хотын төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх.....	63
<b>3.4 Стратеги 2: Хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх</b> .....	65
<b>3.5 Стратеги 3: Гадаад эх үүсвэрийг татах</b> .....	66
3.5.1 Дэд стратеги: Хөгжлийн албан ёсны тусламж .....	66
3.5.2 Дэд стратеги: Даян дэлхийн хөнгөлөлттэй сангууд .....	67
<b>3.6 Стратеги 4: Санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг бий болгох</b> .....	69
3.6.1 Дэд стратеги: Улаанбаатар хотын төсөвт томоохон хэмжээний тогтмол татварыг бий болгох .....	69
3.6.2 Дэд стратеги: Гарааны хөрөнгө оруулалтыг бий болгох .....	70
<b>3.7 Стратеги 5: Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх</b> .....	71
3.7.1 Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоо: Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хувьд.....	74
3.7.2 Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоо: Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн хувьд.....	76
<b>БҮЛЭГ 4. ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЦЭЭ, ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДЛООР НЬ ЭРЭМБЭЛЭХ АРГАЧЛАЛ</b>	79
4.1 Нийтлэг үндэслэл.....	79
4.2 Хамрах хүрээ, зорилго .....	80
4.3 Суурь зарчим.....	80
4.4 Аргачлал, үнэлгээний загвар .....	83
4.5 Аргачлалын туршилт, хэрэглээ .....	83
<b>БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ</b> .....	85
<b>ХАВСРАЛТУУД</b> .....	86
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b> .....	142

## БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

### 1.1 Оршил

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас баталсан 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрийг чиг баримжаа болгон, Монгол Улсын Их Хурал (УИХ)-аас **"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"** (ТХҮБ) урт хугацааны тогтвортой хөгжлийн баримт бичгийг 2016 онд баталсан. ТХҮБ болон ТХЗ-ыг Улаанбаатар хотын түвшинд хэрэгжүүлэхэд түлхэц өгөх зорилгоор Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) нь **"Улаанбаатар хотын хөгжлийн төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэх, санхүүжилтийн стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх"** зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ хүрээнд "Тогтвортой хөгжлийн зорилгуудыг Улаанбаатар хотод нутагшуулах" төслийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ)-ын захиалгаар "Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн өнөөгийн байдал, санхүүжилтийн стратеги" судалгааг Улаанбаатар Аудит Корпорац ХХК гүйцэтгэв.

Энэхүү тайлан нь үндэсний мэргэжилтнүүдийн багийн хийж гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээний үр дүн юм. Зөвлөх үйлчилгээний явцад Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, хөрөнгө оруулалтын төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь үнэлэх аргачлал боловсруулах, хөгжлийн санхүүжилтийн стратегийн санал боловсруулах гэсэн үндсэн гурван ажлыг хийж гүйцэтгэсэн.

Санхүүжилтийн стратегийг боловсруулах үйл ажиллагааны эхний алхам нь нийслэл, Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн бүхий л асуудал, үүний дотор санхүүгийн эх үүсвэр, санхүүгийн системийн зохион байгуулалт, санхүүжилтийн янз бүрийн чиг үүргийг зохицуулж буй бодлого болон практик, үйл ажиллагаа, чадавх зэргийг судалж үзэхээс эхэлнэ. Түүнчлэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн дотоодын нөөцийг дайчлах, зүй зохистой ашиглах, уялдуулах зэрэг хөгжлийн санхүүжилтийн тулгамдсан асуудлуудыг системтэйгээр авч үзнэ.

Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн стратеги нь ТХҮБ 2030, ТХЗ, УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан **"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"** болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон хөгжлийн үр шимийг нийслэлийн иргэд тэгш хүртэх боломжийг хурдасгах санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн оновчтой механизм бий болгох, түүний үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэхүү тайлан нь **5 үндсэн хэсгээс** бүрдэнэ. Удиртгал бүлэгт судалгааны зорилго, цар хүрээ, арга зүй, мэдээллийн эх сурвалжийн талаар, хоёрдугаар бүлэгт Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн өнөөгийн байдлын талаар, гуравдугаар бүлэгт төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлалын санал, түүний хэрэглээний талаар, дөрөвдүгээр бүлэгт санхүүжилтийн стратегийн бодлогыг сайжруулах зөвлөмжийг, тавдугаар бүлэгт судалгааны ерөнхий дүгнэлтийг нэгтгэн харуулсан болно.

### 1.2 Судалгааны зорилго

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь хотын төсвийн орлогын эх үүсвэр болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд гарч буй зарлагыг судлах замаар Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн эх үүсвэрийн боломжийг тодорхойлж, санхүүгийн системийн зохион байгуулалт, санхүүжилтийн янз бүрийн чиг үүргийг зохицуулж буй бодлого болон практик, үйл ажиллагаа, чадавхын талаар үнэлгээ өгөх явдал юм. Энэхүү үнэлгээнд үндэслэн хөрөнгө оруулалтын төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлалын төслийг боловсруулах, санхүүжилтийг тогтвортой байлгах урт хугацааны хэтийн төлөвийг тодорхойлсон хөгжлийн санхүүжилтийн стратегийн талаар зөвлөмжийг нийслэлийн удирдлагуудад санал болгох зорилготой юм.

Энэ ажлын хүрээнд хотоос үзүүлэх үйлчилгээ, дэд бүтцийн ажлыг санхүүжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай, тэнцвэртэй хуваарилахад тулгарч буй бүтцийн болон тогтолцооны хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлно.

Энэхүү судалгаа нь нийслэлийн удирдлагуудыг (1) хотын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг сайжруулах, (2) хөрөнгө оруулалтын төслийн удирдлага, менежментийг сайжруулах чиглэлээр хотын хөрөнгө оруулалтын институтыг бэхжүүлэн, чадварыг дэмжих, (3) хотын төсөвт бизнесийн идэвх санаачилгатай шууд уялдсан, тогтмол, томоохон хэмжээний шинэ татварын орлогыг санаачлан бий болгох, (4) хөрөнгө оруулалтын төслийн үр ашгийг нэмэгдүүлэхэд юунд анхаарах талаар зөвлөмж өгөхөд чиглэгдэнэ.

### 1.3 Судалгааны цар хүрээ, гол асуултууд

Юуны өмнө энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын санхүүгийн тогтолцоо хэрхэн ажиллаж байгааг үнэлж дүгнэхэд гол анхаарлыг хандуулна. Энэ ерөнхий зорилгын хүрээнд судалгааны ажил нь нийслэл болон түүний дүүргүүдийн төсөв санхүүгийн байдлын ерөнхий асуудлыг хамрах бөгөөд тэдгээрийн орлогын эх үүсвэр, зарлага, тэдгээрийн чиг хандлагад дүн шинжилгээ хийнэ. Үүний тулд судалгаа нь доорх гол асуултад хариулт өгнө. Үүнд:

- Нийслэлийн орлогын эх үүсвэр, цаашдын хандлага ямар байх вэ?
- Нийслэлийн зарлага, түүний үр ашгийг сайжруулахад саад болж буй гол асуудал нь юу вэ?
- Орон нутгийн, улсын төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын орчин нөхцөл ямар байна вэ?
- Санхүүжилтийн бусад эх үүсвэрүүдийн боломж байгаа юу?
- Хотын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд тулгардаг сорилтууд юу вэ?
- Нийслэлд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийн үр дүн, юунд анхаарал хандуулах вэ?
- Нийслэлийн санхүүгийн тогтолцооны ямар хэсэгт цаашид судалгаа, өөрчлөлт шаардагдах вэ?

### 1.4 Судалгааны арга зүй, мэдээллийн эх сурвалж

**Судалгааны арга зүй.** “Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн өнөөгийн байдал, санхүүжилтийн стратеги”-ийг олон улсын судалгааны ёс зүйн стандарт болох ESOMAR<sup>1</sup>-ын кодыг баримтлан хийлээ.

Санхүүгийн урсгалын (эх үүсвэрийн) дүн шинжилгээ нь 2007-2016 оны төсвийн жилийг хамрах бөгөөд нийслэлийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг санхүүжүүлэхэд чиглэсэн дотоодын болон гадаад, төрийн болон хувийн хөрөнгийн эх үүсвэрийг хамарсан. Санхүүгийн зураглалыг тодорхойлохын тулд нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийг улсын дундаж ба орон нутгийн дундаж түвшинд харьцуулж авч үзсэн.

Санхүүгийн зураглалыг шинжилгээний гурван түвшинд авч үзсэн. 1 дүгээр түвшний шинжилгээнд а) дотоодын-улсын, б) гадаадын-улсын, в) дотоодын-хувийн, г) гадаад-хувийн санхүүжилтийг хамруулсан. 2 дугаар түвшний хувьд 1 дүгээр түвшний санхүүгийн эх үүсвэр бүрийн задаргаа (жишээ нь, орон нутгийн орлого), 3 дугаар түвшинд мэдээллийн хүртээмж, олдцоос шалтгаалан нарийвчилсан задаргаа (жишээ нь, татварын болон татварын бус орлого, хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-ийн янз бүрийн хэлбэрүүд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих сан, төр-хувийн хэвшлийн санхүүжилт)-г хийсэн. Мэдээллийн эх сурвалж нь албан ёсны статистик тоо, мэдээлэл, Монгол улсын Засгийн газар болон орон нутгийн захиргаанаас гаргасан улсын салбарын санхүүгийн мэдээлэл бөгөөд янз бүрийн эх сурвалжийн мэдээллийг хооронд нь харьцуулахад чиглэгдсэн болно. Түүнчлэн, тоон өгөгдлийн

<sup>1</sup> ESOMAR-ийн бүх гишүүдээр хүлээн зөвшөөрөгдсөн судлаач, мэдээллийн шинжээчдийн ёс зүйн дэлхийн стандарт.

шинжилгээ (ялангуяа мэдээллийн задаргааны түвшинд)-г тодорхой сэдвээр хийсэн судалгаа, үнэлгээний үр дүн, мэдээллээр баяжуулах арга зүйг баримталсан болно.

### Хүснэгт 1.1: Санхүүгийн урсгалын ангилал

	Улсын	Хувийн
Дотоод	<ul style="list-style-type: none"> <li>- Татварын орлого</li> <li>- Татварын бус орлого</li> <li>- Засгийн газрын зээллэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дотоодын хуримтлал/ хөрөнгө оруулалт</li> <li>- Дотоодын зээл</li> </ul>
Гадаад	<ul style="list-style-type: none"> <li>- ХАЁТ-ын буцалтгүй тусламж, зээл</li> <li>- Бусад албан ёсны урсгал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын санхүүгийн зах зээл</li> <li>- Гадаадын шууд хөрөнгө оруулалт</li> <li>- Мөнгөн гуйвуулга</li> </ul>


Санхүүгийн урсгалын зураглалыг ашиглан Бодлого, институтийн дүн шинжилгээ (БИДШ)-ний арга зүйг баримталсан. БИДШ нь нийслэлийн төрийн захиргааны салбарын удирдлагын ямар бүтэц, үе шат нь хөгжлийн зорилтууд болон ТХЗ-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байгааг үнэлэхэд чиглэнэ. БИДШ нь Ази, Номхон далайн хөгжлийн үр өгөөжийг дэмжих байгууллага болон НҮБХХ-өөс санаачлан явуулсан Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ (Development finance assessment)-нд ашигласан арга зүй юм.

БИДШ нь дараах гурван төрлийн мэдээллийн эх сурвалж дээр тулгуурласан: (1) санхүүгийн зураглалын үр дүн, (2) төрийн болон хувийн салбарын оролцогч талуудтай судалгааны багийн хийсэн ярилцлагаас олж цуглуулсан үндсэн мэдээлэл, (3) төсөв, хөрөнгө оруулалтын тоон шинжилгээ зэрэг баримт бичгийн судалгаа (хоёрдогч эх үүсвэр).

Дээр дурдсан “Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ”-ний хүрээнд хийсэн “ижил төстэй орлогын түвшинтэй бусад орнуудтай Монгол улсын санхүүгийн урсгалуудын чиг хандлага, бүтцийг харьцуулсан ирээдүйн дүн шинжилгээ”-г энэхүү судалгаанд ашиглав. Энэхүү дүн шинжилгээ нь нийслэлийн нэмэлт санхүүжилт дайчлах боломжийг харуулах зорилготой юм.

Хөгжлийн хөрөнгө оруулалтын чиглэлээр нийслэл Улаанбаатар хотын түвшинд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн хамрах хүрээ, шаардлага, Монгол улсын үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн баримт бичигт дүн шинжилгээ хийхэд Дүрслэл 1.1-д харуулсан судалгааны арга зүйг ашигласан болно.

### Дүрслэл 1.1. Баримт бичигт дүн шинжилгээний судалгааны арга



**Мэдээлэл цуглуулалт.** Энэхүү судалгаа нь Сангийн яам (СЯ), салбарын бусад яам, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Монголбанк, Нийслэлийн ЗДТГ, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ болон холбогдох бусад орон нутгийн төрийн байгууллагаас гаргасан үндсэн мэдээллийн эх сурвалж, Азийн хөгжлийн банк (АХБ), болон бусад олон улсын байгууллагын гаргасан хоёрдогч мэдээллийн эх сурвалжид үндэслэн хийгдсэн болно. Түүнчлэн, тоон өгөгдлийг задлан шинжлэхдээ янз бүрийн судалгаануудын үр дүн, дүн шинжилгээг ашигласан болно.

Энэхүү судалгааг хийхийн тулд шинжилгээ хийх тоо мэдээллийг нийслэл, түүний 9 дүүргийн батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийн тоо мэдээнээс авсан. Нийслэлийн нэгдсэн төсвийн тоо мэдээлэлд 2006-2016 оны батлагдсан төсөв болон 2006-2016 оны орлого, зарлагын тоо мэдээ хамаарна. Нийслэл, түүний 9 дүүргийн төсвийн задаргааны хувьд орлогын 2006-2016 оны мэдээ, харин зарлагын 2006-2016 оны тоо мэдээг ашигласан.

Судалгааны баг нь 2017 оны 9-р сард Нийслэлийн ЗДТГ, Сангийн яам, Монголбанк, ҮСХ, Татварын ерөнхий газар (ТЕГ)-аас санхүү, төсөв, төсвийн гүйцэтгэлийн үндсэн мэдээллийг 10 жилийн хугацаатай (2007-2016 оны санхүүжилт) өгөхийг хүссэн. Түүнчлэн ОНТҮГ, засгийн газрын байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагууд, төрийн бус байгууллага (ТББ), Дэлхийн банк (ДБ), Олон улсын валютын сан (ОУВС), АХБ, НҮБХХ зэрэг оролцогч талуудаас холбогдох мэдээлэл, үнэлгээ, баримт бичгүүдийг цуглуулж, оролцогч талуудтай уулзалт хийж нэмэлт мэдээлэл авах замаар хоёрдогч тоон болон чанарын мэдээлэл цуглуулсан. Мэдээллийн эх сурвалжууд нь зарим талаар давхцаж байсан бөгөөд энэ нь судалгааны багийг янз бүрийн эх сурвалжуудын хоорондын мэдээллийг судалж ашиглах боломж олгосон юм.

## 1.5 Улаанбаатар хотын хөгжлийн бодлого

**Хөгжлийн тэргүүлэх чиглэл, зорилтууд.** Улаанбаатар хот нь өнөөг хүртэл таван удаа хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж иржээ. Сүүлийн жилүүдэд Монгол улсын нийгэм, эдийн засгийн өөрчлөлт ялангуяа эдийн засгийн хурдацтай өсөлтөөс шалтгаалж хотжилт маш хурдацтай явагдаж байгаа нөхцөл байдлаас шалтгаалж Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсны үндсэн дээр “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ыг боловсруулан УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан байна. Энэ нь Улаанбаатар хотыг хөгжүүлэх дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндсэн баримт бичиг юм. Энэхүү батлагдсан ерөнхий төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн зэргийг нарийвчлан тооцоолсон төлөвлөгөө гаргажээ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дүрслэл 1.2-д харуулсан 6 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна.

### Дүрслэл 1.2. Улаанбаатар хотыг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, түүний бүтэц



Эх үүсвэр. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”, 2013, УБ.

**Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн хэрэгцээ.** Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс харахад хэтийн төлөвийн тооцооллоор улсын төсвөөс нийслэлд хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээг 2016-2020 онд 916 тэрбум төгрөг орчим (буюу жилдээ улсын нийт хөрөнгө оруулалтын 15 хувийг нийслэлд зориулж байсан чиг хандлагыг хэвээр гэж таамагласнаар), мөн нийслэлийн төсвийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд зарцуулах нийт хөрөнгө оруулалт таван жилд 1 их наяд төгрөг байхаар урьдчилан тооцоолж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө зэргийг нэмснээр 2016-2020 онд хэрэгжүүлэх ажлын нийт төсөвт өртгийг 5 их наяд төгрөг орчим байхаар боловсруулсан байна. Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн төсвийн нэгтгэлийг Хавсралт хүснэгт 11.1-д харуулав.

## БҮЛЭГ 2. УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 2.1. Санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо

#### 2.1.1 Хууль эрх зүйн орчин: Холбогдох хуулиуд

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн үйл явцад Улаанбаатар хот, түүний дүүргүүдийн санхүүгийн үүрэг хариуцлага, эрх мэдэл болон санхүүгийн удирдлагын талаарх хууль эрх зүйн орчин шат дараалалтайгаар өөрчлөгдсөөр ирсэн. 1992 онд батлагдсан Монгол улсын үндсэн хууль нь Засгийн газрын бүтэц болон орон нутгийн удирдлагын үндсэн зарчмын талаар эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Үндсэн хуульд Монгол улсын засаг захиргаа нь аймаг, нийслэлд харин аймаг, нийслэл нь сум, дүүрэгт хуваагдах бөгөөд эдгээр нэгж нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, эрх мэдэл бүхий засаг захиргаа, нийгэм, эдийн засгийн цогцолбор болохын хувьд өөрийн удирдлагатай байна гэж заасан. Энэхүү хууль эрх зүйн орчинд гарсан шинэчлэл нь хотын үйлчилгээг орон нутгийн удирдлагад шилжүүлсэн бөгөөд салбарын яамд боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээ үзүүлэх эрх мэдлээ орон нутагт төлөөлүүлэн шилжүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн. Энэхүү судалгаатай холбоотой хууль эрх зүйн хэсгийг Хүснэгт 2.1-д харуулав.

#### Хүснэгт 2.1 Хууль эрх зүйн үндсэн орчин

ХУУЛЬ	ХОЛБОГДОХ ЗААЛТ
Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. Огноо:2006.12.15	Энэ хууль нь засаг захиргааны тогтолцоо, бүтэц болон бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулдаг. Хуулийн 31 дүгээр зүйлд сум, дүүрэг нь усан хангамж, хог хаягдал, бохир ус зайлуулах, цэвэрлэх, гудамж талбайг гэрэлтүүлэх, нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнг арчлах зэрэг үүрэгтэй гэж заасан.
Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль (НЭЗБТХ). (1994 оны хуучин хууль) Огноо:Шинэчилсэн хуулийн төсөл одоогоор батлагдаагүй.	Нийслэл нь УИХ болон улсын төсвийн ерөнхийлөн захирагч (салбарын яамд гм) нараас шаардсан чиг үүргийг гүйцэтгэнэ. НЭЗБТХ-д (4.9.3-р зүйлд) Нийслэл нь “цахилгаан түгээх, зам, харилцаа холбоо болон мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэхэд оролцоно” гэж заасан байдаг.
Төсвийн тухай хууль (ТТХ).	Энэ хуулиар төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх,

Огноо:2011.12.23	төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг. ТТХ (14.2.2, 14.2.3-р зүйлд)-д Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн удирдлагын талаар “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, мөн “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заажээ.
Татварын ерөнхий хууль. Огноо:2008.05.20	Энэ хуулиар Монгол улсад татвар бий болгох, хувь хэмжээг тогтоох, ногдуулах, хураах, тайлагнах, хянах эрх зүйн үндэс болон татвар төлөгч, татварын албаны эрх, үүргийг тодорхойлсон. Мөн энэ хуулиар татварын хувь хэмжээг тогтооход Засгийн газар, нийслэл, аймгийн эрх мэдлийг зааж өгсөн.
Нийслэл хотын албан татварын тухай хууль Огноо:2015.06.19	Энэ хуулиар нийслэл хотын албан татвар ногдуулах, уг татварыг төсөвт төвлөрүүлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Татвар төлөгчийн худалдан авсан бүх төрлийн согтууруулах ундаа, тамхи зэрэг бараанд, зочид буудал, амралтын газар, ресторан, баар зэрэг үйлчилгээнд нийслэл хотын албан татвар ногдуулна. Нийслэл хотын албан татварын хувь, хэмжээг байршил, хүн амын төвлөрлийг харгалзан 0-1.0 хувийн хязгаарт багтаан нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална гэж заасан.
Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль Огноо:2015.06.26	Энэ хуулиар иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор нийслэлийн барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
Хот байгуулалтын тухай хууль Огноо:2008.05.29	Энэ хуулиар Монгол улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харьцангуй бие даан хөгжих бүс нутгийн хөгжлийн зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг хот төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулдаг.
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Огноо:1996.05.27	Нийслэлийн өмчтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулна. Энэ хуульд “НИТХ нь орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, өөрчлөн байгуулах шийдвэр гаргах, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхтэй” гэж заасан.

Ерөнхийдөө хууль эрх зүйн орчинд хийгдэж буй шинэчлэл, өөрчлөлт нь орон нутгийн статусыг аажмаар бэхжүүлж байна гэхэд болно. Өнөөгийн хууль эрх зүйн орчин нийт төрийн байгууллагын хувьд хэрэгжиж буй хэм хэмжээ, үйл ажиллагааны зарчмаас бүрдэнэ. Гэвч засаг захиргааны бүх шатанд эрх мэдлийн төвлөрлийг сааруулах ажлыг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд, дээрх хуулиудын хэрэгжилтийг бодитой, үр ашигтай болгох нэмэлт зохицуулалтууд хэрэгтэй байгаа нь харагдаж байна. Энэ тайланд тодорхой асуудлуудыг тухайн бүлэг бүрд авч үзсэн болно.

## 2.1.2 Төсвийн хүрээ: Улаанбаатар хотын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт

Энэ хэсэгт Улаанбаатар хотын төсвийн төлөвлөлтийн цаглабарыг нарийвчлан судалж үзэв. Төсвийн цагалбарын үндсэн үе шат нь олон улсын стандартын дагуу (1) боловсруулах, (2) өргөн мэдүүлэх, дахин хянах, (3) батлах, (4) зарцуулах, тайлагнах, хяналт тавих, гүйцэтгэлд үнэлэлт өгөх гэсэн дараалалтай байна. Хавсралт Хүснэгт 1-ийг харна уу.

Улаанбаатар хотын төсвийн төлөвлөлтийг Монгол улсын төсвийн тухай хуулийн хүрээнд Сангийн яамнаас хүргүүлсэн ирэх оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид үндэслэн орон нутгийн төсвийн цаглабарын дагуу нийслэл, дүүрэг, төсөвт байгууллагууд боловсруулдаг. Төсвийн төсөлд төсвийн урсгал зардлын санал, төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл арга хэмжээний санал багтдаг.

Энэхүү цаглабарын хүрээнд нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын санал боловсруулахаас эхлээд батлагдах хүртэлх үе шат бүрд тавигддаг шаардлагаас хамаарч хөрөнгө оруулалтын санал маш их өөрчлөгдөж, хянагддаг байна.

Нийслэлийн ЗДТГ нь улсын төсвийн хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн санал (буюу хүслийн жагсаалт)-ыг салбарын яамдад, улмаар СЯ-д жил бүр хүргүүлдэг. Бид улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санал болон тухайн оны Төсвийн тухайн хуульд туссан байдлыг харьцуулан судалж үзлээ. Судалгааг Хавсралт хүснэгт 2-оос харна уу.

2016 оны байдлаар авч үзвэл, Нийслэлийн ЗДТГ-аас нийт 3,735,589.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 783 төрлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж 1,935,055.4 сая төгрөгийн саналыг салбарын яамдад хүргүүлсэн байна. Эдгээр 783 төрлийн төсөл, арга хэмжээний саналаас салбарын яамд болон СЯ-ны хяналтаар 760 санал хасагдаж, зөвхөн 867,455 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 нэр төрлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зориулж 276,548 сая төгрөгийн санхүүжилтийн саналыг Улсын төсвийн төсөлд тусгахаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нийслэлд хамаарах хэдий хэрийн эх үүсвэр батлагдсаныг судалж үзвэл, 410,749.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 110 нэр төрлийн төсөл, арга хэмжээнд зориулж 73,504.9 сая төгрөг батлагджээ. Харин сонирхолтой нь дээр дурдсан 23 нэр төрлийн саналаас зөвхөн 16 төсөл, арга хэмжээг л тусгаж түүнд 12,825 сая төгрөг батлагдсан байна. Эндээс харахад яамдын болон УИХ-ын түвшний шийдвэрээр 332,418 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 94 нэр төрлийн төсөл, арга хэмжээнд зориулж 60,680 сая төгрөгийн санхүүжилтийг Улсын төсөвт нэмж тусгасан гэж үзэж болно.

Мөн ийм судалгааг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал (НИТХ)-аар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын шинэчилсэн жагсаалтын хүрээнд харьцуулан хийж үзлээ. Судалгааг Хавсралт хүснэгт 3-аас харна уу.

НЗДТГ-аас 2016 онд нийт 347,966 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 99 төрлийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж 149,305 сая төгрөгийн саналыг НИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн байна. НИТХ-ийн хэлэлцүүлгийн явцад нийт өргөн барьсан хөрөнгө оруулалтын 99 саналаас 11 саналыг хасаж, 88 саналыг хэвээр үлдээн, харин иргэдийн төлөөлөгчдийн саналаар 12 саналыг нэмж, нийт 346,730 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 100 нэр төрлийн төсөл, арга хэмжээнд зориулж 203,535 сая төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

Дээрх судалгаанаас харахад улсын төсвийн хөрөнгөөр санхүүжин нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын санал болон УИХ-аас баталсан Монгол улсын төсвийн тухай хуульд туссан төсөл хоёрын хооронд маш их ялгаа байна. Тиймээс ямар төрлийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийхээс татгалзсан болон яагаад ийм их ялгаатай байгаа талаар цаад учир шалтгааныг судалж үзэх нь ач холбогдолтой байна. Нийслэл, дүүргийн төсөв, хөрөнгө оруулалтын төслийг хянахад баримталдаг шалгуур үзүүлэлтийн талаар Хавсралт хүснэгт 1-ийн 3-р баганад харуулсан болно.



Бид хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлал боловсруулах үедээ энэ асуудлыг судлан үзэж, анхааралтай авч үзсэн болно.

**Шигтгээ 2.1: Хөрөнгө оруулалтын төслийн санал боловсруулахад тавигдах шаардлага**

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн санал нь дараах шаардлагыг хангах ёстой байна. Үүнд:

**1. Барилга байгууламж, их засварын ажил**

- зураг төсөв хийгдсэн, экспертизээр баталгаажсан байх,
- төсөвт өртгийн тооцоо экспертиз хийгдсэн байх,
- газрын зөвшөөрөл хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдсэн байх,
- газрын геодезийн үнэлгээ хийгдсэн байх,
- ТЭЗҮ хийгдсэн байх,
- шинээр баригдах барилга, байгууламжийн техникийн нөхцөл авагдсан байх (дулаан, цахилгааны эх үүсвэр, цэвэр бохир ус, галын аюулгүй байдал, мэргэжлийн хяналт, улсын байцаагчийн дүгнэлт),
- барилга эхлэх улсын комиссын зөвшөөрөл,

**2. Барилга, байгууламжийн их засвар**

- улсын байцаагчийн дүгнэлт,
- төсөвт өртгийн тооцоо,

**3. Тоног төхөөрөмж, эд хогшил**

- нэр төрөл,
- хүчин чадал,


**4. Зөвлөхийн үйлчилгээ**

- төсөвт өртгийн тооцоо,
- ТЭЗҮ зэрэг болно.

### 2.1.3 Хөрөнгө оруулалтын төсөв боловсруулж, батлах үйл ажиллагааны доголдол

Хөрөнгө оруулалтын төсөв боловсруулах, хэлэлцэн өөрчлөх, эцэслэн батлах үйл явц нь дараах үе шаттайгаар хийгддэг байна (Дүрслэл 2.1).

## Дүрслэл 2.1. Хөрөнгө оруулалтын төсөв боловсруулж, батлах үйл ажиллагааны процесс



Эх үүсвэр: УБАК

Төсөвт байгууллагууд нь хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулахдаа дараах шалгууруудыг харгалзан үздэг. Үүнд:

- ТЭЗҮ боловсруулсан байх,
- Зургийн даалгавар хийгдсэн байх,
- Зураг, төсөв хийгдсэн байх,
- Зураг төсөвт экспертиз хийгдсэн байх,
- Геодезийн зураглал хийгдсэн байх,
- Инженер, геологийн дүгнэлт гарсан байх,
- Тусгай зөвшөөрлийн шаардлага хангасан байх,
- Газрын зөвшөөрөл авсан байх,

Техникийн нөхцөл, мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл (дулааны эх үүсвэр, цахилгаан хангамжийн эх үүсвэр, усан хангамжийн эх үүсвэр, онцгой байдлын дүгнэлт, мэдээлэл холбооны зөвшөөрөл) авсан байх гэх мэт.

НЗДТГ-ын БТХ нь хөрөнгө оруулалтын төсөв боловсруулахдаа дараах зүйлсийг харгалзан үздэг. Үүнд:

- НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр,
- Нийслэлийн тухайн жилийн эдийн засаг нийгмийн төлөвлөгөө,
- Нийслэлийн нийгмийн үйлчилгээний бодит хэрэгцээ (сургууль, төрөх эмнэлэг, цэцэрлэг, авто болон явган хүний, дугуйн зам г.м).

Салбарын яамд, Сангийн яамны түвшинд тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрт багтаах зарчмыг баримтлан, хөрөнгө оруулалтын төсвийг боловсруулдаг.

Үйл ажиллагааны хөтөлбөр, улс орныг хөгжүүлэх эдийн засаг нийгмийн төлөвлөгөө, эрх баригч намын сонгуулийн хөтөлбөрийн зорилгыг үндэслэн Засгийн газар нь хөрөнгө оруулалтын жагсаалтыг боловсруулдаг.

Ийнхүү төсөл, үйл ажиллагаануудыг олон шат дамжлагатайгаар хянан шалгаж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулдаг боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг УИХ-аар хэлэлцэн батлах явцад дээр дурдсан шалгууруудыг хангахгүй төсөл, үйл ажиллагаануудыг нэмэлт өөрчлөлтөөр оруулан батлах тохиолдол гардаг. Жишээлбэл тухайн барилга байгууламж барих төслийн газар нь шийдэгдээгүй эсвэл

ТЭЗҮ хийгдээгүй зэрэг төсөл, үйл ажиллагаанууд батлагддаг. Энэ байдал нь Нийслэлийн ИТХ, Дүүргийн ИТХ-аар төсөв хэлэлцэхэд мөн адилаар давтагддаг байна.

Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх санал, зөвлөмжийг Хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцоог сайжруулах хэсэгт оруулсан болно.

## 2.2 Санхүүжилтийн механизм, эх үүсвэрүүд

Улаанбаатар хот нь Монгол Улсын нийслэл бөгөөд улс орны төрийн удирдлага, засаглал, улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, шинжлэх ухаан, мэдээллийн төв юм. Улс орны бүхий л амьдрал, үйл ажиллагаа энэ хотод төвлөрдөг гэхэд болно. Манай орны тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны гол зангилаа Улаанбаатар хотод оршдог.

### 2.2.1 Улаанбаатар хотын хүн ам

Санхүүжилтийн эх үүсвэр нь хүн амын хэмжээ цаашлаад зах зээлийн хэмжээнээс тодорхой хэмжээгээр хамаарч байдаг. Тиймээс нийслэл хотын хүн амын талаар энд судалж үзэх хэрэгтэй.

Өргөн их уудам нутаг дэвсгэртэй атлаа хүн амынх нь бараг тал хэсэг нь нийслэл хотдоо амьдардаг өөр улс орон үгүй. 1960-аад оны эхээр Улаанбаатар хотод 220-иод мянган хүн оршин сууж байсан бол 2017 оны эхэнд 1380 мянган хүн байнга оршин суудаг хэмээн бүртгэгдсэн нь улсын нийт хүн амын 45 хувийг эзэлж байна (Хүснэгт 2.2).

#### Хүснэгт 2.2. Монгол Улсын хүн ам (мянган хүнээр)

Он	1963	1969	1979	1990	2000	2010	2016
Нийт	1017	1198	1595	2050	2379	2746	3064
Улаанбаатар хот	224	267	402	537	773	1160	1381
Аймгууд	793	931	1193	1515	1606	1586	1683

Эх үүсвэр: ҮСХ, 2017

Энэ нь өнгөрсөн 50 жилийн хугацаанд Улаанбаатар хотын хүн амын тоо даруй 6 дахин өссөн гэсэн үг бөгөөд улсын нийт хүн амын өсөлттэй харьцуулбал 2 дахин илүү хурдтай өсжээ. Улаанбаатар хотын хүн ам ингэж хурдацтай өсөхөд хөдөө орон нутгаас нийслэлд чиглэсэн нүүдэл, шилжилт хөдөлгөөн нэг гол хүчин зүйл болж байна гэхэд болно. 2006-2009 оны хооронд орон нутгаас Улаанбаатар хотод жилдээ дунджаар 30 мянган хүн шилжин ирж байсан нь үүний нэг жишээ юм. Үүнтэй холбоотойгоор 2000 оноос 2010 оны хооронд арван жилийн хугацаанд хөдөө орон нутгийн хүн амын тоо буурч харин хотынх 50 хувиар өссөн байна.

Үүнээс гадна хөдөө орон нутгаас худалдаа наймаа, бизнесийн ажлаар зорчигчид, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуулийн оюутан сурагчид, эмнэлэг, сувиллын үйлчлүүлэгч нар, гадаадын жуулчид зорчигчид гээд тооцвол хотын хүн амын тоо дээрхээс нэлээд өндөр гарах нь ойлгомжтой.

### 2.2.2 Улаанбаатар хотын эдийн засаг

Улаанбаатар хотын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2015 оны байдлаар 15 их наяд төгрөгт хүрсэн нь улсын нийт ДНБ-ий 65 орчим хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын эдийн засгийн хүчин чадлын 65 орчим хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна гэсэн үг (Хүснэгт 2.3). Үүний дотор, сүүлийн 5 жилийн байдлаар боловсруулах үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний 60 хүртэлх хувь, барилгын салбарын 90 хүртэлх хувь, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын 85 хүртэлх хувь, мэдээлэл харилцаа, холбооны салбарын 98 хүртэлх хувь нь Улаанбаатар хотод бүтээгдэн үйлдвэрлэгдэж байна (Хавсралт хүснэгт 4,5,6).

### Хүснэгт 2.3. Монгол Улсын ДНБ-д Улаанбаатар хотын эзлэх хувийн жин, салбараар (хувь)

	2015
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	2.9
Уул уурхай, олборлох үйлдвэр	61.3
Боловсруулах үйлдвэр	54.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	63.5
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент	66.7
Барилга	88.5
Бөөний болон жижиглэн худалдаа	84.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	84.1
Байр, сууц, нийтийн хоол	76.4
Мэдээлэл, холбоо	97.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	72.2
Бүтээгдэхүүний цэвэр татвар	94.4
<b>Дотоодын нийт бүтээгдэхүүн</b>	<b>64.6</b>

Эх үүсвэр: ҮСХ, 2015

Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ДНБ 10,7 сая төгрөг болж байгаа нь улсын дунджаас 45 хувиар өндөр бөгөөд ерөнхийдөө энэ нь хөдөлмөрийн бүтээмж болон улс орны эдийн засагт Улаанбаатар хотын гүйцэтгэж байгаа үүрэг хэчнээн өндөр байгааг нэгтгэн харуулж байна.

Улаанбаатар хотод 2017 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 124 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нь улсын хэмжээнд нийт аж ахуйн нэгжийн 75 хувийг эзэлж байна.

Ийнхүү Улаанбаатар хотын хүн ам болон түр оршин суугчид, зорчигчид, зочин гийчдийн тоо богино хугацаанд огцом хурдацтай өссөн, нөгөө талаас Улаанбаатар хотод улс орны эдийн засаг, нийгмийн гол ачаалал төвлөрч хотын дэд бүтэц, газар, ус болон бусад хангамж, үйлчилгээний хүртээмж, чанарын үзүүлэлтэд тодорхой хүндрэлүүд гарч байна. Энэхүү хэт төвлөрөлттэй холбогдон хотын хөрс, ус, агаарын бохирдол шийдэл болон арга замыг шаардах боллоо. Улсын хөрөнгө оруулалт, олон улсын санхүүгийн байгууллага, гадаад орны зээл тусламж, хувийн бизнесийн хөрөнгө оруулалт, төр болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хотын өмнө тулгарсан олон асуудлыг шийдэж байгаа боловч энэ нь өнөөдөр Нийслэл хотын өмнө тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулах, цаашилбал тавигдаж буй тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чамлалттай байгаа нь тодорхой харагдаж байна. Хүн амын талаас илүү хэсэг нь амьдарч ажиллаж, улсын эдийн засгийн хүчин чадал, шинээр бий болж буй нэмүү өртгийн 60-аас доошгүй хувийг бүтээн гаргаж буй Улаанбаатар хотод цаад агуулгаараа өөрийн хэрэгцээ, хөгжлийн зорилтоо Улсын төсвөөс төдийлөн хамаарахгүйгээр шийдвэрлэх нөөц боломж их бий. Юуны өмнө Улаанбаатар хотын төсөв, санхүүгийн өнөөгийн орчныг авч үзэх шаардлагатай.

### 2.2.3 Улаанбаатар хотын төсөв

Улаанбаатар хотын төсвийн нийт орлого 2016 оны гүйцэтгэлээр нийт 872,9 тэрбум төгрөг, нийт зарлага 961,6 тэрбум төгрөг гарч орлогоос давсан зарлагын хэмжээ 88,7 тэрбум төгрөгт хүрчээ (Хүснэгт 2.4). Энэхүү төсвийн алдагдлыг үндсэндээ өмнөх жилээс дамжин ирсэн дансны үлдэгдлээр нөхсөн гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

**Хүснэгт 2.4. Улаанбаатар хотын төсвийн нэгтгэл (тэрбум төгрөгөөр)**

		2006	2010	2013	2016
Нийт орлого ба тусламжийн дүн		41	164	726	873
	Нийт орлого	35	164	483	554
	А. Урсгал орлого	34	160	483	506
	1. Татварын орлого	24	143	433	506
	2. Татварын бус орлого	8	17	50	47
	Б. Хөрөнгийн орлого	1	4		
	В. Тусламжийн орлого	6		243	319
	1. ОНХС			28	14
	2. Тусгай шилжүүлэг			215	295
Нийт зарлагын дүн		29	103	682	962
	А. Урсгал зардлын дүн	18	66	436	680
	1. Бараа, үйлчилгээний зардал	14	37	350	445
	Цалин ба цалинтай адилтгах	3	12	174	216
	Бусад	11	25	176	229
	2. Татаас ба урсгал шилжүүлэг	4	29	86	235
	Хөрөнгийн зардал	11	74	246	282

Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017


**2.2.3.1 Төсвийн орлого, татварын орлогын байдал, цаашдын хандлага**

Улаанбаатар хотын өнгөрсөн 10 жилийн (2006-2016) төсвийн тоон мэдээллийг үзвэл нийслэлийн нийт орлого ба тусламжийн дүн ихээхэн өссөн бөгөөд үүний дотор 2009 он болон 2013 онд огцом буюу 1.9 болон 2.1 дахин тус бүр өссөн байна (Дүрслэл 2.2).

Үүнд 2009 оны Төсвийн тухай хуулиар хүн амын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварыг орон нутгийн төсөвт шилжүүлснээс хамааран нийслэлийн төсвийн нийт орлогын 14 хувийг бүрдүүлдэг байсан хүн амын орлогын албан татвар 9.3 дахин өсөж нийт орлогын 59 хувийг бүрдүүлдэг болсон байна.

2010 оноос эхлэн санхүүгийн харилцааны хууль эрх зүйн орчныг шинэчлэн, төсвийн бодлогыг макро эдийн засгийн тогтворжуулалтын нэг үндсэн хэрэгсэл болгож төлөвшүүлэх замаар санхүү-төсвийн харилцааны ил тод, оновчтой байдлыг хангаж төсвийн сайн засаглалд шилжсэн юм. Үүнд УИХ-аас 2010 онд баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2011 онд баталсан Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсвийн бие даасан байдлыг илүү хангах эрх зүйн орчин бий болсон, төв болон орон нутгийн төсвийн харилцаанд санхүүгийн дэмжлэг, орлогын болон тусгай зориулалтын шилжүүлгийн механизм хэрэглэх болсон, орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилготой сан бий болгосон зэрэг ихээхэн өөрчлөлтүүд орсон.


### Дүрслэл 2.2: Нийслэлийн нэгдсэн төсвийн орлого, 2006-2016 онд



Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

Мөн 2012 онд төсвийн орлого, зарлагыг шинэ арга, аргачлал, ангиллын дагуу тооцдог болсон зэрэг өөрчлөлтүүдээс хамааран орон нутгийн төсөвт тусгадаг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хөрөнгө худалдсаны орлогуудыг улсын төсөвт төвлөрүүлж, харин улсын төсвөөс ОНХС болон НӨАТ, Орлогын албан татвараас тодорхой хувийг шилжүүлдэг болсон байна. Үүнээс хамааран 2013 онд урсгал орлого 40 хувиар, харин нийт орлого ба тусламжийн дүн 2.1 дахин өссөн байна. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн 10 жилд нийслэлийн төсвийн бүтцэд 3 томоохон өөрчлөлт гарсныг Дүрслэл 2.3-аас харж болно.


### Дүрслэл 2.3: Нийслэлийн нэгдсэн төсвийн бүтцийн харьцуулалт



Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

2006-2008 онд нийслэлийн нийт төсвийн 62 хувийг татварын орлого, 21 хувийг татварын бус орлого эзэлж байсан бол 2009-2012 онд татварын орлого 88 хувь, татварын бус орлого 10 хувь болж татварын орлогын эзлэх хувь өссөн байна. 2009-2012 онд нийт төсвийн 98 хувийг бүрдүүлж байсан урсгал орлого 2013-2016 онд 65 хувь болж буурсан хэдий ч тусламжийн орлого 35 хувьд хүрч өссөн нь нийт төсвийг 2013 онд 2.1 дахин өсгөхөд голлон нөлөөлсөн байна.

**Дүрслэл 2.4: Улсын болон Улаанбаатар хотын дотоодын нийт бүтээгдэхүүн, харьцуулснаар**




Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

**Урсгал орлого.** Урсгал орлого нь татварын ба татварын бус орлогоос бүрдэх бөгөөд дийлэнх хувийг буюу 85-90 хувийг татварын орлого бүрдүүлжээ. Татварын орлого нь сүүлийн 10 жилд дунджаар 40 хувиар өссөн хэдий ч 2009 онд цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг орон нутагт шилжүүлснээс хамааран 2.7 дахин өсөж, 2010-2013 онд эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор тогтвортой 30-50 хувиар (дунджаар 40 хувиар) тус тус өсөж байсан бол сүүлийн жилүүдэд ойролцоогоор 10 хувиар өсөж байна. 2010-2013 онд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өссөн, улмаар уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засаг дунджаар 11.9 хувиар (2011 онд хамгийн өндөр 17.3 хувиар өссөн) өсөж (Дүрслэл 2.4) эдийн засгийн байдал сайжирснаар хүн амын орлого нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Татварын орлогын 60 гаруй хувийг бүрдүүлдэг цалин хөлсний орлогын албан татвар нь 2010-2013 онд хамгийн өндөр буюу дунджаар 40 хувиар өссөн байна. Үүнд тус онуудад улсын дундаж цалин 23 хувиар, Улаанбаатар хотод ажиллагсдын тоо 6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийг 2010 онд шинэчлэн найруулж, хураамжийн хэмжээг өөрчилснөөс хамааран 2011 оны улсын тэмдэгтийн хураамжийн орлого 3.1 дахин өссөн байна. 2013 оны Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр нийслэлийн урсгал орлогод ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн орлогыг тусгадаггүй, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нийслэлд хуваарилдаг болсон хэдий ч нийт татварын орлогын бүтцэд өөрчлөлт гараагүй байна (Дүрслэл 2.5). Бусад татварын орлого болон татварын бус орлогод томоохон өөрчлөлт тус онуудад гараагүй байна.

**Дүрслэл 2.5: Нийслэлийн татварын орлогын бүтцийн харьцуулалт**



Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

Улаанбаатар хотын төсөвт 2016 онд 873 тэрбум төгрөгийн татвар, орлого орсноос 58 хувийг татварын орлого, 5,4 хувийг татварын бус орлого, 36,6 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг бүрдүүлжээ (Хавсралт хүснэгт 7. Улаанбаатар хотын төсвийн татварын орлогын дэлгэрэнгүй судалгаа, 2006-2016).

Хүн амын орлогын албан татвар 352 тэрбум төгрөг болсон нь нийт татварын орлогын 70 орчим хувийг бүрдүүлж байна. Үүнээс, цалин хөлсний орлогын албан татвараар 313,5 тэрбум төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын албан татвараар 25,1 тэрбум төгрөг, хадгаламжийн хүүд ногдуулсан татвараар 4,6 тэрбум төгрөг, хөрөнгө борлуулсан орлогод ногдуулсан татвараар 6,3 тэрбум төгрөг тус тус хотын төсөвт оржээ.

Үл хөдлөх хөрөнгийн татвараар нийт 44,5 тэрбум төгрөг орсон нь нийт татварын орлогын 8,7 хувийг эзэлж байгаа бөгөөд улсын нийт үндсэн хөрөнгийн голлох хэсэг нь байршдаг гэсэн талаас нь харах юм бол энэ нь тийм ч хангалттай байж чадахгүй байна уу гэсэн дүгнэлт хийж болох юм.

Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар 21,8 тэрбум төгрөг болжээ. Улсын хэмжээгээр нийтдээ 800 мянга орчим тээврийн хэрэгсэл байдгийн 70 гаруй хувь нь Улаанбаатар хотод явдаг.

Газрын төлбөрөөр 34,3 тэрбум төгрөг, тэмдэгтийн хураамжаар 35,9 тэрбум төгрөг тус тус хотын төсөвт оржээ. Нийслэл хотын татварыг 2015 оноос эхлэн авч эхэлсэн бөгөөд 2016 онд 3,5 тэрбум төгрөгийг энэ татвараар бүрдүүлжээ.

**Хөрөнгийн орлого.** 2006-2012 онд хөрөнгийн орлого нь нийт орлогын 2-3 хувийг эзэлдэг байсан бол 2013 оны Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон шинэ аргачлалын дагуу хөрөнгө худалдсаны орлогыг татварын орлогын албан татварт бүртгэдэг болсон (Дүрслэл 1-т харууллаа).

**Тусламжийн орлого.** УИХ-аас 2011 онд шинэчлэн баталсан Төсвийн тухай хуулиар төв болон орон нутгийн төсвийн харилцаанд санхүүгийн дэмжлэг, орлогын болон тусгай зориулалтын шилжүүлгийн шинэ механизм хэрэглэх замаар орон нутгийн төсөв санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чухал шинэчлэлийг хийсэн. Энэхүү шинэчлэл нь 2013 оны нийслэлийн төсөвт бүрэн хэрэгжиж эхэлснийг Хавсралт хүснэгт 4-ээс дэлгэрэнгүй харж болно. 2013 оны нийслэлийн төсвийг Засгийн газраас 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”-ын дагуу боловсруулан баталж, тайлагнасан.

Орон нутгийн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор 2013 оноос Төсвийн тухай хуульд заасны дагуу суурь зардалд тусгаж тооцогдох чиг үүргүүдийг (Төсвийн тухай хуулийн 58.1.1, 58.1.4, 58.1.14 дүгээр зүйл) оруулан, орон нутгийн төсвийн нийт орлого, суурь орлого болон суурь зардлуудад үндэслэн санхүүгийн дэмжлэгийн шилжүүлгийг тооцоолж эхэлсэн. Мөн Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг санхүүжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу аймаг, нийслэлийн төсөвт тусгай зориулалтын шилжүүлгийг тусгадаг болсон.

Эдгээр эрх зүйн зохицуулалтаас хамааран 2013 оноос нийслэлийн төсөвт Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг, ОНХНС-ийн шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, НӨАТ, Орлогын албан татварын тодорхой хувийн шилжүүлэг гэсэн ангиллын дагуу жилд дунджаар 280 гаруй тэрбум төгрөг шилжүүлж байгаа нь нийт орлого ба тусламжийн 35 хувийг эзэлж байна. Нийт тусламжийн орлогын дийлэнх хувийг буюу 90 гаруй хувийг тусгай зориулалтын шилжүүлэг эзэлж байгаа бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол
- Ерөнхий боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Газрын харилцаа
- Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээ
- Нийтийн бие тамир



Энэхүү тусгай зориулалтын шилжүүлэг нь 2013-2016 онд дунджаар 11 хувиар өссөн нь нийслэлийн хүн амын өсөлт, хүн ам зүйн өөрчлөлттэй холбоотой байна.


Татварын бус орлогоор 2016 онд нийт 47,2 тэрбум төгрөг хотын төсөвт орсноос голлох хэсгийг хүү, торгуулийн орлого эзэлж байна. Нийслэл, Улаанбаатар хотын төсвийн орлогын тоо мэдээллийг Хавсралт хүснэгт 9-аас дэлгэрэнгүй харж болно.

### 2.2.3.2 Төсвийн зарлага

Төсвийн тухай хууль, Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль зэрэг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжид тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс нийслэл хот 2016 онд 961.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Нийт зарлагын дүн нь урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэнэ. Нийт зарлагын дүнд урсгал зарлагын эзлэх хувь 2006-2012 онд харьцангуй хэлбэлзэлтэй байсан бол 2013 оноос ойролцоогоор 70 хувийг эзэлж байна (Дүрслэл 2.6). Нийслэлийн нийт урсгал зардал нь 2006-2012 онд хүн амын өсөлт, цалин хөлсний өсөлт, захиргааны удирдлага, эдийн засгийн хөгжлөөс хамааран жил бүр тогтмол өсөж (жилд дунджаар 30 орчим хувиар) байсан. Харин хөрөнгө оруулалтын зардал нь орон нутгийн эдийн засгийн бүтэц, төрийн үйлчилгээнээс хамааран харьцангуй өөрчлөгдөж байсан нь нийт зарлагын бүтцийн өөрчлөлтөд ихээхэн нөлөөлсөн байна.

#### Дүрслэл 2.6. Нийт зарлагын бүтцийн харьцуулалт, 2006-2016 онд



Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

**Урсгал зардал.** Нийслэл хотын урсгал зардал 2006-2012 онд дунджаар 30 хувиар өсөж байсан бол 2013 онд 4.7 дахин өссөн байна. Харин сүүлийн жилүүдэд ойролцоогоор тогтмол 20 хувиар өсөж байна. 2013 онд урсгал зардал 4.7 дахин өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- 2012 онд цалин дунджаар 53 хувиар, тэтгэврийн доод хэмжээ 71.2 хувиар, халамжийн тэтгэвэр 1.9 дахин өссөн.
- 2013 онд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй байгууллагын тоо болон ажиллагчдын тоо 7 дахин өссөн.
- Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3.4 дэх заалтаар нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасны дагуу 2013 онд татаас ба урсгал шилжүүлгийн ангилалд халамжийн сан хэмээх зардал нэмэгдэж 72.7 тэрбум төгрөг зарцуулсан. Энэхүү зардал нь сүүлийн жилүүдийн нийт урсгал зардлын ойролцоогоор 15 хувийг эзэлж байна.
- 2012 оноос эхлэн хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн хүрээнд 0-18 нас хүртэлх хүүхдэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмж олгож эхэлсэн.
- Хөрөнгийн зардлын дотор орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварын ажил 2013 онд өмнөх оноос 80 хувиар огцом өссөн зэрэг голлох өөрчлөлтүүд нөлөөлсөн байна.


Урсгал зардлын дийлэнх буюу 70 гаруй хувийг бараа, үйлчилгээний зардал эзэлдэг хэдий ч 2011 болон 2012 онд хотын нийтийн тээврийн татаас 43.9 дахин буурснаас хамааран 94 хувь болж өссөн байна (Дүрслэл 2.7). 2012 оноос өмнө цалин хөлс, түүнтэй адилтгах зардал болон ажил олгогчийн НДШ нь нийт урсгал зардлын 20 гаруй хувийг эзэлдэг байсан бол 2012 онд цалин дунджаар 53 хувиар, тэтгэврийн доод хэмжээ 71.2 хувиар, халамжийн тэтгэвэр 1.9 дахин өссөн нь 2013 оны цалин, түүнтэй адилтгах зардалд нөлөөлж бараа үйлчилгээний зардлыг 4 дахин нэмэгдүүлсэн бөгөөд урсгал зардлын 40 гаруй хувийг бүрдүүлдэг болсон байна. Бараа үйлчилгээний бусад зардал буюу захиргааны зардлын хувьд нийт урсгал зардлын 30-40 хувийг эзэлдэг бөгөөд үүнд гудамж талбайн гэрэлтүүлэг болон цэвэрлэгээ, түлш халаалт, хог хаягдлыг устгах цэвэрлэх зардал, байгаль хамгаалал, газрыг нөхөн сэргээх үйл ажиллагааны зардал зэрэг нь голлон багтаж байна. Энэ нь 2011-2012 онд татаас ба урсгал шилжүүлгийн бууралтаас хамааран нийт урсгал зардлын 69 хувийг эзэлж байсан.

Улаанбаатар хотын төсвийн зарлага 2016 онд 961,6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 70 гаруй хувь буюу 679,6 тэрбум төгрөгийг урсгал төсвийн зарлага эзэлж байна (Хавсралт хүснэгт 8. Улаанбаатар хотын төсвийн зарлага, санхүүжилтийн дэлгэрэнгүй судалгаа, 2006-2016).

Бараа, ажил үйлчилгээний зардал 445,3 тэрбум төгрөг болсон нь урсгал төсвийн зарлагын 65,5 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн хэсгийг нийт 234 гаруй тэрбум төгрөгийн татаас, шилжүүлэг бүрдүүлж байна.

2016 оны байдлаар Улаанбаатар хотын төсвөөс санхүүждэг 497 төсөвт байгууллагад нийтдээ 17,710 албан хаагчид ажиллаж байна. Эдгээр байгууллага, албан хаагчдын нийт цалингийн сан, цалинтай адилтгах (нийгмийн даатгалын шимтгэл, үр дүнгийн болон унааны нэмэгдэл гм) бусад зардлын хэмжээ 216 тэрбум төгрөг болж байгаа нь хотын нийт төсвийн 20 гаруй хувь, нийт урсгал зардлын 30 гаруй хувь, нийт бараа, ажил үйлчилгээний зардлын 50 гаруй хувийг эзэлж байна.

### Дүрслэл 2.7: Нийслэлийн урсгал зардлын бүтцийн харьцуулалт, 2006-2016 онд



Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

Гэрэл цахилгаан, халаалт, цэвэр, бохир усны зардал зэрэг тогтмол зардал 28 тэрбум төгрөг байгаа нь цалингаас бусад бараа, ажил үйлчилгээний зардлын 15 орчим хувийг эзэлж байна. Хог хаягдал устгах, цэвэрлэх зардал болон төлбөр хураамжид тус тус 40 орчим тэрбум төгрөг, хоолны зардалд 20-иод тэрбум төгрөг, урсгал засварт 7,3 тэрбум төгрөг зарцуулсан нь томоохон зардлууд болж байгаа ажээ.


**Хөрөнгийн зардал.** Хөрөнгийн зардал нь орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварын ажил болон замын сангийн хөрөнгө оруулалт, их засварын зардлаас бүрддэг бөгөөд дийлэнх хувийг орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварын ажлын зардал эзэлдэг. Түүнчлэн орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварын ажлын зардал 2011 онд 4.4 дахин, 2013 онд 1.7 дахин нэмэгдсэн байна. Нийслэлд төвлөрдөг тээврийн хэрэгслийн татвар нь замын хураамжаас бүрддэг бөгөөд шинээр зам барих, нөхөн сэргээх гэх мэт хөрөнгийн зардлыг санхүүжүүлдэг.

2016 онд Улаанбаатар хотын төсвийн 30 орчим хувийг буюу 282 тэрбум төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварт зарцуулжээ.

**Нийт төсвийн тэнцэл.** Сүүлийн 10 жилийн төсвийн гүйцэтгэлийг шинжилж үзвэл нийслэлийн төсөв 2014 оноос өмнө үндсэндээ орлого нь зарлагаасаа давсан буюу ашигтай (2011 онд 21.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байснаас бусад) гардаг байжээ. Төсвийн шинэчлэл хийхээс өмнө буюу 2013 оноос өмнөх төсвийн тэнцлийг авч үзвэл 2009 онд нийслэлийн төсвийн ашиг нь нийт орлого ба тусламжийн нийт дүнгийн 50 хувьтай тэнцэж байсан нь хамгийн өндөр, харин 2007 онд 10 хувьтай тэнцэх хэмжээнд байсан нь хамгийн бага үзүүлэлт болж байжээ (Дүрслэл 2.8).

Харин 2011 онд хөрөнгийн зардал өмнөх онтой харьцуулахад 4.4 дахин өссөнөөс шалтгаалан 21.2 тэрбум төгрөгийн буюу 9 хувийн алдагдалтай байсан байна. 2013 оноос эхлэн төсвийн тэнцлийн ашиг жил тутам буурсаар 2016 онд 10 хувийн алдагдалд хүрсэн байна. Энэ нь сүүлийн жилүүдийн хүн амын өсөлт, захиргааны зардал, өсөн нэмэгдэж буй нийтийн үйлчилгээний зардал болон эдийн засгийн агшилтаас уялдсан орлогын бууралтаас ихээхэн хамаарч байна. Өмнөх онуудад төсвийн ашиг өндөр гарахад орлогын огцом өсөлт (2008 болон 2010 он) болон зарлага санхүүжилт төлөвлөснөөс багаар (2007, 2010-2016 он) гарч хэмнэгдэж байсан нь голлон нөлөөлжээ. Татвар хураамжийн орлого оны төгсгөл рүү илүүтэй орж, төсвийн орлогын урсгал нь зардал, санхүүгийн хэрэгцээтэй тэр бүр уялдаж чаддаггүйн улмаас зарим төсөл, арга хэмжээг тэр бүр ондоо багтаан бүрэн санхүүжүүлж амждаггүй байдал ч тодорхой нөлөө үзүүлдэг болохыг энд тэмдэглэх нь зүйтэй юм.

## Дүрслэл 2.8: Нийслэлийн төсвийн үндсэн үзүүлэлтүүд харьцуулснаар, 2006-2016 он



Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

**Дүгнэлт.** 2011 оны эцсээр шинэчлэн батлагдсан Төсвийн тухай хуулиар зарим салбарын төсөвт байгууллагуудыг хотын төсвөөс санхүүжүүлэхээр хуваарилсан, үүний эх үүсвэрт зориулж зарим эх үүсвэр болон шилжүүлгийг Улсын төсөвт хотоос татаас, шилжүүлгийн байдлаар шилжүүлэх болсонтой холбогдуулан хотын төсвийн хэмжээ 2006-2012 он хүртэлх хугацаанд байсан төсвөөс их хэмжээгээр нэмэгдсэн байна. Харин ийнхүү нэг талаас харахад төсвийн мөнгөн хэмжээ их хэмжээгээр нэмэгдсэн боловч, хотын төсвийн чанарын үзүүлэлт төдийлөн сайжирсангүй гэж дүгнэж болохоор байна. Өмнөх жилүүдэд хотын төсвийн орлого зарлагаасаа 40-60 хувиар давж, үлэмж хэмжээний төсвийн ашигтай гардаг, гэхдээ энэхүү давсан орлогыг хотын мэдэлд үлдээхгүйгээр дээд шатны төсөвт дайчлан хураадаг байсан. 2013 онд Улаанбаатар хотын төсвийн ачааллыг үлэмж нэмэгдүүлсэн боловч татвар, өөрийн орлогын эх үүсвэр дээр дүйцэх эрх мэдлийг Улаанбаатар хотод шилжүүлээгүй гэхэд болно. Үүнтэй холбогдуулан хотын төсвийн тэнцвэржилт төдийлөн сайнгүй, хотын орон нутгийн татварын хууль эрх

зүйн орчин болон бусад нэмэгдэл эх үүсвэрийн асуудлыг хөндөхгүйгээр хотын өмнө тулгарч буй шийдэл нэхсэн асуудлууд, хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх боломж бага байгаа юм.

Улаанбаатар хотод Монгол улсын эдийн засгийн үйл ажиллагааны талаас илүү хувь нь явагддаг ч Монгол улсын татварын орлого бүрдүүлэх төвлөрсөн тогтолцоо нь Улаанбаатар хот, төвлөрүүлж болох татварын орлогодоо түшиглэн төрийн үйлчилгээний хангамжийг бие даан санхүүжүүлэх бололцоог хязгаарлаж байна.

### 2.2.3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

2016 онд Улаанбаатар хотын төсвөөс нийт 282 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь төсвийн нийт зарлагын 30 орчим хувийг эзэлж байна.

Улаанбаатар хотын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт нь гол төлөв бага, дунд сургуулийн цогцолбор шинээр барих, сургууль, цэцэрлэгийн завсар үйлчилгээ, эмнэлэг, эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийн засвар, тоног төхөөрөмж, зам гүүрний засвар, хот тохижуулалт, инженерийн шугам сүлжээ, дулааны шугамын ажил, өргөтгөл, бохир усны коллектор, шинэчлэлийн ажил, үерийн хамгаалалтын далан, ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээ, өндөр хүчдэлийн шугам, дэд өртөө зэрэг арга хэмжээнд зарцуулагдсан байна.

Ер нь Улаанбаатар хотын төсвийн нийт дүнд эзлэх хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх жилүүдэд 40 орчим хувь байсан бөгөөд харин 2016 онд 30 орчим хувь болж 10 орчим нэгжээр буурсан байдал харагдаж байна (Хүснэгт 2.5). Энэ нь нэг талаас харвал харьцангуй өндөр мэт байгаа боловч үргэлж өсөн нэмэгдэж байгаа хотын хэрэгцээтэй харьцуулбал үндсэндээ өнөөдрийн шаардлагыг хангахгүй байна.

#### Хүснэгт 2.5. Улаанбаатар хотын төсвийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг)

	2006	2010	2013	2016
Улаанбаатар хотын нийт төсвийн зардал	29	104	682	962
Үүнээс, хөрөнгө оруулалт	11	38	246	282
Хувийн жин (%)	38	37	36	29

Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

Улаанбаатар хотод хийгдэж буй хөрөнгө оруулалтыг бүрэн зургаар нь харахын тулд Орон нутгийн хөгжлийн сан, Улсын төсөв болон Засгийн газрын шугамаар авч буй гадаадын зээл тусламж, мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын байдлыг авч үзэх зайлшгүй шаардлагатай.

Улаанбаатар хот, нэн ялангуяа хотын дүүргүүдийн хувьд Улсын төсвөөс олгож буй Орон нутгийн хөгжлийн сан ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж ирснийг юуны өмнө тэмдэглэх шаардлагатай.

### 2.2.3.4 Орон нутгийн хөгжлийн сан

2011 оны сүүлчээр шинэчлэн батлагдсан Төсвийн тухай хуульд Орон нутгийн хөгжлийн сан болон энэхүү сангийн хөрөнгийг захиран зарцуулахдаа иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх цоо шинэ зарчим тусгалаа олсон билээ.

Орон нутгийн хөгжлийн сан (цаашид “ОНХС” гэх)-г хүн амын тоо, төвөөс алслагдсан байдал болон нутаг дэвсгэрийн хэмжээ, татварын идэвх санаачилга, орон нутгийн хөгжлийн индекс гэсэн цөөн хэдэн үзүүлэлтийг үндэслэн томьёонд тулгуурлан хуваарилж байхаар Төсвийн тухай хуульд заажээ. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр өөрийн бие даасан ОНХС-тай байх зарчмыг тогтоосон.

Мөн эх үүсвэрийг тодорхой байлгах үүднээс Дотоодын Нэмэгдсэн өртгийн албан татварын 15 хувь (Төсвийн тухай хуульд сүүлд орсон өөрчлөлтүүдээр энэхүү хувь нь 10 болон 5 хувь болон тус тус буурсан), Ашигт малтмалын нөөцийн татварын 5 хувийг ОНХС-д төвлөрүүлж байхаар заасан болно.

Төсвийн тухай хуулийн ОНХС-тай холбоотой хэсэг 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. 2013 оноос хойш өнгөрсөн 4 жилийн хугацаанд нийт 600 гаруй тэрбум төгрөгийг дээрх эх үүсвэрүүдээс төвлөрүүлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-уудад хэн нэгэн дарга, хүнд сурталтны оролцоогүйгээр томьёонд тулгуурлан шууд хуваарилжээ (Хүснэгт 2.6).

2013 оноос өмнө аймгуудын өөрийн төсвөөр хийж байсан хөрөнгө оруулалтын хэмжээ жилдээ дунджаар 0,4-2,4 тэрбум төгрөгийн хэмжээнд л байсан бөгөөд дүүрэг болон сум өөрөө мэдэж төсвөөрөө хийдэг хөрөнгө оруулалт гэж бараг байдаггүй байсныг энд тэмдэглэх нь зүйтэй байх.

### Хүснэгт 2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн судалгаа, 2013-16 он (сая төгрөг)

		2013	2014	2015	2016
1	Дотоодын НӨАТ*(15%, 10%, 5%)	141,059	121,387	74,578	46,624
2	АМНАТ*5 хувь	22,159	19,160	19,247	14,436
3	Аймаг орон нутаг хооронд дахин хуваарилах	24,247	52,839	6,302	16,142
4	Бусад			5,858	43,066
	<b>Нийт</b>	<b>187,465</b>	<b>193,386</b>	<b>105,985</b>	<b>120,268</b>

Эх үүсвэр: Сангийн яам, 2017

ОНХС хэрэгжиж эхэлснээр 2013 онд гэхэд л аймгуудын өөрийн хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх жилүүдийнхээс дунджаар дөрвөөс тав дахин нэмэгдсэн байна. Дүүргүүд 2-3 тэрбум төгрөг, сумууд 300-700 сая төгрөгийг ОНХС-даа хүлээн авч иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлсэн байна. ОНХС-ийн зарцуулалтыг Улаанбаатар хот болон аймаг тус бүрээр харуулав (Хүснэгт 2.7).

### Хүснэгт 2.7. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, 2013-16 он (сая төгрөг)

		2013	2014	2015	2016
1	Архангай	8,123.55	8,039.01	4,189.90	3,179.92
2	Баян-Өлгий	7,063.16	6,936.01	3,816.35	3,260.14
3	Баянхонгор	9,605.80	9,482.86	4,898.21	4,737.82
4	Булган	6,482.85	6,864.63	3,588.90	3,550.47
5	Говь-Алтай	8,504.29	9,649.87	4,732.12	5,693.66
6	Дорноговь	7,616.54	7,435.35	3,935.72	5,579.86
7	Дорнод	7,804.42	8,379.19	4,282.91	4,140.61
8	Дундговь	7,187.66	7,390.90	3,777.76	4,114.72
9	Завхан	7,857.49	7,557.39	4,006.82	4,185.77
10	Өвөрхангай	8,330.28	9,350.24	4,615.83	3,444.38
11	Өмнөговь	8,317.51	9,371.97	4,674.85	21,515.02

12	Сүхбаатар	8,364.63	7,696.54	4,012.46	7,681.16
13	Сэлэнгэ	6,666.87	6,634.30	3,709.66	4,887.34
14	Төв	6,924.13	6,922.90	3,817.06	6,300.92
15	Увс	7,517.68	7,774.41	3,890.91	3,040.62
16	Ховд	7,910.83	8,095.38	4,338.43	3,664.06
17	Хөвсгөл	8,161.82	8,927.22	4,573.20	3,395.60
18	Хэнтий	8,262.50	8,445.58	4,094.76	4,417.19
19	Дархан-Уул	6,543.64	6,096.25	3,535.53	3,295.29
20	Нийслэл	27,766.29	32,137.59	20,960.00	14,393.66
21	Орхон	7,015.29	6,774.44	3,812.30	3,562.03
22	Говьсүмбэр	5,438.18	5,424.98	2,721.16	2,227.42
	<b>Нийт</b>	<b>187,465.41</b>	<b>195,387.00</b>	<b>105,984.83</b>	<b>120,267.69</b>

Эх үүсвэр: Сангийн яам, 2017

Улаанбаатар хотод Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар өнгөрсөн 4 жилийн хугацаанд олон чухал төсөл арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдаг. Доорх Хүснэгт 2.8-аас Орон нутгийн хөгжлийн сангийн ерөнхий зориулалтыг 2013 оны жишээгээр харж болох юм.

Улсын төсвөөс Улаанбаатар хот болон дүүргүүдийн Орон нутгийн хөгжлийн санд 2013 онд нийт 27,8 тэрбум төгрөгийн хөрөнгө хуваарилсан бөгөөд энэхүү хөрөнгө оруулалт, санхүүжилтээр нийт 406 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлжээ. Хороодын хэмжээнд иргэдийн саналыг авч нэгтгэх замаар хэрэгцээг тодруулсны дагуу цэцэрлэгт хүрээлэн байгуулах, зүлэгжүүлэх болон мод тарих, гудамж талбай тохижуулах, хүүхдийн тоглоомын талбай, үүний дотор сагсны талбай байгуулах зэрэг хот тохижуулах зориулалтаар 170 орчим төсөл хэрэгжүүлэхэд 23,8 тэрбум төгрөг зарцуулсан нь нийт санхүүжилтийн 85 хувийг эзэлжээ. Мөн гудамж, талбай, нэн ялангуяа гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийн 100 төсөл хэрэгжүүлж 5 тэрбум төгрөг зарцуулжээ. Гэр хороолол, хашааны явган болон авто зам, гүүр тавих, хатуу хучилт тавих, хавтанжуулах зэрэг замын ажлын нийт 84 төсөл хэрэгжүүлж, үүнд 4,3 тэрбум төгрөг зарцуулжээ. 4-5 жилийн өмнө “харанхуй” хот гэгдэж байсан Улаанбаатар хот, нэн ялангуяа гэр хороолол үндсэндээ Орон нутгийн хөгжлийн сангийн “буян”-д шөнөдөө гэрэл гэгээтэй болсон гэж болно.

## Хүснэгт 2.8. Улаанбаатар хот болон дүүргүүдийн орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын судалгаа, 2013 он (сая төгрөгөөр)

		2013
Төслийн тоо		406
Төлөвлөсөн санхүүжилт		35030
Гүйцэтгэл		27766
Замын ажил		
	Төслийн тоо	84
	Гэрээний дүн	5157
	Санхүүжилт	4306
Гэрэлтүүлэг		
	Төслийн тоо	100
	Гэрээний дүн	9588
	Санхүүжилт	4990
Хот тохижилт, тоглоомын талбай		
	Төслийн тоо	168
	Гэрээний дүн	23823
	Санхүүжилт	15696

Эх үүсвэр: Нийслэлийн ЗДТГ, Төрийн сан, 2017

Орон нутагт олон жилийн туршид шийдэл байхгүй хуримтлагдаж ирсэн бэрхшээлтэй асуудлуудыг шийдэх гарцыг ОНХС олж өгсөн. ОНХС-ийн ач буянаар хөдөө орон нутаг, нэн ялангуяа аймаг, сумын төвүүдийн нүүр царай сүүлийн хэдхэн жилийн дотор огцом сайжирсан гэхэд болно. Хэдхэн жилийн өмнө тас харанхуй байсан олон суурин газар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гэрэл гэгээтэй болсон. Улсын хэмжээнд хийгдсэн гудамжны гэрэлтүүлэг бүхэлдээ ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн гэхэд болно. Иргэдийн амьдрах орчныг сайжруулах, тав тухыг хангахад ОНХС ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Эдгээр арга хэмжээний үр дүнд иргэдийн эд хөрөнгө, хашаа байшингийн үнэ цэнэ нэмэгдсэн талаар иргэд ярьж хэлдэг.

Статистикийн мэдээнээс үзэхэд ОНХС хэрэгжиж эхлэхээс өмнө Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас жилд дунджаар 30,4 мянган хүн шилжин ирж байсан бол энэ үзүүлэлт 2016 он гэхэд бараг 20 хувь буюу 5 мянган хүнээр буурчээ. Улаанбаатар хотоос буцаж хөдөө орон нутагт шилжиж байгаа иргэдийн тоо 40 орчим хувиар нэмэгджээ. Энэ хугацаанд цэвэр шилжилт 2 дахин буурчээ (Хүснэгт 2.9). Энэ бол ОНХС-ийн бодит үр дүн гэж дүгнэж болох юм. Үүнийг дагаад нийгмийн болон хувь хүний амьдралд олон эерэг үр дүн гарч байгаа нь ойлгомжтой.

## Хүснэгт 2.9. Шилжилт хөдөлгөөний мэдээлэл, Улаанбаатар хот, сүүлийн 10 жилээр

	Шилжин ирсэн	Шилжин явсан	Цэвэр шилжилт
2007-14 оны жилийн дундаж	30,392	10,493	19,899
2015	30,297	11,702	18,595
2016	25,196	14,342	10,854

Эх үүсвэр: ҮСХ, 2017

### 2.2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэхэд Улсын төсөв байнга чухал ач холбогдолтой явж ирсэн.

Доорх хүснэгтийн 2010-2014 оны хөрөнгө оруулалтын тоо мэдээг Улаанбаатар хотын Хөрөнгө оруулалтын газраас, харин 2015-2016 оны тоо мэдээг Сангийн яамнаас авсан болно (Хүснэгт 2.10).

2016 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод нийт 117 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, нийт 154 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

2010 оноос хойш сүүлийн 6 жилийн хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод нийт 1100 орчим төсөл хөтөлбөр хэрэгжүүлжээ.

Эмнэлэг, сургууль шинээр барих, эмнэлэг, сургууль цэцэрлэгийн их засвар, улсын чанартай зам тавих, засаж сайжруулах, инженерийн дэд бүтцийг шинээр байгуулах, байгааг нь өргөтгөн шинэчлэх, цахилгааны болон дулааны шинэ шугамууд барих, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, инженерийн хийцтэй худаг, төрийн албан хаагчид, ахмадууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэх зэрэг арга хэмжээ үндсэндээ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод 2010 оноос хойш (PS.2013 он ороогүй) эрүүл мэндийн салбарт нийт 104 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, нийт 31 тэрбум төгрөг зарцуулжээ. Мөн боловсролын салбарт 357 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, нийт 51 тэрбум төгрөг зарцуулсан байна. Улаанбаатар хотын улсын чанартай замын сүлжээг өргөтгөх, нэмэгдүүлэх, зам, гүүр шинээр барих арга хэмжээнд Улсын төсвөөс 67 төсөлд нийт 93 тэрбум төгрөг зарцуулсан болно.

## Хүснэгт 2.10. Улсын төсвөөс Улаанбаатар хотын төсөвт шилжүүлсэн болон Улаанбаатар хотод хийсэн хөрөнгө оруулалтын судалгаа (сая төгрөг)

	2010	2011	2012	2014	2015	2016
<b>Төслийн тоо</b>	151	297	227	118	176	117
<b>Төслийн нийт төсөвт өртөг</b>	126,740	113,733		55,845	714,070	538,392
<b>Төлөвлөсөн санхүүжилт</b>	42,848	92,183	67,635	33,533	285,709	154,027
<b>Гүйцэтгэл</b>	41,140	63,883	64,726	17,292	272,274	144,050
<b>Эрүүл мэндийн салбарт</b>						
Төслийн тоо	21	19	31	17	10	6
Санхүүжилт	5,217	2,802	10,086	6,181	2,908	3,891
<b>Боловсролын салбарт</b>						
Төслийн тоо	45	116	92	56	30	18
Санхүүжилт	6,160	5,154	2,765	10,037	20,069	7,296
<b>Замын ажил</b>						
Төслийн тоо	16	25	9		10	7
Санхүүжилт	15,119	49,365	1,321		17,548	9,521

Эх үүсвэр: Сангийн яам, Нийслэлийн ЗДТГ, ХОГ, 2017

Сүүлийн жилүүдэд Улсын төсвөөс Улаанбаатар хотын цахилгаан хангамж, хүрэлцээг сайжруулах асуудалд ихээхэн ач холбогдол өгч байна. Тухайлбал, 2015 онд энэ зориулалтаар нийт 28 төсөл арга хэмжээнд 120 тэрбум төгрөг, 2016 онд 10 төсөл, арга хэмжээнд 38 тэрбум төгрөг зарцуулжээ.

### 2.2.5. Гадаадын зээл, тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалт


**Хөгжлийн албан ёсны тусламж.** Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Япон Улс, БНХАУ, ХБНГУ зэрэг орнуудын хөтөлбөр, төсөл, зээл тусламж манай орны эдийн засаг, нийгмийн хөгжилд үнэлж баршгүй ач холбогдолтой билээ.

Дүрслэл 2.9-д харуулснаар Улсын төсвийг санхүүжүүлэх зорилгоор олгодог ХАЁТ-ийн гадаад санхүүжилт сүүлийн арав гаруй жилд буурсан байна. Нийт хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж буюу



улсын салбарт олгох ХАЁТ-ын хэмжээний ДНБ-д эзлэх хувь 2007 онд 8 хувьтай байсан бол 2014 онд 3 хувь хүртэл буурч 2016 онд 4 хувь хүрч нэмэгдсэн байна. Нэг хүнд оногдох ХАЁТ-ын хэмжээ 2007 онд 164 ам.доллараас 2014 онд 117 болж буурч, 2017 онд 165 ам.долларт хүрэх төлөвтэй байна.<sup>2</sup>

## Дүрслэл 2.9. ДНБ-д эзлэх Засгийн газрын нийт ХАЁТ ба нэг хүнд ногдох хэмжээ, ам доллароор, 2015 оны тогтмол үнээр



Эх үүсвэр: СЯ, ХАЁТ-ийн төсөл.

Улсын салбарын ХАЁТ-ын хэмжээнд Монгол Улсын 2013 он хүртэлх эдийн засгийн өндөр өсөлт болон Герман, Япон зэрэг хөгжлийн чухал түншүүд нь ХАЁТ-ийн хэмжээгээ бууруулсан нь нөлөөлсөн байна. Улсын нийт өр төлбөрийн өнөөгийн өндөр түвшнийг харгалзан үзвэл ХАЁТ-ийг дайчлах Засгийн газрын нэгдсэн стратеги дутагдалтай байгааг харуулж байна. Мөн түүнчлэн, хөгжлийн хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор хөгжлийн санхүүгийн байгууллагаас эсвэл даян дэлхийн хөтөлбөр/сан зэргээс олгосон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр санхүүжих ХАЁТ-ын санхүүжилтэд үнэлгээ хийж цаашдын бодлого, стратеги гаргахын оронд Засгийн газраас арилжааны нөхцөлөөр төсвөөс гадуур зээл олгож санхүүгийн байдлаа дордуулсан байна гэжээ.<sup>3</sup>

Улаанбаатар хотын хувьд авч үзье. Сүүлийн 25 жилийн хугацаанд эдгээр олон улсын санхүүгийн байгууллагууд болон хандивлагч орнуудаас Засгийн газрын шугамаар авсан зээл тусламжийн хүрээнд Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын олон чухал төсөл, хөтөлбөр, арга хэмжээ амжилттай хэрэгжиж ирлээ.

Улаанбаатар хотын цахилгаан болон дулаан, цэвэр усны хангамж хүрэлцээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх, орон сууцны хорооллуудыг барих, зам гүүр шинээр барих, шинэчлэх, явган гарцыг өргөтгөх, нийтийн тээврийг хөгжүүлэх зэрэгт Засгийн газрын шугамаар авсан зээл, тусламж онцгой үүрэг гүйцэтгэж байгаа билээ. Үүнийг 2017 онд жишээгээр Хүснэгт 2.11-ээс харахад л хангалттай юм.

2017 онд Дэлхийн банкнаас Улаанбаатар хотын цэвэр агаар төслийн хүрээнд 3,5 тэрбум төгрөг, Азийн хөгжлийн банкнаас Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл, Нийслэлийн хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслүүдэд 10 тэрбум төгрөг, БНХАУ-аас Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах, Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр барих 2 төсөлд нийт 14 тэрбум төгрөг, Австри улсаас Улаанбаатар хотын цэвэр, бохир усны хоолойг шинэчлэх технологийг нэвтрүүлэх

<sup>2</sup> Нийт ХАЁТ нь улсын секторт олгосон ХАЁТ-ийн хэмжээ юм. Тоо мэдээлэл дутмагаас болж ТББ-д олгосон ХАЁТ ороогүй.

<sup>3</sup> Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ

төсөлд 6 тэрбум төгрөг тус тус хөрөнгө оруулалтын санхүүжилт олгох юм. Мөн БНХАУ-аас Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл, Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн төслүүдийг шинээр эхлэх болно.

### Хүснэгт 2.11. Гадаадын зээл, тусламжийн хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжих төслийн 2017 оны санхүүжилт (сая төгрөг)

Төслийн нэр	Зээлдэгч	2017
Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл	ДБ	3,520
Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл (шинээр)	БНХАУ	
ADF-АХБ, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	АХБ	829
OCR-АХБ, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	АХБ	3,187
Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	ЕХОБ	3,143
Улаанбаатар хотын цэвэр, бохир усны хоолойг шинэчлэх технологийг нэвтрүүлэх төсөл	Австри	6,300
Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл	БНХАУ	8,596
Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлт (шинээр)	БНХАУ	
Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр барих төсөл	БНХАУ	5,288
Нийслэлийн хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл -2	АХБ	6,213
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн нийт дүн		<b>37,076</b>

Эх үүсвэр: Сангийн яам, 2017

Эдгээр олон талт санхүүгийн байгууллагууд нь хотын дэд бүтцийн хөгжилд зориулан Засгийн газарт зээл олгоходоо ихэвчлэн төслийн техник-эдийн засгийн судалгаа хийх, төрийн байгууллагын ажилтнуудын сургалт зэрэг чадавх хөгжүүлэх хөтөлбөр, тендерийн үйл ажиллагааг зохион байгуулахад зөвлөгөө өгөх зорилгоор тусламжуудыг олгодог. Эдгээр санхүүгийн байгууллагууд нь дэлхийн болон бүс нутгийн туршлагатай, дэд бүтцийн хөгжлийн шинэ, үүсэж буй хандлагуудыг сайн мэддэг мэргэжилтнүүдтэй байдаг тул Улаанбаатар хотын захиргаа нь дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэхэд тэднийг оролцуулж, туршлага судлах, зөвлөгөө авах үйл ажиллагаагаа улам өргөжүүлэх боломжтой юм.

#### 2.2.6 Улаанбаатар хотын орон нутгийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгийн удирдлага

Нийслэлийн иргэдийн эрүүл энх аж төрөх, өдөр тутмын хэвийн амьдралыг хангах, худалдаа, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх үндсэн чиг үүрэг, зорилго бүхий хот дүүргийн захиргаа, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цагдаа, гал команд, явган болон авто зам, гүүр, цэцэрлэгт хүрээлэн, парк, ус зайлуулах систем, цэвэр бохир ус, цахилгаан эрчим хүч, холбоо болон мэдээллийн технологийн асар том, ээдрээтэй сүлжээ завсарлагагүйгээр байнгын үйл ажиллагаа явуулж байдаг билээ. Энэ бүх үйл ажиллагаа нь олон зуун жилийн туршид үе үеийн нийслэлийн иргэдийн хичээл зүтгэл хөдөлмөрөөр бүтсэн эд баялаг, үндсэн хөрөнгөд түшиглэсэн, төрийн болон орон нутгийн өмчлөл, хувийн өмчлөлийн үндсэн дээр буюу товчхон хэлэхэд өмчлөлийн олон хэвшилд тулгуурласан байдаг болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Хотын хүн ам эрс хурдацтай өсөж, хүрээ нь өргөжин тэлж, эдийн засгийн идэвхжил асар ихээр нэмэгдэж буй өнөө үед өмчлөлийн олон хэвшилд тулгуурласан дээрх дэд бүтэц, сүлжээний хөрөнгийн удирдлага, менежментийг зүй зохистой, хоорондын уялдаатай, ухаалгаар ханган гүйцэлдүүлэх, хэвийн ажиллагааг хангах засвар үйлчилгээг байнга хийх, хөрөнгө оруулалтыг үр дүнтэй, үр ашигтай хийх үүрэг

зорилго бүхий хөрөнгийн удирдлагын хамгийн орчин үеийн тогтолцоо бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хөрөнгийн удирдлагын ухаалаг тогтолцоо нь хотын дэд бүтэц, сүлжээний бүхий л үе шатанд, тухайлбал, засвар үйлчилгээ хийх, нэгэнт байгаа өмч хөрөнгийг сайжруулах, эсвэл шинэчлэн солих, шинээр хөрөнгө оруулалт хийн бүтээн байгуулахад анхаарлыг хандуулсан байх ёстой. Хотын удирдлагын хувьд хөрөнгийн удирдлагын ухаалаг тогтолцоо нь энэхүү чиглэлээр хамгийн зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх эрхэм зорилготой юм. Олон улсын тэргүүний туршлагаас харвал Хотын удирдлага, мэргэжлийн албууд, нийслэлийн иргэдийн хооронд санал солилцох, хамтын шийдэлд хүрэх механизм бүрдүүлэх нь хөрөнгийн удирдлагын сайн тогтолцооны зайлшгүй нэг шаардлага гэж үзнэ.

Хөрөнгийн удирдлагын ухаалаг тогтолцоо нь дараах 3 суурь үе шаттай байна. Үүнд:

*Нэгдүгээрт*, Хэрэгцээг тодорхойлох: Хөрөнгийн удирдлагын ухаалаг тогтолцоо нь юуны өмнө иргэд, олон нийтэд чухам ямар үйлчилгээг, хэдий хэр хугацаанд, ямар давтамжтай, ямар зардал, өртөгтэйгөөр хийж гүйцэтгэх, энэхүү үйлчилгээний хамрах хүрээ нь ямар болохыг тодорхойлно.

*Хоёрдугаарт*, Эрсдэлийг тогтоох: Тухайн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд үүсэж болох эрсдэл, эсвэл авч хэрэгжүүлээгүйн улмаас гарч болох эрсдэлийг тооцох нь нэн чухал байдаг. Тухайлбал, зарим гудамж талбайг өөрчлөх, шинэчлэх ажлыг иргэдтэй зөвшилцөлгүйгээр эхлүүлсэн нь олны эсэргүүцэлтэй тулгарч эцэстээ энэ ажлаа цуцлан хөрөнгө, материалын үр дүнгүй зардал гаргах нь тохиолддог. Эсвэл, дулааны шугамын үйлчилгээ, арчилгааг хийлгүй хугацаа алдсаны улмаас шугамын осол гарах, үүний улмаас иргэд, байгууллагын тав тух алдагдах, илүү их зардал чирэгдэл учрах нь байдаг.

*Гуравдугаарт*, Хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэх: Тухайн төлөвлөсөн, эсвэл зайлшгүй шаардлагатай арга хэмжээг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, эсвэл төрийн өмчит аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын алинаар нь хийж гүйцэтгэхийг тогтоосны үндсэн дээр хэрэгцээтэй хөрөнгө оруулалтыг босгох, санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг шийдэх шаардлагатай тулгардаг.

Эдгээр 3 суурь үе шат нь өөр хоорондоо нягт уялдаатай байдаг бөгөөд хөрөнгө санхүүгийн бололцоо боломж нь хэрэгцээг тэр болгон бүрэн хангаж чаддаггүйтэй холбогдон хотын хөрөнгө оруулалтын хэрэгцээг эрэмбэлэх, энэ чиглэлээр тодорхой аргачлал боловсруулан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

## 2.2.7 Зардлаа нөхсөн байх зарчим

Хотын нийтийн аж ахуйн зарим үйлчилгээ тухайлбал, цэвэр усаар хангах, бохир ус болон хог цэвэрлэх, зайлуулах үйлчилгээний үнэ тариф эдгээр үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зардлыг тэр бүр нөхөж чадахгүй байх нь нэлээд түгээмэл байдаг. Энэхүү асуудал томоохон бэрхшээл болон лавширсан тохиолдолд нийтийн аж ахуйн үйлчилгээнд шинээр хэрэглэгчдийг холбон сүлжээг өргөтгөх болон нэгэнт тогтсон үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангахад байнгын хүндрэл учирдаг. Нийтийн тээвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, эрчим хүч дулааны хангамж, цэвэр бохир ус, хог цэвэрлэх, зайлуулах үйлчилгээний үнэ тариф нь зах зээлийн зарчмаар тогтоогдсон тохиолдолд энэхүү үйл ажиллагаа нь зардлаа нөхөх, өөрөө өөрийгөө бие даан авч явах, санхүүгийн хувьд үр ашигтай байх нөхцөл бүрдэх нь ойлгомжтой.

Үнэ тарифын нөхцөл байдал тааламжтай, зах зээлийн зарчмаар тогтоогддог, тогтвортой тохиолдолд Улаанбаатар хотын хөгжлийн хөрөнгө оруулалтын олон арга хэмжээг концесс буюу төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд, эсвэл хувийн хөрөнгө оруулалтад түшиглүүлэн авч хэрэгжүүлэх илүү боломж бүрдэх юм. Улаанбаатар хотын такси, интернэт, мэдээлэл технологийн олон үйлчилгээ чухамхүү ийм л зарчмаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бизнес үйл ажиллагаанд үндсэндээ тулгуурлан явагдаж байна. Энэ жишгээр нийтийн аж ахуй, нэн ялангуяа хог цэвэрлэх, зайлуулах, тээвэрлэх үйл ажиллагааг үнэ тарифын хувьд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд авч хэрэгжүүлэх эдийн засгийн хувьд сонирхолтой тогтолцоо бүрдүүлэх нь Хотын өнөөгийн удирдлагын өмнө тулгарч буй нэг чухал сорилт болж байна.

## 2.2.8. Санхүүжилтийн бусад эх үүсвэрүүд

Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийг сайжруулахтай холбогдуулан дээр дурдсанаас бусад боломжит эх үүсвэрүүдийн өнөөгийн нөхцөл байдлыг судлан үзлээ. Үүнд:

- Өрийн бичиг, бонд,
- Төр ба хувийн хэвшлийн түншлэл буюу концесс,
- Хөрөнгийн зах зээл,
- Хувийн хөрөнгө оруулалтын компаниуд,
- Дотоодын санхүүгийн байгууллагууд,
- Хөрөнгийн хөшүүрэг (газар).

### 2.2.8.1. Өрийн бичиг, бонд

Нийслэлийн удирдлага, холбогдох байгууллагууд өнгөрсөн хугацаанд нийслэл хотын эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудал, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын зорилтыг хэрэгжүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох, хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулан хөрөнгө оруулалтын оновчтой арга хэрэгслээр санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах арга замуудыг хайн нэлээн ажиллажээ.

НЗДТГ нь Дэлхийн банктай хамтран бонд гаргах асуудлаар олон удаагийн уулзалт хэлэлцүүлэг хийж, судалгаа явуулсан байна. Олон улсын зах зээлээс хөрөнгө босгох эрх зүйн орчныг бэлдэж, нийслэлийн хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх нийтлэг харилцааг зохицуулсан “Нийслэлийн бондын журам”-ыг Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 117 дугаар тогтоолоор баталсан байна.

Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдэд нийслэл хотын олон улсын зах зээлээс зээлэх чадварт хязгаар тавьсан (буюу өрийн мөнгөн тэмдэгтийн талаар тодорхойлж өгсөн) заалт байдаггүй ч, авах зээлийн нийт хэмжээнд хязгаар тогтоосон байдаг. Төсвийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-р заалтад “Аймаг нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 41.5-д заасан зориулалтаар улсын төсвийн жилийн дотор эргэн төлөгдөх нөхцөлтэй өр үүсгэж болно” гэж заасан байна. Тодруулбал, өрийн хэмжээ нь өмнөх жилийн төсвийн суурь орлогын дүнгээс болон төлөх өрийн үйлчилгээний нийт хэмжээ нь өмнөх жилийн төсвийн суурь орлогын 15 хувиас хэтэрч болохгүй гэсэн тодорхой заалт байдаг.

Төсвийн тогтвортой байдлын хуульд “улсын өр” гэдэгт дотоод, гадаад зээл болон Засгийн газар, орон нутгийн захиргаа түүний дотор төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн ирээдүйд эргэн төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн бүх төрлийн төлбөрийг оруулсныг тодорхой зааж өгсөн байна. Иймд улсын нийт өр ДНБ-ий 40 хувиас хэтэрч болохгүй. Энэ жишгээр тооцвол Дэлхийн банкнаас гаргасан 2012 оны судалгаагаар нийслэл хот 347 тэрбум төгрөгийн бонд гаргах боломжтой гэж үзсэн байна. Хэрэв хотын төсөв, шууд орлого нэмэгдвэл үүнээс илүү хөрөнгийг босгох боломжтой гэж үзжээ. Бонд нь хүү өндөртэй, төлөх хугацаа богино байдаг учраас бондын хөрөнгийг Налайхын аж үйлдвэрийн парк, ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах, хуучин орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах гэх мэт хурдан хугацаанд эргэн төлөгдөх боломжтой төслүүдэд зарцуулахаар журамд тусгаж байжээ. Гэвч одоогоор нийслэлээс ямар нэгэн бонд гаргаагүй байна.

Мөн сүүлийн жилүүдэд нийслэлээс үнэт цаас гаргах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал санаачилга гарган Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж байгаа ажээ.

### 2.2.8.2. Төр болон хувийн хэвшлийн түншлэл буюу хувийн санхүүжилтийн санаачилгууд

ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлого 2009 онд батлагдсан, мөн 2010 онд Концессын тухай хууль батлагдсан зэрэг нь ТХХТ-ийг дэмжихэд чухал ач холбогдолтой байв. Концессын тухай хууль нь олон улсын тэргүүн туршлагад тулгуурласан бөгөөд концессыг хэрэгжүүлэх тодорхой, цогц орчныг бий

болгож, олон салбаруудын дэд бүтцийн төслүүдэд хувийн хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн зохицуулалтын тогтолцоог бий болгосон.<sup>4</sup> Олон улсын хэмжээнд ТХХТ-ийн зохицуулалт нь гол төлөв замын салбар, Худалдан авах хэлцэл бүхий усан цахилгаан станц, усан хангамж, хог хаягдлын менежмент, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний салбарт түгээмэл байдаг.

Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын хэрэгцээг хангахад төр болон хувийн хэвшлийн түншлэл (концесс) чухал ач холбогдолтой юм. Эдийн засгийн хөгжлийг дэмжих, тодорхой хөтөлбөрийг хэрэгжүүлэх төр, хувийн хэвшилд адил тэгш боломж олгох, харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх талаар олон арга хэмжээг авчээ. 2012-2016 оны хооронд нийслэлийн концессын нийт 148 төсөл хэрэгжихээр батлагдсанаас 2016 оны байдлаар 19 төсөлд концессын гэрээ байгуулагдаж, нийт 464 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2015 онд концессын гэрээгээр Налайх дүүргийн тавдугаар хорооны нутаг дэвсгэрт 1000 м3 хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламж бүрэн ашиглалтад орсон байна. Түргэн тусламжийн салбар пунктын барилга, Өлзийт хороолол- Шувуун фабрик чиглэлийн автозамын ажлууд хэрэгжсэн байна.

2015-2016 оны хооронд нийт 30 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төслийг барих шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээгээр хийж гүйцэтгэсэн байна (Хүснэгт 2.12). Эдгээр концессын гэрээний хүрээнд Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургуулийн өргөтгөл, Баянгол дүүргийн 38 болон 73 дугаар сургууль, Хан-Уул дүүргийн 32 дугаар сургуулийн барилга угсралт, хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэжээ.

### Хүснэгт 2.12. Концессын гэрээгээр хийсэн хөрөнгө оруулалт, 2015-16 он (сая төгрөг)

Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөвт өртөг	Санхүүжилт
Сургуулийн барилгын өргөтгөл, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр сургууль	10,787.0	10,787.0
Сургуулийн барилга, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль	14,884.5	5,581.7
Сургуулийн барилга, Баянгол дүүрэг, 73 дугаар сургууль	10,736.3	7,515.4
Сургуулийн барилга, Хан-Уул дүүрэг, 32 дугаар сургууль	5,800.0	5,800.0

Эх үүсвэр: НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн газар, 2017

Харин 2016 онд Концессын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын зүйлийн жагсаалт батлах, концессын гэрээ байгуулах эрх олгох, аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй гэрээ байгуулахыг хориглосон. Хотын бүтээн байгуулалтыг хийхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын олон төрөлгүйгээр шийдэж чадахгүй билээ. Иймд концессыг хэрэгжүүлэх чиглэлээр нийслэлийн удирдлагууд УИХ, Засгийн газартай хамтран ажиллах шаардлагатай нь харагдаж байна.

### 2.2.8.3 Хөрөнгийн зах зээл

Азийн 13 оронд хийсэн дотоодын нийт хадгаламж болон тухайн орны үндсэн хөрөнгийн бүтцийн судалгаанаас харахад хөрөнгө оруулалтын хэмжээнээс давсан хадгаламж зах зээл дээр байна гэсэн судалгаа байдаг. Зарим орнуудын хувьд энэхүү зөрүү нь ДНБ-ий 40 хувьтай тэнцэх хэмжээний өндөр байжээ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтад татаж болох эх үүсвэр буюу тухайн орны хадгаламж их байгаа ч, хөрөнгө оруулалт ихээр дутагдалтай байгаа явдал нь санхүүгийн зах зээл хөгжөөгүйгээс шалтгаалж байна. Эдгээр орнуудад буй их хэмжээний хадгаламж нь дэлхийн санхүүгийн төвүүдээр дамжин гадагш гарах боломжтой ба бүтээмж багатай салбаруудад хөрөнгө оруулах боломжтой байна.

Манай орны хувьд, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж чадвал зах зээл дээр байгаа хадгаламжийн хөрөнгийг санхүүжилтийн хэрэгцээнд чиглүүлэн зуучлан холбох олон холбоснууд бий болно. Тиймээс

<sup>4</sup> НҮБХХЧ. Хөрөнгө оруулалтын бодлогод хийсэн дүгнэлт (2013)

манай засгийн газар дотоодын хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэх арга замыг идэвхтэйгээр эрэлхийлэх хэрэгтэй гэдэг нь илэрхий байна.

Мөн хөрөнгийн зах зээл дээр хотын захиргаа амжилттай бонд гаргахын тулд үйл ажиллагаагаа болон санхүүгийн нөхцөлөө олон нийтэд илүү ил тод, нээлттэй байлгаж, санхүүгийн нөхцөл байдлаа зээлжих зэрэглэл тогтоодог агентлагуудаар үнэлүүлэх шаардлагатай. Энэ практик нь АНУ-д түгээмэл байдаг бөгөөд, харин Азийн улс орнуудын хувьд хотын захиргаа нь зээлийн эрсдэл болон зээлжих зэрэглэлийн хувьд бэрхшээлтэй тулгардаг байна.

Мөн ихэнх Азийн орнуудын хувьд хотын захиргааны санхүүгийн мэдээллийг авах боломжгүй эсвэл үнэлгээ хийх зорилгоор ашиглахад тохиромжгүй гэж үздэг байна. Иймд Улаанбаатар хотын захиргаа энэ тал дээр түлхүү анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна.

#### 2.2.8.4 Даатгалын компаниуд

Олон улсын жишгээр авч үзвэл тэтгэврийн сан, даатгалын компаниуд, төрөл бүрийн сангууд, хандивлагч байгууллагууд нь ихэвчлэн эрсдэл багатай, томоохон цар хүрээний, урт хугацаанд үр дүнгээ өгөх төслүүдэд хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байдаг. Иймд хотын дэд бүтцийн төслүүд нь тэдгээрийн шаардлагад зүй ёсоор нийцдэг.

Нийслэл Улаанбаатар хотын хувьд, өөрийн хувь эзэмшил орсон даатгалын компани, банктайгаас гадна орон нутгийн өмчит газрууд, хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд, орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд зэрэг нийт 60 гаруй байгууллагатай юм. Иймд Улаанбаатар хот хувьцааг нь эзэмшдэг даатгалын компаниар дамжуулан олон төрлийн санхүүгийн хэрэгсэл, хөрөнгөнүүдээр дамжуулан хөрөнгө оруулалт хийх боломж байна. Тухайлбал, засгийн газрын бонд, компанийн бонд, хувьцаа, хувийн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, хейдж сангууд, дэд бүтцийн сангууд зэрэг байж болно.

Дэд бүтцийн төслүүдийн эрсдэлийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын хугацааны хязгаар, тэдгээр байгууллагуудын нөөцийн хэмжээ зэрэг голлох хүчин зүйлүүдийг авч үзвэл ихээхэн хэмжээний санхүүжилтийн нөөц, бололцоо бодитой байгаа хэдий ч дэд бүтцэд урт хугацааны хөрөнгө оруулалт хийх суваг, арга зам хангалтгүй байж болно. Тиймээс Засгийн газар тэдгээр байгууллагуудын санхүүжилт олгоход тавьдаг шаардлагуудыг ойлгож, тэдгээр нөөцүүдээс хөрөнгө оруулалт татахад дэмжлэг болохуйц бодлогын зохицуулалтаар хангах хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

#### 2.2.8.5 Дотоодын санхүүгийн байгууллагууд: дотоод зээллэг

2015 онд Нийслэлийн ИТХ-ын шийдвэрээр “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн стратегид тусгагдсан төсөл хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК-ийг үүсгэн байгуулсан байна.

Тус компани нь хотын хөгжлийн төлөвлөгөө, стратегид тусгагдсан зарим төсөл, хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран санхүүжүүлж, хэрэгжүүлэх, төр хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааны зохистой хэлбэрийг сонгох, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, иргэн, хувийн хэвшлийн санаачилсан төсөл хөтөлбөрийн тооцоо судалгааг хийх, дэд бүтэц, газрын харилцааг зохион байгуулах, хамтран ажиллах төслийн нэгж байгууллага, хөрөнгө оруулалтын асуудлыг хамтран шийдвэрлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Энэ компани нь өөрийн үндсэн орлогоос гадна Улсын болон нийслэлийн төсвөөс төслийн хөрөнгө оруулалтад зориулан компанид хуваарилсан хөрөнгө, компанийн үнэт цаасыг гадаад, дотоод зах зээлд нээлттэй болон хаалттай хүрээнд гаргаж худалдсаны орлого, хөрөнгө оруулалтын зээл, гадаад, дотоодын иргэд байгууллагаас компанийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд зориулан өгсөн хандив, тусламж, хууль тогтоомжийн хүрээнд болон НИТХ-аас зөвшөөрөгдсөн бусад орлого зэргээр хөгжлийн сан бүрдүүлэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Одоогийн байдлаар “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК, “Илхаэ Холдингс” ХХК ба “Кэй Жэй Эл Глобал” ХХК нь Улаанбаатар хотын орчны бохирдлыг буруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах бодлогын хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх шороон болон хучилттай замын арчилгаа, хог хаягдлын менежментийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хамтран ажиллах, төслийн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, хоорондын уялдаа холбоог сайжруулах тухай харилцан ойлголцож санамж бичиг байгуулсан байна.

### 2.2.8.6 Газарт суурилсан санхүүжилт

Улаанбаатар хотын хувьд Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь чиг үүргийн дагуу барилга байгууламж, тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж, хувьчлалын орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлдэг байна. Харин газарт суурилсан санхүүжилтийн механизмыг төдийлөн хэрэгжүүлээгүй байна.

Өнөө үед хөгжиж буй орнуудад газарт суурилсан санхүүжилтийн хэлбэр нь хотын дэд бүтцийг санхүүжүүлэх чухал эх үүсвэр болоод байна. Иймд нийслэл Улаанбаатар хотод төрийн өмчийн төслүүдийг газрын үнэ цэнийн өсөлтийг дагасан газар сайжруулалтын механизм (татвар байж болно)-аар санхүүжүүлэх боломж байгаа эсэхийг судлах шаардлага тулгарсан байна.

Газрын үнэ цэнийг өсгөх олон аргыг ашиглаж болно. Хамгийн түгээмэл арга зам нь нийтийн эзэмшлийн газрыг зарж эсвэл түрээсэлж, хотын дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх явдал юм. Газарт суурилсан санхүүжилт нь бас төр, хувийн хэвшлийн түншлэлд боломжуудыг нээдэг. Хотын удирдлага нь хотын дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхэд зориулж хувийн хэвшилд газрыг үнэгүй ашиглуулж эсвэл уг хөрөнгө оруулалтаас үүдсэн газрын үнийн өсөлтийн өгөөжийг хуваан хүртэх боломжтой байна.

## 2.3. Хотын санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд тулгардаг сорилтууд

Хотын дэд бүтцийн төслүүдийг боловсруулах хүчин чадал Улаанбаатар хотод хангалттай хэмжээнд байхгүй байна. Үүнд: хотын захиргааны түвшинд стратегийн төлөвлөлт хийх чадавх сул, санхүүгийн зах зээлийн сул хөгжлийн улмаас санхүүгийн эх үүсвэр хомс, төслийн мөн чанартай холбоотой тулгамдсан асуудлууд их, төслийн бүтцийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрдөггүй, түүнчлэн төсвийн алдагдал, ядуурлын түвшин зэрэг олон хүчин зүйлүүдийг нэрлэж болно.

Хотын хөгжлийн төслийг санхүүжүүлэх таатай орчныг бий болгоход тулгарч буй гол сорилтуудыг дараах хэсгүүдэд авч үзсэн болно.

### 2.3.1 Төсвийн алдагдал, ядуурал

Монгол улсын эдийн засгийн өсөлт 2016 онд 1.2 хувьтай байсан бол 2017 оны эхний хагаст 5.3 хувиар өссөн<sup>5</sup>. 2017 оны I хагаст төсвийн орлого 41.1 хувиар өсөж, төсвийн зарлага 9.6 хувиар өссөн буюу төсвийн алдагдлын хэмжээ ДНБ-ий 5.8 хувьтай тэнцсэн байна. Төсвийн алдагдал нь Засгийн газрын хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх чадварыг хязгаарлаж байна. Монгол улс 2016 оны байдлаар 3.1 сая хүн амтай бөгөөд улсын дунджаар 29.6 хувь буюу 907.5 мянган хүн ядуу амьдарч байна<sup>6</sup>. Улаанбаатар хотод ядуурлын түвшнээс доогуур түвшинд амьдарч буй хүн амын эзлэх хувь 2016 онд 24.8 хувь буюу өндөр хэвээр байгаа бөгөөд, эдгээр хүн ам нь дэд бүтцийн ашиглалтын өндөр төлбөр төлөхөд бэрхшээлтэй тулгардаг. Энэ нь эргээд Засгийн газраас дэд бүтцийн төслүүдийг өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжийг хязгаарлаж байна. Мөн популист улс төрийн амлалт нь төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэх нийгмийн шаардлагыг бий болгож байна.

<sup>5</sup> ҮСХ, Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2017 оны 7 сар.

<sup>6</sup> ҮСХ, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, 2016.

### 2.3.2 Дотоодын зах зээл дэх эх үүсвэрийн хязгаарлагдмал байдал


Хотын дэд бүтэц нь урт хугацаанд их хэмжээний хөрөнгө оруулалтыг шаарддаг бөгөөд манай улсын санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийн сул хөгжлөөс хамааран хүндрэлтэй асуудлууд үүссээр байна.

Дотоодын санхүүгийн зах зээлийн сул хөгжил нь ялангуяа дэд бүтцийн төслүүдийг гадаадын зээлээс хамааралтай болгож байна. Өөрөөр хэлбэл, төслийн эрсдэлийн түвшнийг нэмэгдүүлж, гадаад валютаар авсан зээл нь хөрөнгө оруулалтын төслийг гадаад валютын ханшийн хэлбэлзэлд өртүүлдэг. Засгийн газар гадаад валютын ханшийн эрсдэлийг үүрэх боломжгүй тул төсөл нь валютын хейдж хэлцэл хийх шаардлагатай тулгарч төслийн зардлыг нэмэгдүүлж байна.

### 2.3.3 Төсөл хөгжүүлэх, зөв бүтэц боловсруулах чадавх

Төслүүд, ялангуяа дэд бүтцийн төслүүдийн бүтээн босголтын үе шатанд их хэмжээний хөрөнгө зарцуулахыг шаарддаг. Энэ шаардлага нь нийслэлийн ИТХ-ийн хуваарилах төсвөөс ямагт өндөр дүнтэй байдаг. Дүрслэл 2.10-д дэд бүтцийн төслийн мөнгөн урсгалын загварыг дүрслэн харуулав. Энэ нь хөрөнгийн зардлын шаардагдах хэмжээ болон Улаанбаатар хотын санхүүгийн чадавхын хоорондын ялгааг харуулж байна. Улаанбаатар хот олон тооны төслийг өөрөө хэрэгжүүлэхээр шийдсэн тул энэ нөхцөл байдал үүсэж байна.

**Дүрслэл 2.10. Төсөвт байгууллагаар дамжуулан дэд бүтцийн төсөлд үзүүлэх санхүүжилтийн загварчлал**



Эх үүсвэр: УБАК судалгаа

Хэдийгээр хотын захиргаа хувийн хэвшлийн оролцоонд нээлттэй байгаа боловч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хомс байгаагийн нэг шалтгаан нь төслийн бүтцэд асуудал байна гэж үзэж байна. Эрсдэлийг удирдах асуудалд оролцох боломжгүй талд эрсдэл түлхүү хуваарилагддаг. Тодруулбал, хэрэглээний тариф тогтоох, үнэ, борлуулалтын хэмжээ зэрэг эрэлтийн эрсдэлтэй холбоотой асуудлууд нь хувийн хэвшлийн хяналтаас гадуур байдаг. Иймд эрэлт хэрэгцээний эрсдэлийг хуваан хариуцах боловч тэдгээр эрсдэлийг удирдах байр суурь эдэлдэггүй тул хувиараа бүтээн босгогчид, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын сонирхол, оролцоог хязгаарлаж байна. Цаашилбал, оролцогч талуудтай зөвлөлдөөгүй, зах зээлийн мэдээлэл, эрсдэлийн хэмжээ, төрлийг ул сууртай үнэлээгүй боловсруулсан төслийн бүтэц нь бодит бус төслүүдэд хүргэж байна.



### 2.3.4 Төслийн санхүүгийн чадавхгүй байдал

Зарим төслүүд санхүүгийн үр ашиг багатай байдаг тул тэдгээрийг бизнесийн (арилжааны) үндсэн дээр санхүүжүүлэх нь бэрхшээлтэй тулгарч байна. Өөрөөр хэлбэл, өндөр зардалтай хөрөнгө оруулалт боловч эцсийн хэрэглэгчийн төлбөрийн хязгаарлалт нь санхүүгийн хувьд сул төслүүдийг бий болгодог. Ийм төслийг хэрэгжүүлэх нь нийгмийн эерэг нөлөөтэй байж болно. Жишээлбэл, метроны масс хурдны тээврийн систем (MRTS) төсөл нь асар их хөрөнгийн зардлыг шаардах бөгөөд эцсийн хэрэглэгчийн үнийг хязгаарлахыг мөн шаарддаг. Гэсэн хэдий ч, нийгмийн тал дээр иймэрхүү төслүүд нь замын түгжрэлийг багасгаж, хотын хүн амын амьдралын чанарыг сайжруулна.

### 2.3.5 Институтийн чадавх сул: Засгийн газар, холбогдох агентлагуудын чиг үүргийн давхцал

Засгийн газрын янз бүрийн түвшний байгууллагууд хотын хөгжлийн төслүүдийг боловсруулж хөгжүүлэхэд оролцдог боловч тэдний оролцооны түвшин харилцан адилгүй байна. Ерөнхийдөө, бодлого нь Засгийн газрын янз бүрийн түвшинд гарч байхад хэрэгжүүлэх үүрэг хариуцлага нь хамгийн доод түвшинд буюу хот, дүүргийн захиргаанд ирдэг. Дүрслэл 2.11-т Засгийн газрын янз бүрийн түвшний байгууллагууд, хот байгуулалтын дэд бүтцийг хөгжүүлэхэд оролцох тэдний үүргийг харуулж байна.

Ихэнхдээ засгийн газрын байгууллагуудын хооронд үүрэг, хариуцлагын талаар тодорхой зааг байдаггүй бөгөөд ийм байдал нь салбарын, агентлагуудын хоорондын харилцан ойлголцол, хамтын ажиллагаанаас шалтгаалж байна. Энэ нь гол төслүүдийн хэрэгжилтийг удаашруулахад хүргэдэг. Засгийн газрын бүтэц, чиг үүргийн хүрээнд хот төлөвлөлт, барилгын бодлогын асуудлыг Барилга, хот байгуулалтын яам хариуцаж байна. Хотын удирдлага нь дангаараа хот байгуулалт, дэд бүтцийг сайжруулах шийдвэр гаргах боломжгүй. Иймд хууль эрх зүйн зохицуулалтын орчныг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

### Дүрслэл 2.11. Засгийн газрын байгууллагуудын үүрэг



### 2.3.6 Хотын менежментийн үр ашиг, чадавх

Хотын дэд бүтцийн санхүүжилтийг шийдвэрлэгч, төсөл боловсруулагч, дотоодын хөрөнгө оруулагч талаас нь авч үзвэл хотын менежментийн үр ашиг, чадавх нэлээд сул байна. Тухайлбал, хотын дэд бүтцийн санхүүжилтийн хувьд: хотын захиргаанд санхүүгийн загвараас бүрдсэн иж бүрэн дүн шинжилгээ хийх, төслийн бүтэц боловсруулах, эрсдэл хуваарилах, мөнгөний үнэ цэнийн тооцоо хийх чадавх сул байна. Харин тухайн төслийн хувьд: эдийн засгийн өгөөжийн өнөөгийн цэвэр үнэ (ӨЦҮ буюу NPV), санхүүгийн өгөөжийн дотоод хувь (СӨДХ буюу IRR) тооцох чадавх сул байна. Дотоодын хөрөнгө оруулагчийн хувьд: төслийн эдийн засаг, нийгмийн нөлөөллийг тооцох, санхүүжилтийн өртгийн тооцоо хийх, засгийн газрын дэмжлэгт тавигддаг янз бүрийн шаардлага, шалгуур, түүний үр дагаврыг тооцоолох чадавх сул байна.

Үүнээс гадна авлига зэрэг тогтолцооны үр ашиггүй байдал их байгаа бөгөөд, энэ нь гадаадын хөрөнгө оруулалтын урсгалд гол саад учруулагч юм.

### 2.3.7 Мэдээллийн хүртээмж

Энд мэдээллийн хүртээмж, цогц чанар талаас авч үзэж байна. Нийслэл, дүүргийн захиргаанд хөгжлийн төслүүд, ялангуяа дэд бүтцийг санхүүжүүлэх боломж, процедурын холбоотой мэдээлэл хангалтгүй байдаг. Хэрэв ийм мэдээлэл байгаа эсвэл хүртээмжтэй байгаа бол ихэнхдээ төөрөгдөл үүсгэх олон тайлбартай байдаг.

## 2.4 Хөрөнгө оруулалтын төслийн үр ашигт байдал


Энэ судалгааны хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа дор дурдсан төслийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлуудын талаар санал, зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр,
2. Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр /ОНӨҮГ/,
3. Налайхын барилгын материалын үйлдвэр, технологийн парк /ОНӨҮГ/ төсөл,
4. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн /ОНӨҮГ/ төсөл.

Бид өнгөрсөн хугацаанд бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төслийн үр ашгийг тооцохоор төлөвлөж байсан боловч НЗДТГ-аас өгсөн мэдээлэл нь ийм үнэлгээ хийхэд хангалттай бус, хязгаарлагдмал байсан тул сонгосон төсөл, хөтөлбөрийн танилцуулга, төлөвлөгөө, үйл ажиллагааны жилийн тайлан зэрэгт үндэслэн хэрэгжилтийн явцын үнэлгээ хийснийг тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын тайлан, ХШҮ болон хөндлөнгийн аудитын тайлан, ТЭЗҮ болон шаардлагатай бусад мэдээллийг бидэнд ирүүлээгүй тул төслийн үр ашгийг тооцох боломжгүй байна.

Судалгааны аргачлал. Төсөл, хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн харилцан хамаарал, тогтолцоог Дүрслэл 2.12-д үзүүлсэн байдлаар шинжилсэн.

### Дүрслэл 2.12. Төсөл, хөтөлбөрийн зорилго, үр дүнгийн харилцан хамаарал



Төсөл тус бүрээр хийсэн шинжилгээг авч үзье.

### 2.4.1 Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилго:	<b>Цомхон бүтэцтэй, ойлгомжтой дүрэмтэй, соёлтой шуурхай үйлчилгээтэй, технологигсон, ажиллаж амьдрахад таатай ухаалаг хот бий болгох</b>
Батлагдсан огноо:	НИТХ-ын 2014 оны 16/11 тогтоол
Хэрэгжүүлэх үе шат:	2014-2016 Цахимжсан Улаанбаатар 2015-2018 Технологигсон Улаанбаатар 2016-2020 Ухаалаг, ногоон, хөгжингүй Улаанбаатар
Санхүүжилтийн эх үүсвэр:	Нийслэлийн төсөв
Хэрэгжүүлэгч:	Нийслэлийн мэдээллийн технологийн газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд
Судалгааны хамрах хүрээ:	Хөтөлбөрийн 2014-2016 оны үйл ажиллагаа
Судалгааны аргачлал:	Баримт бичгийн судалгааны арга ашигласан.
Мэдээллийн эх сурвалж:	Хөтөлбөрийн 2014-2015 оны ажлын танилцуулга, Ухаалаг Улаанбаатар хөтөлбөрийн 2016 оны хэрэгжилтийн тайлан

### Хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий байдал

Ухаалаг Улаанбаатар хөтөлбөрийн 6 зорилтын хүрээнд 2014-2016 онд хийсэн гол үйл ажиллагааг зорилт тус бүрээр доор үзүүлэв. “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх судалгааны асуулгыг Хавсралт хүснэгт 9-өөс харна уу.

Ухаалаг Засаглал зорилтын хүрээнд “ухаалаг хот” дэд бүтцийн технологийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, нийслэлийн төрийн үйлчилгээний цахим систем бий болгож автоматжуулснаар төрийн 27 байгууллагын 337 төрлийн үйлчилгээ, мэдээллийг иргэд нэг дороос шууд авах боломжтой болсон. Нийслэлийн бүх дүүрэг, хороодыг нэгдсэн сүлжээнд холбож, шилэн дансны системийг нийслэлийн

байгууллагуудад нэвтрүүлсэн. 116 хороонд Иргэний танхим ажиллуулж иргэдийн оролцоог хангах чиглэлд ажиллаж байна.

Ухаалаг эдийн засаг зорилтын хүрээнд газрын бирж байгуулж, ажилгүй иргэдийг нийслэлийн хэмжээнд бүртгэлжүүлэн нэгдсэн системд оруулж, бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн.

Ухаалаг иргэд зорилтын хүрээнд иргэдийг мэдээллээр хангах, дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, архи тамхигүй өдөр зэрэг арга хэмжээ зохион байгуулсан.

Ухаалаг үйлчилгээ зорилтын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж буй 242 үйлчилгээг стандарт багцад оруулсан. Дүүргүүд видео хурлын системд холбогдож, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах, ил тод шуурхай шийдвэрлэх зорилго бүхий өргөдөл гомдлын нэгдсэн программ нэвтрүүлсэн.

Ухаалаг орчин зорилтын хүрээнд хороо бүрд хийгдэх тохижилт, бүтээн байгуулалтын ажлын саналыг 318 мянган өрхөөс авч хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулсан. Нийслэлийн дата төв болон нийслэлийн 6 цэгт утасгүй интернэт бүс байгуулсан. Хотын нийтийн тээврийн үйлчилгээнд цахим төлбөрийн систем нэвтрүүлж, замын хөдөлгөөний зөрчлийг камерын хяналтын системийн тусламжтай хянадаг болсон. Нийслэлийн 52 байршилд газар өмчлүүлэх ажлыг цахимаар хийж 94,385 иргэнд газар өмчлүүлсэн байна.

Ухаалаг амьдрал зорилтын хүрээнд 16 байршилд бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барьж, цахим эрүүл мэнд төсөл хэрэгжүүлж, Улаанбаатар хотод нийт 627 камер суурилуулжээ.

## **“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ**

1. Хөтөлбөрийн зарим зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим үйл ажиллагаанууд нь санхүүгийн, технологийн шийдэл, боловсон хүчний хувьд шийдэгдэх боломж тааруу, судалгаа, үндэслэл муутай тул зорилтот хугацаандаа хэрэгжих боломжгүй байна.
2. Үндсэн хөтөлбөртэй уялдаатайгаар олон арван дэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр заасан нь хэт нүсэр, хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болоход нөлөөлсөн.
3. Хэдийгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хөтөлбөрийн удирдах хороог байгуулсан ч дараах шалтгааны улмаас үр дүнтэй ажиллаж чадсангүй. Үүнд:
  - Хэт олон байгууллагуудыг төлөвлөгөөнд оролцуулснаар заримд нь ажлын давхардал үүсэж, цалгардуулах боломжийг олгосон байна.
  - Удирдах хороо хангалтгүй, идэвх санаачилгагүй ажилласан нь 2014 оноос хойш ганц удаа хуралдсан гэж тайланд тусгагдсанаас илэрхий харагдаж байна.
  - Удирдах хороо, ажлын хэсгүүдэд ТББ, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэдийн төлөөлөл бараг байхгүй, хотын захиргааны ажилтнууд, голдуу удирдлагуудыг оруулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байж болно.
  - Хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж чадаагүй.
  - Зарим ажлыг хэн хийж хэрэгжүүлэх нь тодорхойгүй, хариуцсан эзэнгүйгээс ажил цалгардах явдал гарчээ.
4. Хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа хоорондоо зөрчилдсөн олон ажил, зорилтууд байна. Шуурхай, шударга, хүнд сурталгүй үйлчилгээг бий болгох зорилготой ч, маш олон төв, ОНӨҮГ байгуулж төрийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал:
  - Улаанбаатар хотын өрсөлдөх чадварын судалгааны нийгэмлэг,
  - Нийслэлийн шуурхай удирдлагын нэгдсэн төв,
  - Инновац болон R&D судалгааны төв,
  - Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв,

- Газрын бирж гэх мэт.
5. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, төсөв хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, шалгалт бараг хийгдээгүй, хяналтын тогтолцоог зохих түвшинд бүрдүүлээгүй байна.
  6. Нэн яаралтай, ойрын хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай, хэрэгжих бүрэн боломжтой ажлуудыг хийж гүйцэтгэхгүй удаашруулах, хойшлуулах, санаачилга гаргахгүй байх явдал их байжээ. Тухайлбал:
    - Хууль эрх зүйн орчны шинэчлэлүүд,
    - Эрх мэдэл шилжүүлэх,
    - Төрийн зарим чиг үүргийг ТББ, холбоодод гэрээгээр шилжүүлэх,
    - Тусгай зөвшөөрөл, лиценз олголтыг ил тод, нээлттэй болгох,
    - Хотын байгаль орчны бохирдлыг бууруулах зэргийг дурдаж болно.
  7. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо тун хангалтгүй байна. Хэдийгээр хөтөлбөрт энэ талаар тодорхой заалтууд байгаа ч хэрэгжүүлээгүй байна. Тэднийг хөтөлбөрт хамруулах, оролцуулах талаар хөтөлбөрийн удирдлага, удирдах хороо, нийслэлийн төр захиргааны байгууллагуудаас ямар нэг санаачилга, идэвх гаргаагүй байна.
  8. Хэт олон ажил, том зорилтууд дэвшүүлсэн хэдий ч тэдгээрийг санхүүжүүлэх санхүүгийн эх үүсвэр хангалтгүй, тодорхой бус, хязгаарлагдмал байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.
  9. Ухаалаг Улаанбаатар хөтөлбөрийн хувьд шалгуур үзүүлэлтүүдийг хөтөлбөрийн хүрэх үр дүнгээр тодорхойлж гаргажээ. Тэдгээрээс үзэхэд зарим нь хэрэгжсэн, зорилгодоо хүрсэн эсэхийг тодорхойлоход бэрхшээлтэй буюу хүндрэлтэй асуудлууд нэлээд байна. Тухайлбал, “иргэдэд шударга, шуурхай, чирэгдэлгүй үйлчилдэг хот” болсон эсэхийг “Төрийн үйлчилгээний хурд 50-90 хувиар хурдассан”-аар тодорхойлох уу, эсвэл өөр шалгуураар хэмжих үү? Хотыг ухаалгаар удирдах мэдээлэлтэй болсон эсэхийг ямар шалгуураар үнэлэх гэх мэт нь тодорхойгүй, эсвэл дутуу дулимаг тодорхойлсон нь төслийн хэрэгжилт, үр дүнг гаргах, тайлагнах, үнэлэн шинжлэхэд ихээхэн бэрхшээл учруулахаар байна. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг Хавсралт хүснэгт 10-аас харна уу.

### **“Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хувьд өгөх санал, зөвлөмж**

1. Хөтөлбөрийн удирдах хороо, ажлын хэсгүүд, төслийн нэгжүүдийн удирдлагыг шинэчлэн томилох, эсвэл тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэх, хариуцлага тооцох, хөтөлбөрийн удирдлага, хэрэгжилтэд хувийн хэвшил, бизнесийн холбоод, иргэд, судалгаа шинжилгээний байгууллагуудын төлөөллийг түлхүү оруулах,
2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд нарийвчилсан үнэлэлт дүгнэлт өгөх, санал зөвлөмж боловсруулах ажлыг хөндлөнгийн судалгааны байгууллагуудаар гүйцэтгүүлэх, санхүүгийн аудит хийлгэх, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах,
3. Хөтөлбөрийн санхүүжилтийг тодорхой болгон шийдвэрлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг өргөнөөр татах ажлыг зохион байгуулах,
4. Хөтөлбөрийн хөрөнгө, санхүүгийн нэгдсэн удирдлагын болон хяналтын тогтолцоог яаралтай бий болгох, хөтөлбөрийн зорилтуудын уялдаа холбоог хангах замаар давхардсан ажил, үүргүүдийг арилгах,
5. Хөтөлбөрийг бусад төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах, нэгтгэх замаар зарим санхүүжилтийн асуудлыг шийдэх гарц, шийдлийг олох,
6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадварлаг мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх, хувийн хэвшлээс, аутсорсинг болон бусад хэлбэрээр мэргэжилтэн ажиллуулах арга, механизмуудыг хэрэгжүүлэх,

7. Нийслэлийн зарим чиг үүрэг, үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгэмд гэрээгээр болон бүрэн шилжүүлэх талаар судалж санал боловсруулах, энэ ажлыг эрчимжүүлэх замаар хүнд суртал, чирэгдэлгүй үйлчилгээг хангах боломжийг бүрдүүлэх,
8. Хөтөлбөрийн болон нийслэлийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн байнгын, чадварлаг хамтын ажиллагааны механизм бий болгох,
9. Хөтөлбөрийн болон нийслэлийн хүрээнд иргэд, хувийн хэвшил, ТББ, олон нийтээс санал авах, тусгах, эргээд тайлагнах механизм бий болгох.
10. Тухайн төсөл, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, дүгнэх, хянах тусгай арга, шалгуур үзүүлэлтүүд нь төслийн төлөвлөлтийн чухал хэсгийн нэг юм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийг цаашид нарийн тодорхой боловсруулж гаргах хэрэгтэй.

## 2.4.2 Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр

<b>Хөтөлбөрийн зорилго:</b>	Хот орчмын бүсэд мал аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлэхэд хадлан, бэлчээрийн талбайн ургамлын нөмрөгт цөлжилтийг даахуйц, орчны таатай уур амьсгал бүрдүүлэх, хөрс, цаг уурын нөхцөлд тохирсон, ургах чадвар өндөр, ногоон масс ихтэй тэжээлийн ургамлыг нутагшуулж, малчид, фермерүүдийн идэвх оролцоонд тулгуурлан бэлчээрийн менежментийг шинэчлэх
<b>Батлагдсан огноо:</b>	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 32 дугаар тогтоол
<b>Хэрэгжүүлэх үе шат:</b>	2014-2020
<b>Санхүүжилтийн эх үүсвэр:</b>	Улсын болон орон нутгийн төсөв, иргэн, ААН-ийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, тусламж, гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж
<b>Хэрэгжүүлэгч:</b>	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, ногоон хөгжлийн газар, ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төв
<b>Судалгааны хамрах хүрээ:</b>	Хөтөлбөрийн 2016-2017 оны үйл ажиллагаа
<b>Судалгааны аргачлал:</b>	Баримт бичгийн судалгааны арга ашигласан.
<b>Мэдээллийн эх сурвалж:</b>	Хөтөлбөрийн 2016-2017 оны ажлын тайлан

### Хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий байдал

Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн 2015-2017 онд хийсэн гол үйл ажиллагааг доор үзүүлэв.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 212 тоот тогтоолоор “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨҮГ-ыг байгуулж хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн гол зорилго болох бэлчээрийн тариалалтад үрлэн технологи нэвтрүүлэх ажил эхлэлийн шатанд байна. Технологийн карт гаргасан, туршилтын журмаар тариалах 2 төрлийн 8 зүйл 21 сортын олон наст ургамлын үр Австри улсаас ирээгүй, БНХАУ-ын 2 төрлийн 6 зүйлт олон наст ургамлын үрээр харьцуулсан туршилтын тариалалт хийсэн ч зөвхөн 2 зүйл нь соёолсон, гадаадын мэргэжилтний саналаар тариалалтыг бүтэн жилээр хойшлуулсан нь төслийн хэрэгжилт сул байгааг харуулж байна.

Эрчимжсэн мал аж ахуйн загвар төв байгуулах ажлын хүрээнд барилгын ажлын болон техник, тоног төхөөрөмжийн худалдан авалт 2017 оны 7 сарын байдлаар 97 хувийн гүйцэтгэлтэй байна. Харин бага оврын техник, тоног төхөөрөмжийн худалдан авалтын сонгон шалгаруулалт хойшлогдсон байна. 2015-2016 онд нийт 2,0 тэрбум төгрөгийн техник тоног төхөөрөмж, 90 үнээний зогсоол бүхий фермерийн цогцолборын барилга байгууламжийн ажил хийж гүйцэтгэсэн ч, одоо ашиглалтгүй хадгалагдсан

байдалтай байна. Мөн техник дундын төвийн барилга баригдсан, ашиглалтгүй байна. Цахилгааны шугам татах ажлыг бүрэн хийж дууссан ч зураг төслийг буруу төлөвлөснөөс 520 м шугам агаараар дахин татах шаардлага үүсжээ. Нийт 150 га газрыг хашаалсан, 10 га-д олон наст таримлын холимгоор үрлэгээ хийж туршилт явуулсан.

### “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтийг оновчгүй тодорхойлсон, тоон утгаар илэрхийлсэн хүрэх түвшин байхгүй тул хэрэгжсэн эсэхийг үнэлэхэд хүндрэлтэй буюу боломжгүй байна. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд хийсэн шинжилгээг Хүснэгт 2.13 -аас харна уу.

### Хүснэгт 2.13. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд хийсэн шинжилгээ

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	Дүн шинжилгээ		
	Тоон үнэлгээ	Чанарын үнэлгээ	Хөндөгдөх асуулт
Нийслэлийн МАА-г эрчимжсэн байдлаар хөгжүүлэх, таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий эрх зүйн баримт бичгүүд, түүний хэрэгжилт сайжрах		√	Хэчнээн баримт бичиг, дүрэм журамд ямар өөрчлөлт хийх, тэдгээр нь иргэдэд яаж нөлөөлөх?
Нийслэл орчимд мал аж ахуй эрхлэгчдэд технологийн болон онолын мэдлэг олгох сургалт, үзүүлэх сургууль, судалгаанд хамрагдах хүний тоо нэмэгдэх	√		Ямар сургалт явуулж, хэдэн хүн хамруулах, үр дүн нь юу болох?
Нийслэл орчимд бэлчээрийн МАА хөгжүүлэхэд бэлчээрийн даац, ашиглалт сайжрах		√	Хэдэн хувиар яаж сайжрах, гол үр нөлөө нь юу болох?
Нийслэлийн эрчимжсэн МАА-аас авах бүтээгдэхүүний ашиг шим, сүүн бүтээгдэхүүний хэмжээ өсөж хүн амыг эрүүл хүнсээр хангах хангамж нэмэгдэх	√	√	Сүүн бүтээгдэхүүн хэдэн хувиар өсөх, борлуулалт яаж нэмэгдэх?
Ногоон тэжээл тариалалтын чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт бууралт, хөрөнгө оруулалтын нийгмийн үр ашиг нэмэгдэх		√	Хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээнүүдийг хийх үү, яаж илэрхийлэх?
Бэлчээрийн талбайгаа шинэ технологиор тарималжуулсан иргэн, ААН, хоршоод шинээр бий болох	√		Хэчнээн хоршоо, иргэд бий болох, хамрагдах?
Бэлчээрийг тарималжуулах шинэ технологиор ногоон тэжээл үйлдвэрлэх чиглэлээр хэрэгжүүлсэн гадаад, дотоод, олон улсын байгууллагуудын төслүүд, түүний үр нөлөө сайжрах		√	Тус хөтөлбөр хэрэгжсэнээр бусад төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд яаж нөлөөлөх?

Тус хөтөлбөр нь хэдийгээр 2015 онд батлагдаж 2 жил гаруй хэрэгжиж байгаа ч үйл ажиллагаа нь жигдрээгүй буюу эхлэлийн шатанд байгаа тул үр дүнд суурилсан бус, үйл ажиллагаанд тулгуурласан үнэлэлт дүгнэлт хийх нь илүү тохиромжтой гэж үзлээ.

**Хүснэгт 2.14. Хөтөлбөрийн үйл ажиллагаанд тулгуурласан үнэлэлт**

Асуудлууд	Маш их	Их	Дунд зэрэг	Бага зэрэг	Маш муу
Төсөл/ хөтөлбөр хэрэгжсэнээр шинэ дэвшилтэт технологи, мэдлэг, ноу-хау нэвтэрч хөтөлбөрийн хэрэгжилтэд эергээр нөлөөлөх эсэх		√			
Төсөл/ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чадварлаг, туршлагатай удирдлага, боловсон хүчнээр бүрэн хангагдсан эсэх				√	
Төсөл/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд холбогдох бүх талуудын оролцоог хангасан эсэх				√	
Төсөл/хөтөлбөрийн тайлагнал, хяналтын тогтолцоог оновчтой төлөвлөсөн эсэх					√
Төсөл/хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх хариуцлага, оролцооны тогтолцоог бүрэн тусгасан эсэх				√	
Төсөл/хөтөлбөр хэрэгжих хууль эрх зүйн болоод бодлогын дэмжлэг туслалцаа хангалттай бий эсэх	√				
Төсөл/хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд нөлөөлөх хатуу, зөөлөн дэд бүтцийн асуудлуудыг оновчтой шийдэж тусгаж чадсан эсэх			√		
Төсөл/хөтөлбөрийн хэрэгжилт байгаль орчин, ногоон эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл, үр дүнг бодитойгоор тусгаж чадсан эсэх			√		
Төсөл/хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлуудыг бүрэн тусгаж, хангаж чадсан эсэх				√	
Төсөл/хөтөлбөрийн хэрэгжилтэд учрах эрсдэлүүдийг зөв тооцоолж хөтөлбөрт тусгаж өгсөн эсэх				√	

Дээрх **Хүснэгт 2.14-д үзүүлсэн** үнэлгээнээс үзэхэд тус хөтөлбөрийг анх санаачлан боловсруулахдаа үр дүнг дутуу тооцож боловсруулсан, зах зээлийн судалгаа шинжилгээ, эрэлт хэрэгцээг сайн судлаагүй, холбогдох талуудыг оролцуулж санал бодлыг тусгаагүй зэрэг дутагдалтай асуудлууд их байсан нь хөтөлбөрийн боловсруулалт, цаашдын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх боломжийг олгосон байна. Тухайлбал:

- Газрын хөрс эвддэггүй, бэлчээрийн талбайг хагалдаггүй, үрлэж тариалах дэвшилтэт технологийг нэвтрүүлж нутагшуулах ажил өнөөг хүртэл эхлээгүй байна. Энэ нь хөтөлбөрийн хэрэгжилтэд учрах саад бэрхшээл, асуудлуудыг нарийн тооцож төлөвлөөгүйгээс шалтгаалсан байж болно.
- Малчид, фермерүүдэд чиглэсэн олон ажил огт хийгдээгүй, ялангуяа тэдний нэгдэж нийлэх, хамтран хоршоо байгуулах ажил эхлээгүй байна.
- Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах ажил барилга, техник тоног төхөөрөмжийн хувьд бэлэн болсон ч, ажиллах хүч, зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөлт хийгдээгүй байна.
- Хөтөлбөрийн удирдлага буюу Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨҮГ-ын зүгээс хөтөлбөрийн хэрэгжилтэд идэвх, санаачлаг багатай хандсан нь харагдаж байна. Энэ нь нэг талаас байгуулагдаад удаагүйтэй, нөгөө талаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө байхгүйтэй холбоотой байж болно.



- Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа бараг дундаа орж байхад ихэнх ажлыг судлах, боловсруулах, төлөвлөх түвшинд явж байгаагаас харахад тухайн хөтөлбөр хугацаандаа хэрэгжиж чадах эсэх нь эргэлзээтэй байна.
- Төсвийн хөрөнгөөр их хэмжээний техник, тоног төхөөрөмж худалдан авсан ч ашиглагдахгүй байгаа нь хөрөнгө мөнгө үргүй зарцуулагдах, ашиглан шамшигдуулах нөхцөл бүрдүүлж болзошгүй байна.

### **“Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийн хувьд өгөх санал, зөвлөмж**

1. Мэргэжлийн байгууллагаар нарийвчилсан үнэлгээ, судалгаа хийлгэж цаашид авч хэрэгжүүлэх ажил, үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан гаргаж хэрэгжүүлэх,
2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг эрчимжүүлэх, энэ салбарт нэвтрүүлэх үүднээс тус хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг мэргэжлийн холбоодод хариуцуулан, нийслэлийн төсвөөс их зардал гаргахгүйгээр хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх боломжуудыг ашиглах,
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨҮГ-ын удирдлага, боловсон хүчинд мэргэжлийн хүмүүсийг түлхүү хамруулах, тэдний үүрэг, хариуцлага, ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодотгож хариуцлага тооцдог байх, тайлан, төлөвлөгөө боловсруулах арга барилд суралцуулах,
4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх,
5. Хөтөлбөрийн хэрэгжилт, төсөв, хөрөнгийн зарцуулалт зэрэгт тавих хяналт шалгалт, мониторингийн ажлыг тогтмол хийж байх,
6. Хөтөлбөрийн хүрээнд иргэдэд түрээслэх, ашиглуулах, өөрсдөө боломжийн хирээр ашиглаж ашиг орлого олох чиглэлд санаачилгатай ажиллах,
7. Зөвхөн гадаадын мэргэжилтний заавраар бус хөтөлбөрийн хэрэгжүүлэгчийн хувьд санаачилгатай ажиллах, бололцоо боломжуудыг сайн ашиглах, бусад төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулах, хамтран ажиллах боломжуудыг судлан хэрэгжүүлэх.

### **2.4.3. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ**

<b>Төслийн зорилго:</b>	Байгаль орчинд ээлтэй, бизнесийн таатай орчин бүхий, орчин үеийн үлгэр жишээ Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлж, Монгол улсын барилгын материал үйлдвэрлэлийн салбарын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулах
<b>Батлагдсан огноо:</b>	НИТХ-ын 2014 оны 148 тогтоол
<b>Хэрэгжүүлэх үе шат:</b>	2014-2024
<b>Санхүүжилтийн эх үүсвэр:</b>	Нийслэлийн төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, Төр, хувийн хэвшлийн түншлэл
<b>Хэрэгжүүлэгч:</b>	Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ
<b>Судалгааны хамрах хүрээ:</b>	Төслийн 2014-2016 оны үйл ажиллагаа
<b>Судалгааны аргачлал:</b>	Баримт бичгийн судалгааны арга ашигласан.
<b>Мэдээллийн эх сурвалж:</b>	Төслийн 2016-2017 оны хэрэгжилтийн тайлан

### **Төслийн хэрэгжилтийн ерөнхий байдал**

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк (НБМҮТГ) төслийн 2016-2017 онд хийсэн гол үйл ажиллагааг доор үзүүлэв.

Тус паркт хамрагдах үйлдвэрүүдийн төслийг эхний байдлаар шалгаруулж, эхний 6 үйлдвэрийн шавыг тавьж, 2018 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Сонгон шалгаруулалтад төслийн ажиллах хүчний 80 хувийг Налайх дүүргийн иргэдээс авах шаардлага тавьжээ. Парк эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 7 сард авч, одоогийн байдлаар 15 үйлдвэрийг сонгон шалгаруулалтад оруулсан. Уг төслийг Налайх дүүрэгт байгуулахаар төлөвлөж буй Барилгын материалын худалдааны төв, Улаанбаатар тээвэр логистикийн төвийн төслүүдтэй харилцан уялдаатай хөгжүүлэхээр төлөвлөсөн. Эхний ээлжийн үйлдвэрүүдийн барилгыг барихад шаардагдах эрчим хүчний асуудлыг бүрэн шийдсэн. Паркийн оффис байр, 16-20 тн/цаг хүчин чадалтай 2 гүний худаг барьж ашиглалтад оруулсан. Паркийн газрын хил зурвасаар 2 км сайжруулсан шороон зам тавьж, эзэмшлийн замын нийт урт 13.2 км болжээ.

Паркийн зорилтот зах зээл нь барилгын материал үйлдвэрлэгчид юм. Монгол улс барилгад өргөн хэрэглэгддэг 45 нэр төрлийн бүтээгдэхүүний 40 хувийг дотооддоо, үлдсэн 60 хувийг импортын бүтээгдэхүүнээр хангаж байна. Харин НБМҮТП байгуулагдсанаар дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ 70 хүртэл хувиар өсөх боломжтой.

### "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ

1. Улсын хэмжээнд барилгын материалын 300 гаруй үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаагаас энэ паркт 40-50 үйлдвэрийг байршуулахаар тусгасан байна. Гэвч эдгээр үйлдвэрийг хэрхэн сонгох, шалгуур үзүүлэлт, хөнгөлөлт дэмжлэг зэрэг нь тодорхой бус эсвэл оновчгүй байгаа нь барилгын материал үйлдвэрлэгчдийг энд байршиж үйлдвэрээ явуулах сонирхлыг татах арга механизм болж чадахгүй байна.
2. Паркийн эзэмшил 120 га, цаашид сунгах боломжтой 130 га газрыг тус паркийн нэр дээр шилжүүлэн үйл ажиллагааг жигдрүүлбэл гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татахад дөхөм болно.
3. Паркийн эрх зүйн статусыг өөрчилж, хувийн хэвшил, холбоодод менежментийн гэрээгээр шилжүүлэх зэрэг төслийг хөгжүүлэх, нийслэлийн төсөвт дарамт учруулахгүй байх оновчтой арга механизмыг судлах хэрэгтэй.

#### 2.4.4. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн (ОНӨТҮГ) төсөл

Төслийн зорилго:	Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрийг хамгаалах, Ногоон байгууламжийг нэмэгдүүлснээр хотын агаарын бохирдлыг бууруулах, Хотын хүн амыг эрүүл, аюулгүй, тохилог орчинд чөлөөт цагаа өнгөрөөх /гүйх, алхах, дугуй унах/ боломжийг олгох
Батлагдсан огноо:	НИТХ-ын 2011 оны 53 тогтоол
Хэрэгжүүлэх үе шат:	2010- 1-р үе шат 2011-2013 1А үе шат 2014-2015 2-р үе шат 2016-2017 3-р үе шат 2018-2020 4-р үе шат
Санхүүжилтийн эх үүсвэр:	Нийслэлийн төсөв, Өөрийн босгосон хөрөнгө оруулалт, Итгэлцлийн сан, Гадаад, дотоодын хандив, тусламж
Хэрэгжүүлэгч:	Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн ОНӨТҮГ
Судалгааны хамрах хүрээ:	Төслийн 2014-2016 оны үйл ажиллагаа
Судалгааны аргачлал:	Баримт бичгийн судалгааны арга ашигласан.
Мэдээллийн эх сурвалж:	Төслийн 2014-2015 оны ажлын танилцуулга,

## Төслийн хэрэгжилтийн ерөнхий байдал

Үндэсний цэцэрлэгт хүрээлэн (ҮЦХ) төслийн хүрээнд Улаанбаатар хотын Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр хүртэлх, Туул голын дагуу 1280 га талбайд цэцэрлэгт хүрээлэн баригдахаар төлөвлөгдсөнөөс 183 га талбайн ерөнхий төлөвлөгөө, зураг гарч 2017 оны байдлаар эхний ээлжийн 30 га талбайн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн хийж ашиглалтад өгсөн ба дараагийн 25 га талбайн тохижилтын ажлууд хийгдэж байна. ҮЦХ ОНӨТҮГ нь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх чиглэлийн үйл ажиллагаануудыг тогтмол хийдэг байна. ҮЦХ ОНӨТҮГ-аас жил бүр бүх нийтээр мод тарих үндэсний өдөр, Улаанбаатарын өвлийн наадам, The colour Event UB, Эх дэлхийн цаг зэрэг олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээг зохион байгуулдаг.

ҮЦХ-ийн Ерөнхий төлөвлөгөөний дагуу жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Төсвийн Ерөнхийлөн Захирагчтай гэрээ байгуулан ажилладаг ба нийслэлийн төсвөөс жил бүр 3,5-3,6 тэрбум төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн аудитын газраас хийсэн Аудитын тайлангаас үзэхэд зардлын хэтрүүлэл, буруу зарцуулалт зэрэг зөрчил дутагдал бага гардаг байна.

## Үндэсний цэцэрлэгт хүрээлэн төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ

1. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд хоцрогдолтой байгаа нь нийслэлийн төсөв, санхүүгийн нөхцөл болон нийслэлийн удирдлагын бодлого шийдвэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс голлон шалтгаалжээ хэмээн үзэж байна.
2. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн удирдлагын зүгээс өөрийн үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлэх, өсгөх чиглэлд санал санаачилгатай ажиллаж байгаа нь 2015 онд 1,1 тэрбум төгрөг, 2016 онд 5,1 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны орлого олсноос тодорхой харагдаж байна. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн санхүүжилтийг 100 хувь нийслэлийн төсвөөс гаргадгийг тодорхой үе шаттайгаар багасгаж, 2020 он гэхэд өөрийгөө санхүүжүүлдэг тогтолцоонд шилжүүлэх боломжтой байна.
3. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд түрээсээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд, иргэдээс түрээсийн төлбөрийн хэмжээг бууруулах, орчин нөхцөлийг сайжруулах талаар тавьж буй гомдол, саналыг шуурхай шийдвэрлэж байх нь цаашид олон аж ахуйн нэгж, байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах, төсөл амжилттай хэрэгжүүлэхэд чухал түлхэц болно.
4. Тус төслийн нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг Хүснэгт 2.15-д харуулсан үзүүлэлтээр тооцож үзэв. Үнэлгээнд сонгосон 7 үзүүлэлтийн 3 нь дундаас дээш үнэлгээтэй байгаагаас дүгнэхэд тус төсөл нь нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлж байна.

## Хүснэгт 2.15. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн төслийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Үзүүлэлт	Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Маш бага
Нийслэлийн ногоон байгууламжид үзүүлэх нөлөөлөл		√			
Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад үзүүлэх нөлөөлөл			√		
Иргэдийн тав тухтай амарч зугаалах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд үзүүлэх нөлөөлөл	√				
Нийслэлийн сайн засаглал, удирдлагын тогтолцоог сайжруулахад үзүүлэх нөлөөлөл				√	
Нийслэлийн иргэдийн эрүүл мэнд, орчин нөхцөлд үзүүлэх нөлөөлөл				√	
Төр-иргэний харилцаа, ойлголцлыг бататгах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулахад үзүүлэх нөлөөлөл				√	

Иргэдийн экологийн боловсрол, байгаль орчны танин мэдэхүй, мэдлэгийг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөөлөл			√		
--	--	--	---	--	--

## 2.5. Бүлгийн дүгнэлт

2016 оны гүйцэтгэлээр Улаанбаатар хотын төсвийн урсгал орлого 506 тэрбум төгрөг, харин урсгал зарлага нь 680 тэрбум төгрөг болж урсгал төсвийн алдагдал нь 170 гаруй тэрбум төгрөг болжээ. Урсгал төсвийн алдагдал ийнхүү их хэмжээтэй байгаа нь Улаанбаатар хот өөрөө бие даан хөрөнгө оруулалтын хэрэгцээгээ хангах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийг сайжруулахтай холбогдуулан боломжит эх үүсвэрүүдээ эргэн нэг харах хэрэгтэй юм. Үүнд:

- Өөрийн буюу орон нутгийн хөрөнгө оруулалт
- Орон нутгийн хөгжлийн сан
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт
- Гадаадын зээл тусламж
- Өрийн бичиг, бонд
- Төр ба хувийн хэвшлийн түншлэл буюу концесс
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт зэрэг болно.

Юуны өмнө ойрын 1-3 жилийн хугацаанд хотын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж тийм ч сайнгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Улаанбаатар хотын өөрийн хөрөнгө оруулалтын боломжийн талаар дээр дурдсан. Улсын төсвийн алдагдал их хэмжээтэй, төсвийн нөхцөл байдал хүнд байгаагийн улмаас Орон нутгийн хөгжлийн сан болон Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь бүү хэл урьд жилүүдийн түвшинд ч хадгалан үлдэх боломж тун бага байна.

Олон улсын валютын сангийн хөтөлбөр манай улсад хэрэгжиж эхлээд жил гаруй болж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын шугамаар орж ирэх гадаадын зээл, тусламжийн хэмжээ, зориулалт үндсэндээ ойрын 3 жилийн хугацаанд төдийлөн өөрчлөгдөхгүй, нэмэгдэхгүй гэж ойлгогдож байна. Мэдээж жижиг хэмжээний буцалтгүй тусламжууд шинээр орж ирэх боломжтой боловч энэ нь асуудал шийдэх хэмжээнд байхгүй гэдэг нь ойлгомжтой.

Монгол Улсын Өрийн удирдлагын хуулиар заасан Засгийн газрын өрийн дээд хязгаар өнөөдрийн байдлаар хэтэрчихсэн байгаа, нөгөө талаас ОУВС-тай байгуулсан хөтөлбөрт зааснаар шинээр ямар нэгэн өр тавих, өр нэмэгдүүлэх, мөн түүнчлэн концессын гэрээ шинээр байгуулах нь хөтөлбөр хэрэгжих ойрын 3 жилийн хугацаанд боломжгүй байгаа юм.

Гэр хорооллын дахин төлөвлөлт, их барилга, нийтийн тээвэр, эрчим хүч, дулааны хангамж, хог цэвэрлэх, боловсруулах зэрэг угаасаа үнэ, тарифын таатай нөхцөлд эдийн засгийн хувьд үр ашигтай байж болох олон асуудлыг дотоод, гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдэж болох боловч эдгээр төслүүдийг босгох, олон нийтэд санал болгох, тэдний итгэл үнэмшлийг бүрдүүлэх талаар Улаанбаатар хотын удирдлагаас ихээхэн идэвх зүтгэл гаргах нь зайлшгүй.

Улаанбаатар хотын хөгжлийн зорилтыг хангахад чиглэгдсэн санхүүжигдэх боломжтой хөрөнгө оруулалтын төслүүдийг судлан боловсруулах, ач холбогдол болон эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлэх, эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн стратегийг тодорхойлох нь эдгээр төслүүд бодитоор хэрэгжих суурь нөхцөлүүд болно.

Иймд төслүүдийг эрэмбэлэх болон санхүүжилтийн стратегийг боловсруулахад тодорхой хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалуудыг хэрэглэх шаардлагатай бөгөөд энэ судалгааны тайлангийн дараагийн хоёр бүлэгт холбогдох аргачлалуудын саналыг танилцуулах болно.

## БҮЛЭГ 3. САНХҮҮЖИЛТИЙН СТРАТЕГИ

Энэ бүлэгт Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-уудыг Улаанбаатар хотод хангахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүдэд шаардлагатай санхүүжилтийг хэрхэн татах, бий болсон нөөц бололцоогоо үр дүнтэйгээр, хамгийн үр ашигтайгаар хэрхэн зарцуулахад дэмжлэг болох санхүүжилтийн стратегийг тодорхойлж санал болгосон.

### 3.1 Улаанбаатар хотын хөгжлийн зорилтыг хангахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүд ба ТХЗ-уудын уялдаа

УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг, Засгийн газрын 2016 оны 174 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн 90 төслийг баталсан. Эдгээр төсөл, хөтөлбөрүүдийн 2017 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтийн явц, өөрчлөлтийн талаарх мэдээлэл нь НЗДТГ-аас шинэчлэгдэн боловсруулагдаагүй байгаа учраас батлагдсан үеийн мэдээллийг энд ашигласан болно.

Эдгээр 90 төслийг ТХЗ-уудтай хэрхэн уялдаж байгааг үнэлсэн бөгөөд ингэхдээ Шведийн Стокхолмын Байгаль Орчны Институтийн санал болгосон бодлогын хоорондын уялдааг үнэлэх аргачлалыг хэрэглэсэн болно. Бид энэхүү аргыг хэрэглэхдээ төслүүдийг ТХЗ-той уялдуулах байдлаар хялбарчлан ашиглахаар сонгосон. Ингэхдээ матрицын мөрүүдэд төслүүдээ, баганад ТХЗ-ыг авч хоорондын уялдаа, нөлөөллийг нь шинжилсэн. Шведийн санал болгосон дээрх аргыг Үндэсний Хөгжлийн Газар (ҮХГ) улсын хэмжээнд одоо хүчинтэй байгаа бодлогын баримт бичгүүдийг үнэлэхэд хялбаршуулан ашиглахаар шинэ аргачлал боловсруулж байгаа бөгөөд тэрхүү аргачлалд санал болгосон аргыг бид энд туршин авч үзсэн болно.


ҮХГ-ын дээрх аргачлалын дагуу доор харуулсан 7 түвшинтэй оноогоор харилцан нөлөөллийн хүчийг илэрхийлсэн.

#### Бодлогын зорилтуудын хоорондын уялдаа, нөлөөг тодорхойлох оноо

Оноо	Онооны утга агуулга
+3	Харьцуулж буй зорилтын хэрэгжилтэд шууд хүчтэй нөлөөтэй, шууд хүчтэй уялдаатай.
+2	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд тус болно.
+1	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг яваандаа бүрдүүлнэ.
0	Эерэг болон сөрөг ямар нэг нөлөө үзүүлэхгүй.
-1	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх сонголтуудыг хязгаарлана.
-2	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлнө.
-3	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй болгоно, хүчтэй эсрэг нөлөөтэй.

Эх үүсвэр: ҮХГ, 2017

Энэ аргачлалаар дээр дурдсан төслүүдийг үнэлж үзэхэд ТХЗ-той хэрхэн уялдсан байдлыг дараах Дүрслэл 3.1-ээс харж болно. Харин

**Дүрслэл 3.1: Төслүүдийн Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан байдал**

Эх үүсвэр: УБАК, 2017

**Тайлбар:** Зураг дээрх X/Y тэмдэглэгээ нь: X–тухайн ТХЗ-ын уялдаанд өгсөн онооны нийлбэр, Y–тухайн ТХЗ-той уялдсан төслийн тоо.

Тухайлбал, дээрх 90 төслүүдээс 39 төслүүд нь ТХ-ын 1-р зорилго буюу ядуурлыг бууруулах зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Мөн ТХ-ийн Эрүүл мэндийг дэмжих, Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих, баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, Тэгш бус байдлыг бууруулах, Чанартай боловсролыг дэмжих, Инновац дэд бүтцийг хөгжүүлэх, Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, Өлсгөлөнг зогсоох, Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлт зэрэг (3, 11, 6, 10, 4, 9, 7, 2, 8-р) зорилгуудыг хангахад эдгээр 90 төслүүдийн ихэнх нь чухал нөлөө үзүүлэхээр байна.

Харин ТХЗ-ын 5, 13, 15, 16, 17-р зорилгуудтай эдгээр төслүүд харьцангуй бага уялдаатай харагдаж байгаа тул цаашид Улаанбаатар хотын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээнд эдгээр зорилгуудыг хангахад түлхүү анхаарч үйл ажиллагаа болон санхүүжилтээ чиглүүлэх шаардлагатай байна.

Нөгөө талаас, ТХЗ-тай хамгийн их уялдаатай байгаа төслүүдийг авч үзвэл, Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах нарийвчилсан судалгаа, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэл хийх судалгааны төслүүд, мөн түүнчлэн Эмээлтийн болон Багануурын үйлдвэр технологийн паркуудыг барьж байгуулах төслүүд, гэр хорооллын хог хаягдал, ариун цэврийн байгууламжаас үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүд нь ТХЗ-ыг хангахад хамгийн өндөр нөлөөтэй төслүүд байна. Өөрөөр хэлбэл, эдгээр төслүүдийг нэн тэргүүнд авч үзэн, бололцоот санхүүжилттэй уялдуулж хэрэгжүүлбэл ТХЗ-ыг хангахад нэлээд чухал түлхэц үзүүлэхээр харагдаж байна.

**3.2 Төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт**

Улаанбаатар хотод ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээг тооцоолохдоо дээрх 90 төслүүдийн ТХЗ-уудтай хэрхэн уялдаж байгааг үнэлсэн эрэмбийн дагуу (1) хамгийн сайн уялдсан буюу 5-аас дээш оноотой эхний 32 төсөл, (2) 2-оос дээш оноотой эхний 64 төсөлд шаардлагатай санхүүжилтийн хэмжээг дараах байдлаар тооцоолов.

### Хүснэгт 3.1: ТХЗ-той хамгийн их уялдсан төсөл, хөтөлбөрүүдэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, сая төгрөгөөр

Уялдаагаарх зэрэглэл	Төслийн код	Төслийн нэр	Нийт төсөвт өртөг
1	1.3.4-40	Сэргээгдэх эрчим хүчний нарийвчилсан судалгаа хийх, технологи сонгох, ТЭЗҮ боловсруулах төсөл	2,000
2	2.2.1-48	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэл хийх замаар өргөтгөх төслийн зураг төсөв	6,000
3	6.2.1-89	Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл	2,000
4	6.2.1-90	“Багануур” Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн зураг төсөв	2,000
5	1.3.2-38	Гэр хорооллын хог хаягдал, ариун цэврийн байгууламжаас үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах төсөл	5,000
6	1.1.2-6	Мал эмнэлгийн лабораторийн болон үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл	1,903
7	2.1.1-44	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл (24 байршил)	753,205
8	6.2.1-88	Налайхын Барилгын материалын Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл	2,000
9	1.1.1-1	Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр	255,666
10	1.1.1-2	Төвөөс алслагдсан бүсийн иргэдэд гамшгаас хамгаалах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх /аврах, гал унтраах анги/	24,300
11	1.2.2-21	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн төвийн барилга барих	983
12	1.3.5-42	“Эко парк” байгуулах төсөл	3,000
13	1.2.1-15	Нийслэлийн Хүрээ амаржих газар барих төсөл	18,810
14	1.2.1-16	Нийслэлийн 4 дүгээр амаржих газар барих төсөл	19,000
15	1.2.2-19	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих төсөл	7,500
16	1.2.2-25	Түргэн тусламжийн төвийн салбар пункт барилга барих төсөл	5,000
17	1.2.4-31	“Хороо бүрд сургууль” багц төсөл	158,420
18	1.3.6-43	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт болон цэцэрлэгт хүрээлэнг нэмэгдүүлэх төсөл	70,467
19	6.1.1-84	Улаанбаатар хотын олон улсын ачаа тээврийн нэгдсэн логистик төв байгуулах төсөл	147,922
20	6.1.1-85	Улаанбаатар хотын баруун ачааны тээврийн нэгдсэн логистик төв байгуулах төсөл	122,550
21	1.1.1-3	Болзошгүй гамшгийн үед иргэд түр цугларах талбай байгуулах төсөл	44
22	1.1.1-5	Болзошгүй гамшгийн үед иргэдийг хоргодох байраар хангах төсөл	1,400
23	1.2.1-13	Хүүхдийн эмнэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх багц төсөл	21,000
24	1.2.2-20	Ахмад настны асрамжийн төвийн барилга барих төсөл	983
25	1.2.2-23	Туул тосгоны эрүүл мэндийн төвийн барилга барих төсөл	3,000

Уялдаагаарх зэрэглэл	Төслийн код	Төслийн нэр	Нийт төсөвт өртөг
26	1.2.2-28	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга барих төсөл	27,000
27	1.2.3-29	“Хороо бүрд цэцэрлэг” багц төсөл	93,356
28	1.2.4-35	“Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор” багц төсөл	136,840
29	1.3.4-39	Улаанбаатар хотын сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан-техникийн шинэчлэлтийн төсөл	60,898
30	2.1.2-45	Газар шинэчлэн зохион байгуулалтын багц төсөл (38 төсөл)	517,100
31	2.1.3-47	Түрээсийн орон сууцыг хөгжүүлэх төсөл	354,900
32	4.1.3-69	Дагуул, хаяа хот, тосгодын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах багц төсөл	1,629
<b>Нийт дүн (эхний 32 төслийн хувьд)</b>			<b>2,825,877</b>
33	1.1.1-4	Болзошгүй гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх төсөл	450
34	1.2.1-12	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төв байгуулах төсөл	9,436
35	1.2.2-18	Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга барих төсөл	2,830
36	1.2.2-22	Налайх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих төсөл	15,000
37	1.2.2-26	Ахмадын сувиллын барилга барих төсөл	5,800
38	1.2.2-27	Ахмадад үйлчлэх халамж, асрамжийн төвийн барилга барих төсөл	27,000
39	1.2.3-30	Хүүхэд хөгжил хамгааллын төвийн барилга барих төсөл	27,000
40	1.2.4-32	Сургуульгүй 18 хорооны судалгаа	5,000
41	1.3.4-41	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлэг сайжруулах хөтөлбөр	22,031
42	2.2.1-49	Туул усан цогцолбор барих төслийн зураг төсөв	3,000
43	2.2.1-51	Баруун дүүрэг, 3,4-р хороолол, Тасган, Зүүн хойд бүсийн усан сангуудыг хооронд нь 12,0км шугамаар холбох, Зүүн хойд бүсийн усан санг өргөтгөх төсөл	26,955
44	2.2.1-52	Багахангай дүүрэгт усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийх төсөл	650
45	2.2.2-53	Төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл	36,016
46	2.2.3-55	Улаанбаатар хотын Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг сайжруулах хөтөлбөр	114,000
47	2.2.3-56	Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах төсөл	24,000
48	5.1.2-74	Туулын шугуй цогцолбор – Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах төсөл	3,000
49	6.1.1-86	Улаанбаатар хотод улс, хот хоорондын нийтийн тээврийн авто буудал байгуулах төслийн ТЭЗҮ боловсруулах төсөл	900
50	1.2.1-14	Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах байгууллагын хэрэгцээг тодорхойлох, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр нэгдсэн судалгаа хийх төсөл	2,000
51	2.2.3-57	Улаанбаатар хотын цахилгааны “Их тойруу” төсөл	3,300
52	2.2.3-58	УБ хотын Түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн төсөл	184,200



Уялдаагаарх зэрэглэл	Төслийн код	Төслийн нэр	Нийт төсөвт өртөг
53	2.2.4-59	Авто зам, гүүрний шинээр барих болон өргөтгөл шинэчлэлтийн багц төсөл	285,840
54	2.3.1-62	Хотын тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр	530,530
55	2.3.1-63	Нийтийн тээврийн парк шинэчлэлт	322,308
56	4.1.2-68	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл (Дэд төв)	180,915
57	1.1.2-7	Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл	7,026
58	1.1.2-8	Замын цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл	3,900
59	1.1.2-11	Алслагдсан хороодод Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл	6,000
60	1.2.2-17	Шүд, эрүү нүүрний төвийн барилга барих төсөл	6,000
61	1.2.2-24	Наркологийн эмнэлгийн барилга барих төсөл	6,235
62	2.2.2-54	Орон сууцны хорооллын доторх гадна шугам сүлжээний төсөл	15,045
63	3.1.1-64	Хан-Уул дүүргийн нийгмийн үйлчилгээний төв барих төсөл	3,820
64	5.1.2-73	Усан парк, амьтны хүрээлэн – зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах төсөл	2,000
<b>Нийт дүн (эхний 64 төслийн хувьд)</b>			<b>4,708,063</b>

Эх үүсвэр: УБАК

Дээрх хүснэгтээс харахад эхний 32-т эрэмбэлэгдсэн төслүүдэд нийт 2,825 тэрбум төгрөг, эхний 64-т эрэмбэлэгдсэн төслүүдэд нийт 4,708 тэрбум төгрөг зарцуулагдах шаардлагатай байна.

### 3.3 Стратеги 1: Санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх

Монгол улсын эдийн засгийн байдал сайнгүй байгаа өнөө үед төсвийн урсгал зардлыг бууруулах, ойрын хугацаанд өндөр үр өгөөж өгөх төслүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд шаардлагатай зээлийн болон бусад нэмэлт эх үүсвэрүүдийг татаж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх нь нэн тэргүүний асуудал болсон.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, зам, барилга байгууламжийн жагсаалтыг харвал нийт 203,534.8 сая төгрөгийг НИТХ-аар баталсан байна. Үүнээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт чиглэсэн зөвхөн 2 төсөл байсан ба төсөвт өртөг нь 641.6 сая төгрөг буюу нийт хөрөнгө оруулалтын 0.3 хувь байсан. Тухайлбал: 1) Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк (СХД)-д 417.6 сая төгрөг, 2) Налайхын Барилгын материалын үйлдвэр, технологийн паркийн бүтээн байгуулалтад 224.0 сая төгрөг төсөвлөсөн. Бусад бүх төсөл, хөтөлбөрүүдийн хувьд эдийн засгийн үр өгөөж нь тун бага байна.

Сүүлийн үеийн шинжлэх ухааны хурдацтай хөгжлийн үр дүнд дэвшилтэт шинэ технологиуд нь олон салбарт, өргөн хэрэглээнд нэвтэрч байна. Олон улсын хөгжлийн хурдацтай хөл нийлүүлэн урагшлахын тулд Улаанбаатар хотын хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэлийн салбар дотроо дэлхийд эрчимтэй хөгжиж буй топ компаниудаас шууд хөрөнгө оруулалт татах, үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, ноу-хауг нэвтрүүлэх талаар хөрөнгө оруулалтын бодлогод тусгах нь зүйтэй. Тухайлбал, Малайз улс нь тэргүүлэх чиглэлийн салбар дотроо дэлхийд эрчимтэй хөгжиж буй топ 100 компаниудын сонирхлыг өөрийн орон руу татах гарааны төслийг хэрэгжүүлэн ажилласан сайн туршлагатай юм.

Улаанбаатар хотын хувьд нар, салхины сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлтийн сүүлийн үеийн дэвшилтэт лаборатори байгуулах, мах боловсруулах, сүү, цагаан идээ

боловсруулах, экологийн цэвэр хүнсний ногоо боловсруулах зэрэг өндөр технологийг дэлхийд тэргүүлэх компаниудаас худалдан авч дотоодын ААН-үүдэд хөнгөлөлттэй үнээр худалдах, технологийн зааварчилгаа сургалтууд явуулах, тэдгээр үйлдвэрлэлийн олон улсын чанарын стандартыг нэвтрүүлэх, аялал жуулчлалын бизнесийн ноу-хауг тухайн салбарт тэргүүлэгч орнуудаас авч хөгжүүлэх, дотоодын ААН-үүдийг олон улсын түвшинд хүргэх гэх мэт байж болно. Ийм үйл ажиллагаанууд нь эдийн засгийн ирээдүйтэй салбарын гараа нь болох ба эдийн засагт цаашдаа нэмүү өртгийн гинжин холбоо үүсгэж, өсөлтийн шинэ талбар, бизнесийн шинэ боломжуудыг үүсгэх юм.

Зах зээлийн эдийн засгийн тулгуур зарчмын дагуу бараа, үйлчилгээний хэрэглээг тогтвортой өсгөх замаар аливаа орны эдийн засаг хэвийн явагддаг. Гэтэл хэрэглээний хэмжээний хязгааргүй өсөлт нь үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагддаг байгалийн баялгийн зарцуулалтыг хэт их болгож, байгаль экологийн тэнцвэрт байдлыг ноцтой алдагдуулахад хүргэсэн. Одоо дэлхий нийтэд тогтвортой ногоон хөгжлийг дэмжсэн эдийн засгийг хөгжүүлэх шаардлагатай байгаа талаар ихээр яригдаж байна.

Тиймээс санхүүжилтийн бодлогыг өндөр үр өгөөжтэй, зөв байлгахын тулд ерөнхийдөө *нэгдүгээрт*, хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн зохицуулалт, *хоёрдугаарт*, хөрөнгө оруулалтын төслийн удирдлагын тогтолцоо, *гурвдугаарт*, санхүүжилтийн тогтолцоонд иргэд, олон нийтийн оролцоог хангах, *дөрөвдүгээрт*, Улаанбаатар хотын төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх гэсэн чухал хүчин зүйлүүдийг нарийвчлан авч үзсэн.

### 3.3.1 Дэд стратеги: Хууль эрх зүйн орчныг сайжруулах

Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн орчныг сайжруулах, шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг босгох, хөрөнгө оруулалтын төслийн удирдлага, менежментийг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэхэд Улаанбаатар хотын хууль эрх зүйн орчныг өнөөгийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх нь чухал ач холбогдолтой болж байна.

Хотын хөгжлийн асуудлаар, нэн ялангуяа санхүүжилтийн эх үүсвэр босгох, барилга, хот байгуулалт, цахилгаан эрчим хүч, дулаан, зам тээвэр гэх мэт олон чухал асуудлаар Улаанбаатар хот дангаараа шийдвэр гаргах, түүнийгээ хэрэгжүүлэх, гүйцэтгэх боломж хязгаарлагдмал байгаа юм. Салбарын яамд, Засгийн газрын бүтцийн байгууллагууд угаасаа хотын эрх мэдэлд байх ёстой олон чухал чиг үүргийг хэрэгжүүлсээр байгаа нь шуурхай, хүнд суртлаас ангид, ухаалаг зөв шийдвэр гаргахад саад болж байна. “Улаанбаатар хотын цахилгаан түгээх сүлжээ” ХК, “Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээ” ХК зэрэг байгууллагууд бодлогын хувьд салбарын яамны харьяанд, өмчлөлийн хувьд Засгийн газарт харьяалагдаж буй нь үүний нэг илрэл юм.

Засгийн газар болон Улаанбаатар хотын чиг үүргийн заагийг тодорхой нарийвчлан шинэчилж, холбогдох зохион байгуулалт болон бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг авахаас гадна Улаанбаатар хот, дүүрэг болон хороодын чиг үүргийн заагийг улам тодорхой болгож, тухайлсан чиг үүрэгт нь нийцсэн эрх мэдэл, санхүү, төсвийн эх үүсвэрийг шилжүүлэх нь нэн чухал асуудал болж байна.

Өнөөдрийн төсвийн тогтолцоогоор Улаанбаатар хот аймгуудтай, дүүргүүд сумдуудтай статусын хувьд нэг түвшинд байгаа билээ. Гэтэл хүн ам, эдийн засгийн боломжоороо дүүргүүд нь аймгуудаас ч том, хороод нь сумдын хэмжээнд, тэр бүү хэл зарим аймгаас ч том хороо байгааг зайлшгүй тооцож үзэх шаардлага бодит амьдралаас урган гарч байгаа билээ.

Үүнтэй холбогдуулан иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг аль түвшинд шийдэж байх, ямар төсөл, хөрөнгө оруулалтыг хот, дүүрэг, хороодын хэн нь шийдэж, хэрэгжүүлж, хариуцаж байх, татвар болон төсвийн санхүүжилтийг хэрхэн үүнд нийцүүлэх талаар хууль эрх зүйн хүрээнд тодорхой зааж шийдвэрлэх шаардлагатай болж байна.

Хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл сүүлийн 10-аад жил нэлээд яригдаж байгаа боловч тодорхой үр дүн өнөөг хүртэл гарахгүй байна. Энэ хуулийн төслийг ойрын хугацаанд хэлэлцүүлэх, батлуулах, энэ хүрээнд Засаг захиргааны нэгжийн тухай хуульд дагалдах өөрчлөлтүүдийг оруулахад анхаарал хандуулах нь зүйтэй.

### 3.3.2 Дэд стратеги: Хөрөнгө оруулалтын удирдлага, тогтолцооны шинэчлэл

Хөрөнгө оруулалтын удирдлага (ХОУ)-ын зөв зохион байгуулалтыг бий болгоход үйл ажиллагааны түвшний дотоод хяналтын нарийвчилсан тогтолцоо, албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх, хариуцлага тооцох тогтолцоо, алба нэгжүүдийн мэдээлэл, харилцааны олон сувагт, чөлөөтэй урсгалын тогтолцоо, төсөл хэрэгжилтийн явцын болон үр дүнгийн мэдээллийг судлах, үнэлэх, архивлах тогтолцоо, төсөл хэрэгжсэний дараа хөөн шалгах хяналтын тогтолцоо, ХОУ-ын тогтолцоог уян хатан байлгаж, тасралтгүй засаж, сайжруулах тогтолцоо гэх мэт нь хөрөнгө оруулалтын төслийн удирдлага, менежментийн гол бүрэлдэхүүн хэсэг юм.

Улаанбаатар хотын удирдлага, засаг захиргааны одоогийн бүтцэд хөрөнгө оруулалтын төслийн удирдлага, менежментийг дээрх агуулгаар бүрэн хэмжээгээр хийж гүйцэтгэдэг алба, нэгж байхгүй гэхэд болно.

“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-ын дүрэм, чиг үүрэг, орон тоо, бүтэц, зохион байгуулалтыг судалж үзэхэд энэхүү алба нь үндсэндээ барилга захиалагч, хяналтын үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн стратегид тусгагдсан төсөл хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК-ийг 2015 онд үүсгэн байгуулсан байна.

“Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК нь Улаанбаатар хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, нийслэлийн эдийн засгийн хөгжлийн стратегид тусгагдсан зарим төсөл, хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран санхүүжүүлж, хэрэгжүүлэх, төр-хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааны зохистой хэлбэрийг сонгох, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, иргэн, хувийн хэвшлийн санаачилсан төсөл хөтөлбөрийн тооцоо судалгааг хийх, дэд бүтэц, газрын харилцааг зохион байгуулах, хамтран ажиллах төслийн нэгж байгууллага, хөрөнгө оруулалтын асуудлыг хамтран шийдвэрлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах үндсэн зорилготой ажээ.

“Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК нь өөрийн үндсэн орлогоос гадна Улсын болон нийслэлийн төсвөөс төслийн хөрөнгө оруулалтад зориулан компанид хуваарилсан хөрөнгө, компанийн үнэт цаасыг гадаад, дотоод зах зээлд нээлттэй болон хаалттай хүрээнд гаргаж худалдсаны орлого, хөрөнгө оруулалтын зээл, гадаад дотоодын иргэд байгууллагаас компанийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд зориулан өгсөн хандив, тусламж, хууль тогтоомжийн хүрээнд болон НИТХ-аас зөвшөөрөгдсөн бусад орлого зэргээр хөгжлийн сан бүрдүүлэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр заажээ.

#### Дүрслэл 3.2: Нийслэлийн хөрөнгө оруулалтын шинэчилсэн тогтолцоо



Эх үүсвэр: УБАК

Энэ бүгдээс харахад Нийслэлийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын төслийн удирдлага, менежментийг үндсэнд нь хэрэгжүүлэх чиг үүргийг Нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлэхдээ гүйцэтгэлийн хяналтыг “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ-тай, концесс, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хөрөнгө санхүүжилт босгох асуудлаар “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК-тай хамтран ажиллах шаардлага зүй ёсоор тавигдах болно. Үүнээс гадна энэхүү үйл ажиллагаанд худалдан авах ажиллагаа, төрийн сангийн үйл ажиллагааны уялдааг улам боловсронгуй болгох нь энд чухал үүрэгтэйг анхаарах нь зөв юм. Энэ тогтолцооны саналыг доорх схемээр харуулав.

Нэн ялангуяа “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК болон Нийслэлийн ЗДТГ-ын хоорондын эрх мэдэл, чиг үүрэг, хариуцлагын зааг, хуваарийг зөв тогтоох нь хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Нийслэлийн Хөгжлийн бодлогын хэлтэс нь хотын удирдлага, Нийслэлийн ИТХ-д “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК-тай холбоотой дараах асуудлаар бодлогын зөвлөгөө өгч, шийдвэр гаргуулан, хэрэгжилтийг хянаж байх нь зохистой байна. Үүнд:

- 1) хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг (цаашид “мандат” гэх)-ийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох;
- 2) Корпорацаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөө буюу стратегийн баримт бичгийг батлах, түүнд өөрчлөлт оруулах тухай бүрд шаардлагатай гэж үзвэл уг баримт бичиг мандатад нийцэж байгаа эсэхэд аудит хийлгэх;
- 3) мандатын хэрэгжилтийн байдалд дүгнэлт гаргаж, НИТХ болон Засаг даргад танилцуулах;
- 4) мандатын хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн тохиолдолд Корпорацын үйл ажиллагаанд аудит хийлгэх;
- 5) удирдах зөвлөлийн гишүүнтэй гэрээ байгуулах, цалин хөлсний хэмжээг тогтоох;
- 6) удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох ажлыг зохион байгуулах;
- 7) Корпорацын тайланг хүлээн авах, хянах;
- 8) мандатыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шийдвэр гаргахад Засаг даргад зөвлөх;
- 9) Корпорацын улирал, бүтэн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг үндэслэн мандатын хэрэгжилт болон цаашид авах арга хэмжээний талаарх дүгнэлт, зөвлөмж гаргаж Засаг даргад хүргүүлэх;
- 10) Корпорацийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох;
- 11) Корпорацийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг батлах;
- 12) Корпорацийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- 13) гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг үнэлэх зэрэг болно.

Дээр санал болгосон үүрэг хариуцлага, чиг үүргийн зарим хэсгийг Корпорацийн удирдах зөвлөлд эрх мэдлийг шилжүүлэх замаар хэрэгжүүлсэн ч бас болох юм.

Хотын хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын төслийн удирдлага, менежментийг эхнээс нь зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий алба, төслийн нэгжийг Нийслэлийн Хөгжлийн бодлогын хэлтэс дотор байгуулж, эсхүл тус хэлтсийн Төсөл, хамтын ажиллагааны тасгийг орон тоо, чиг үүргийн хувьд өргөтгөн зохион байгуулах шаардлагатай юм. Үүнээс гадна шинэ алба болон холбогдох бусад газрууд, тухайлбал, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” НӨҮГ, “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК-ийн ажиллагсад, боловсон хүчний төслийн удирдлагыг хэрэгжүүлэх мэдлэг боловсрол, чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр дахин сургалт, институтийг бэхжүүлэх дунд хугацааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг ДБ, АХБ, НҮБХХ болон бусад хөгжлийн байгууллагууд, харилцагч бусад орны нийслэл, хотуудын хамтын ажиллагааны хүрээнд тавьж хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

### 3.3.3 Дэд стратеги: Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн тогтолцоонд иргэд, олон нийтийн оролцоог хангах

Иргэд болон хувийн хэвшлийн оролцоог бодлого боловсруулах, төсөв зохиох, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах нь аливаа хөрөнгө оруулалтын төслийг сонгох, хэрэгжүүлэх, үр ашиг, үр дүнг дээшлүүлэхэд нэн чухал ач холбогдолтой байдаг. Иймд дараах Дүрслэл 4.4-д үзүүлсэн эргэх холбоо бүхий иргэд, олон нийтийн хэлэлцүүлгийн тогтолцоог бий болгох нь зүйтэй гэж бид үзэж байна.

Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн бодлогыг тодорхойлоход иргэд, олон нийтийн оролцоог хангах гол механизм нь хэлэлцүүлгийн хэлбэр байх нь илүү оновчтой гэдэг нь ойлгомжтой. Өнгөрсөн жилүүдэд Нийслэл болон дүүргүүд, хороодод Иргэний танхимууд олноор байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байсан. Иргэд, олон нийтийн хэлэлцүүлгүүдийг хийхдээ эдгээр Иргэний танхимын тогтолцоог өргөнөөр ашиглах боломж буйг энд тэмдэглэх нь зүйтэй юм.

Нийслэлийн засаг захиргаа, холбогдох ажлын алба, нэгжүүдээс Улаанбаатар хотын хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийг тодорхойлохдоо иргэд, олон нийт, аж ахуйн нэгжүүдийн санал, хүсэлтийг авах, харилцан ойлголцох, олон талын санал бодлыг нэгтгэж, арга зам, бодлогыг тодорхойлох нь бодлогын хэлэлцүүлгийн зорилго юм.

Ийм хэлэлцүүлгүүдийг хэд хэдэн үе шатаар хийж болно. Тухайлбал, эхний шатны хэлэлцүүлгүүдийг (Дүрслэл 4.4: Баруун талын зураг) сэдэвчилсэн болон өргөн хүрээгээр зохион байгуулж Улаанбаатар хотод тулгамдаж байгаа асуудлуудын хоорондын уялдаа, шийдэгдэх шаардлагатай асуудлуудыг эрэмбэлж гаргах бөгөөд үүн дээр тулгуурлан бодлогын саналуудаа томъёолно.


Томъёолсон бодлогын саналууд дээр үндэслэн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах бөгөөд энэ төслөө 2 дах шатны хэлэлцүүлгүүдээр (Дүрслэл 4.4: Зүүн талын зураг) талуудтай хэлэлцүүлж тэдний санал дүгнэлтийг тусгана.

Дээрх хэлэлцүүлэгт оролцогчид Сангийн яам, Төв банк, Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, НЗДТГ гэх мэт төрийн үйлчилгээний байгууллагуудаас гадна иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөллүүд, хуульч, эдийн засагч, бусад мэргэжлийн судлаач, мэргэжлийн тэргүүлэх сэтгүүлч нараас бүрдэж болно.

Хэлэлцүүлэгт оролцож буй талуудын хэлэлцүүлэгт хэрхэн оролцох хэм хэмжээг тогтоосон тодорхой дүрэм, удирдамж гаргах нь хэлэлцүүлгийг зохион байгуулалт сайтай, үр дүнтэй, үүрэг, хариуцлагатайгаар хийх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Аливаа бодлогын эцсийн зорилтот үр дүн нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүрэх учраас бодлогыг далайцтай, чамбай төлөвлөх явцад иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөллүүдийн идэвхтэй дуу хоолой нь бодлогын чиглэлийг улам нарийн тодорхой болгож, өнөөгийн нөхцөл байдалд ямар шаардлага байгаа тухай ойлголт сайжирч, гүнзгийрдэг.

### Дүрслэл 3.3: Бодлого тодорхойлоход иргэд, олон нийтийн оролцоог хангах дэс дараалал



Эх үүсвэр: УБАК

Хэлэлцүүлэгт аль болох нийгмийн төлөөллийг өргөнөөр оролцуулснаар цаашид бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэд тавих иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, иргэдийн дунд ойлголт мэдээллийг сайжруулах, идэвхийг нэмэгдүүлэх зэрэг эерэг нөлөөллүүдийг бий болгох юм.

Оролцооны аргаар асуудлын болон шийдлийн хувилбаруудыг тодорхойлох нь дараах хэд хэдэн ач холбогдолтой:

- Оролцогч талууд хамтран хэлэлцэж гаргаж ирсэн тул боловсруулсан бодлого, төлөвлөгөөнд өөриймсгөөр хандан хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно.
- Асуудлыг олон талын өнцгөөс нь харж гаргаж ирснээр боловсруулсан бодлого төлөвлөгөөг илүү бодитой байхад нөлөөтэй.
- Талууд нэгдмэл эрх ашгаа ойлгох, хүч нөөц боллоцоогоо нэгтгэх, харилцан итгэлцлийг бий болгодог.
- Хэдийгээр олон ургалч санаа гаргах боловч эцсийн үр дүндээ хамтын шийдвэрт хүрэх соёлыг бий болгодог.

Дээрх хэлэлцүүлгээс гарсан үр дүнг ашиглан бодлого, стратеги төлөвлөгөө боловсруулах бөгөөд энэ үйл ажиллагааны задаргаа болон төсөл, хөтөлбөрөөр дамжин санхүүжилтийн эх үүсвэртэй уялдаж хэрэгжинэ. Төлөвлөлтийн энэ процессыг дараах схемээр харууллаа.

### Дүрслэл 3.4: Төлөвлөлтийн процесс



Эх үүсвэр: УБАК

Улаанбаатар хотод Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, эрэмбэлэх, гарц шийдлүүдийг гаргаж бодлого, үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийг эрэмбэлж санхүүжилтийн эх үүсвэртэй уялдуулсан системтэй цогц механизм бүрдэх хэрэгтэй байна. Ингэхгүйгээр зөвхөн өнөөдрийн тулгамдаж буй бэрхшээлийг тойрсон богино хугацааны шийдлээр асуудлыг шийдвэрлэснээр ирээдүйд гарах урт хугацааны хөгжлийн асуудлуудыг шийдэхгүй бөгөөд урт хугацаанд өгөөжөө өгөх хөгжлийн үр дүнтэй төсөл, хөтөлбөрүүдээ эхлүүлж чадахгүй цаг алдах эрсдэлтэй юм. Иймд манай санал болгож буй аргачлалын дагуу эхэнд эрэмбэлэгдсэн төслүүдийг хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч түүнд санхүүгийн бололцоотой эх үүсвэрээ уяж хэрэгжүүлэх нь Улаанбаатар хотын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдэх, урт хугацааны үр нөлөөг авчрахад чухал ач холбогдолтой юм.

### 3.3.4 Дэд стратеги: Улаанбаатар хотын төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх

Нийслэлийн төсвийн 42 байгууллагын 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд Нийслэлийн аудитын газраас 2017 онд гүйцэтгэсэн аудитаар илрүүлсэн хөрөнгө зарцуулалтын зөрчлүүдийг шинжилж үзлээ.

#### Хүснэгт 3.2. Илэрсэн зөрчлийн ангиллын судалгаа, сая төгрөгөөр

	Зөрчлийн дүн
Үр ашиггүй зарлага	349
Цалин, нэмэгдэл	218
Зөвлөх үйлчилгээний тендер	209
Анхан шатны баримт бүрдэл	127
Бараа материалын зардал	83
Орлого	79
Засварын зардал	67
Албан томилолт	63
Үндсэн хөрөнгө	27
Шатахууны зардал	25
Баяр ёслол, арга хэмжээний зардал	13
Нийт	1,260

Эх үүсвэр: УБАК

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө зарцуулалтын зөрчлийн 28 хувь буюу 349 сая төгрөг нь үр ашиггүй зардлаас үүдсэн ба цалин, нэмэгдэл илүү олгосон зөрчил нь 17 хувь буюу 217.8 сая төгрөг, зөвлөх үйлчилгээг тендер зарлаагүй авсан зөрчил нь 17 хувь буюу 210 сая төгрөг, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гаргасан зардлын зөрчил нь 10 хувь буюу 127 сая төгрөг гэх мэт илэрсэн байна.

**Дүрслэл 3.5: Зөрчлийн ангилал тус бүрийн нийт илэрсэн зөрчилд эзлэх хувь**

Эх үүсвэр: УБАК

Үр ашиггүй хөрөнгө зарцуулсан зөрчлийг нарийвчлан авч үзвэл тус ангиллын зөрчлийн 62 хувь буюу 218 сая төгрөг нь НЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн байна. Үүнд дараах томоохон зөрчлүүд багтсан байна.

1. Засаг даргын нөөц сангаас зориулалт бусаар буцалтгүй тусламж болон эмэгтэйчүүдийн баярт 104.5 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 заалт, Сангийн сайдын 2012 оны 239 тоот тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 15 заалтыг зөрчсөн.
2. Засаг даргын нөөц сангаас шүүхийн шийдвэрийн нөхөн олговорт 93 сая төгрөг олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн “103.1. Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэснийг зөрчсөн.
3. Хэзээ эргэж ашиглах нь тодорхойгүйгээр 18 сая төгрөгийн урьдчилгааг ААН-д шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 заалтыг зөрчсөн.


Нийслэлийн харьяа нийт 42 байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын тайлангуудыг үзэхэд 28 байгууллагад хөрөнгө зарцуулалтын зөрчил илэрсэн байна. Үүнээс эхний 9 байгууллагыг сонгон дараах хүснэгт болон дүрслэлээр үзүүлэв.



**Хүснэгт 3.3: Илэрсэн зөрчлийн судалгаа, сая төгрөгөөр, хувиар**

Байгууллагын нэр	Зөрчлийн дүн /сая төг/	Нийт зөрчилд эзлэх %	Тухайн байгууллагын төсөвт эзлэх %
1 НЗДТГ	468	37%	2%
2 УБ хотын захирагчийн ажлын алба	279	22%	1%
3 Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар	192	15%	4%
4 Чингэлтэй дүүргийн халамжийн сан	82	7%	7%
5 Нийслэлийн Авто замын хөгжлийн газар	38	3%	2%
6 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	36	3%	1%
7 Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор	21	2%	2%
8 Нийслэлийн байгаль орчны газар	18	1%	2%
9 Нийслэлийн газрын алба	18	1%	4%
10 Бусад	108	9%	2%
<b>Нийт</b>	<b>1,260</b>		

Эх үүсвэр: УБАК

**Дүрслэл 3.6: Илэрсэн зөрчлийн судалгаа, байгууллагаар, сая төгрөгөөр, хувиар**

Эх үүсвэр: УБАК

**3.4 Стратеги 2: Хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх**

Монгол Улсад ТХХТ-ийн төсөл хэрэгжүүлэх орчин төдийлөн сайн хөгжөөгүй бөгөөд бусад Ази-Номхон далайн улс орнуудтай харьцуулахад ТХХТ-ийн таатай орчин гэсэн ангилалд Монгол Улс хамгийн сүүлд жагссан байна.<sup>7</sup>

ТХХТ-ийн нийт хөрөнгө оруулалттай холбоотой тоо мэдээлэл хязгаарлагдмал бөгөөд одоогоор хэрэгжиж байгаа ТХХТ-ийн талаар цогц статистик тоо баримт байхгүй байна<sup>8</sup>. Гэтэл нөгөөтээгүүр ТХХТ нь Засгийн газрын хөгжлийн стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ТХХТ-ийг зөв зохистой төлөвлөж, бүтцийг зөв гаргаж, хэрэгжүүлэх аваас дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх, ТХХТ-ээр төслийг хэрэгжүүлэх үр ашигтай арга хэрэгсэл байж чаддаг. Мөн, ТХХТ-ийг төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд буюу жишээлбэл эрүүл мэнд, боловсролын салбарт ашиглах боломжтой.

ТХХТ-ийг нэвтрүүлэх, түүнийг зохицуулах бодлогын орчныг бүрдүүлсэн ч Засгийн газар болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага чадавхаа бэхжүүлэхээс нааш ТХХТ-ийн төслүүдийг хэрэгжүүлэх асуудал бэрхшээлтэй байх болно. “Улаанбаатар хотын Хөгжлийн корпорац”-ийн ажилтнууд зах зээлийг үнэлэх чадавхтай байх, хувийн хэвшлийн оролцоог хангахуйц төслүүдийг сонгох, хувийн хөрөнгө оруулагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс эрсдэлийг хуваах найдвартай механизмыг бий болгох, салбарын яамд тухайлбал Эрчим хүчний яам, Боловсролын яам болон Зам, тээврийн яамдыг ТХХТ-ийн төсөл боловсруулан хэрэгжүүлэхэд нь хамтран ажилладаг байх шаардлагатай. Цаашилбал, ил тод, өрсөлдөөнт тендер шалгаруулалтын үйл явц, хууль журмын биелэлтийг сайтар хангах, төслийн хэрэгжилтийг хангах таатай орчныг бүрдүүлэх стратегийн арга хэмжээ авах шаардлагатай байна. ТХХТ-ийг хөгжүүлэх, энэ хэлбэрээр хэрэгжүүлэх төслийн тоо хэмжээ, мөнгөн дүнгийн хэмжээг нэмэгдүүлэх нь гадаадын шууд хөрөнгө оруулалт зэрэг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын бизнесийн ерөнхий орчныг сайжруулах байдлаас мөн хамаарна.

### 3.5 Стратеги 3: Гадаад эх үүсвэрийг татах

#### 3.5.1 Дэд стратеги: Хөгжлийн албан ёсны тусламж

Монгол Улсын ХАЁТ-ийг 2016 онд салбараар хуваарилсныг Зураг 1-т харуулж байна. Онцгой байдлын салбарт олгосон буцалтгүй тусламжийн хэмжээ 11 сая ам доллар буюу хамгийн их бөгөөд хоёрт хөдөө аж ахуйн салбарт 9 сая ам.доллар олгосон боловч үнэмлэхүй хэмжээний хувьд бусад олон орныхтой харьцуулахад харьцангуй бага байна. Бусад салбаруудад олгосон ХАЁТ бусад орнуудтай харьцуулахад маш бага байгаа бөгөөд, Монгол улс эрчим хүчинд 370 мянган ам.доллар, байгаль орчинд 2.3 сая ам долларын тусламж авсан байна. Түүнчлэн нийгмийн салбарууд нь маш бага хуваарилалтыг авсан байна.

#### Дүрслэл 3.7: ХАЁТ-ийн салбаруудын хуваарилалт, 2016 оноор



<sup>7</sup> <https://www.cmc-global.org/content/public-private-partnerships-development-mongolia-perspective>

<sup>8</sup> НҮБХХ, АХБ, Ази, Номхон далайн хөгжлийн үр өгөөжийг дэмжих байгууллага, Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ, 2017

Эх сурвалж: СЯ, ХАЁТ-ийн төсөл.

Монгол Улсын Засгийн газар болон хөгжлийн түншүүд нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг ХАЁТ бага байгаа гол салбаруудад хэрэгжүүлэхээр зорьж буй тул Улаанбаатар хотын хувьд нэмэлт санхүүжилтийг дайчлах томоохон боломж гарч байна. Засгийн газраас нэмэлт санхүүжилт дайчлах стратегийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь эдгээр салбарууд нь урт хугацаанд санхүүжилтийн хувьд бэхжиж хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал юм.

Улсын төдийгүй Улаанбаатар хотын санхүүгийн удирдлагын системийг цаашид сайжруулах нь өнөөгийн санхүүжилтийн үр дүн, үр ашгийг дээшлүүлэх төдийгүй хоёр талын уламжлалт болон олон талт ХАЁТ, сэргээгдэх эрчим хүч, байгаль орчны болон цаг уурын өөрчлөлтөд нөлөөлөх шинэ төрлийн хөнгөлөлттэй үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой болох юм.<sup>9</sup>

### 3.5.2 Дэд стратеги: Даян дэлхийн хөнгөлөлттэй сангууд

Засгийн газар дэлхий даяар байдаг хөнгөлөлттэй сангууд болох Даян дэлхийн байгаль орчны сан (ДДБОС/GEF), Вакцинжуулалт, Дархлаажуулалтын Дэлхийн холбоо (GAVI), ДОХ, Сүрьеэ ба хумхаатай тэмцэх даян дэлхийн сан (GFATM) болон Боловсролын түншлэлийн даян дэлхийн сан (GPE) гэх мэт даян дэлхийн сангуудаас олгосон хөнгөлөлттэй зээлүүдэд нэгдсэн эсэх талаар хяналт хийгээгүй байна. Хөнгөлөлттэй санхүүжилтийн дийлэнх нь эдгээр эх үүсвэрээс олгогдож байна. Жишээ нь Даян дэлхийн сан ойролцоогоор 7,6 сая ам.доллар, ДОХ, Сүрьеэ ба Хумхаатай тэмцэх даян дэлхийн сан 5.0 сая ам долларыг сүүлийн 10 жилд хуваарилсан.<sup>10</sup>

Мөн даян дэлхийн сангийн зарим өөр эх үүсвэрээс Монгол Улс хөнгөлөлттэй санхүүжилт авах боломжтой хэд хэдэн эх үүсвэр байдаг. Жишээлбэл, уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтээс Монгол улс илүү их хөрөнгө босгох боломжтой. Нэг хүнд ногдох хорт хийн хэмжээ өндөр, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд хүчтэй орсон орны хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход тулгарч болох сорилтуудыг даван туулах, арилгах арга хэмжээ авахад зориулж санхүүжилт авах боломжтой байдаг.

Уур амьсгалын сангийн шинэчилсэн мэдээллээр<sup>11</sup>, GTEF сангийн санхүүжилтээс 5.59 сая ам.долларыг Монгол Улсад хуваарилсан бөгөөд энэ нь бүс нутгийн хуваарилалтын 2.4 хувийг эзэлж байна. Хуваарилагдсан хэмжээний хувьд Зүүн өмнөд Азийн 20 орноос Монгол Улс 12-т орж байна. Цөөн хүн амтай Монгол орны хувьд нэг хүнд ногдох хэмжээ харьцангуй өндөр байгаа тул Монгол Улсад илүү санхүүжилт татах боломж байна гэдгийг харуулж байна.

Эдгээр сангуудын ихэнх нь сэргээгдэх эрчим хүчний шийдэлд зориулагддаг тул энэ тал дээр Монгол Улсын хувьд нэлээд их нөөц бололцоо байгааг харуулж байна. Монгол Улс нар, салхи, усны арвин нөөцтэй бөгөөд эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах нөөцийн хувьд дэлхийд дээгүүр ордог байна<sup>12</sup>. Гэсэн хэдий ч эдгээр нөөцийг ашигладаггүй тул хөрөнгө оруулагчдад ашиггүй учраас тэдгээрийн сонирхлыг татахгүй байна. Уламжлалт эрчим хүчиндээ өндөр өртөгтэй татаас өгдөг, институтын болон зохицуулалтын хүрээ сул, шугам, сүлжээнд нэвтрэх болон чадавхын хувьд асуудалтай зэрэг эрчим хүчний зах зээлийн бүтцийн хязгаарлалтын улмаас сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд өрсөлдөх чадваргүй хэвээр байна. Хэрэв уламжлалт эрчим хүчний эх үүсвэрт Засгийн газраас

<sup>9</sup> Непалын хөгжлийн санхүүжилтийн байгууллагын мэдээлснээр төлөвлөлт, төсөвлөлт, хяналтын чадавх сулаас ХАЁТ-ийн санхүүжилт буурсан байна.

<sup>10</sup><https://www.theglobalfund.org/en/portfolio/country/?loc=MNG&k=ccd66728-2585-4e48-a529-591ccfb81152>

<sup>11</sup> Уур амьсгалын сангийн шинэчлэлт нь Хайнрих Болл Свифт (HBS) ба Хилийн Далайн Хөгжлийн Хүрээлэн (ODI)-гийн хамтарсан санаачилга юм. Эдгээр хандивлагчид хөрөнгө оруулах барьцаанаас эхлэн төслийг санхүүжүүлэх бодит хуваарилалт хийх хүртэл цаг уурын өөрчлөлтийн санхүүжилтийг хянаж байдаг.

<sup>12</sup>Европын хөгжлийн тайлан. Хөгжиж буй орнуудын сэргээгдэх эрчим хүчний санхүүжилт: Механизм ба хариуцлага. 2012

олгодог ихээхэн хэмжээний татаасыг байхгүй болговол энэхүү сэргээгдэх эрчим хүчний Эх сурвалж дотоодын болон олон улсын сонирхлыг татаж өрсөлдөх чадвар бий болно.

Ийнхүү Монгол Улс хөнгөлөлттэй санхүүжилтийн энэхүү Эх сурвалжийг ихээхэн хэмжээгээр татах боломжтой гэдгийг харуулж байна. Үүний тул үндэсний бодлого нь сэргээгдэх эрчим хүчний томоохон хөрөнгө оруулалтыг дэмжиж, Засгийн газраас эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх чадавхыг дээшлүүлэхэд онцгой анхаарах шаардлага гарч байна.

Санхүүгийн эдгээр эх үүсвэрүүдийг ашиглан эрчим хүч, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой Монгол Улсын төдийгүй Улаанбаатар хотын хөгжлийн олон сорилтуудыг санхүүжүүлэхэд тавигдах шаардлагыг хангах, үр өгөөжтэй төслүүдийг танилцуулснаар хөгжлийн санхүүжилтийг илүү үр дүнтэйгээр татах замаар дэлхийн санхүүгийн Эх үүсвэрээс санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх боломж нээгдэж байна.

Хөрөнгийн нэмэлт санхүүжилтийн боломжийн талаар зарим эх сурвалжийг жишээ болгон авч үзье.

## **Шигтгээ 2: Уур амьсгалын өөрчлөлтийг зөөлрүүлэх ба дасан зохицох даян дэлхийн сангууд ба санхүүжилт**

Хөнгөлөлттэй нөхцөлөөр олгогддог даян дэлхийн санхүүжилтийн Эх сурвалжийг жишээ болгон авч үзье. Цэвэр технологийн сан нь Цаг уурын хөрөнгө оруулалтын санд багтдаг Олон талт хандивлагчдын итгэлцлийн хоёр сангийн нэг бөгөөд хүлэмжийн хийн болон нүүрс төрөгчийн ялгаруулалтыг бууруулахыг дэмжсэн технологийг бий болгох, нутагшуулах, шилжүүлэх санхүүжилтийг үе шаттайгаар санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Бүсийн Хөгжлийн Банк, Дэлхийн банкаар дамжуулж Цэвэр технологийн сан нь 15 улсын хөтөлбөр, нэг бүс нутгийн хөтөлбөрийг санхүүжүүлдэг. Монгол Улс цэвэр технологийн сангаас санхүүжилт авдаг улс орнуудын дунд хараахан ороогүй байна.

Бага орлоготой орнуудын сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг дэмжих хөтөлбөрт 839 сая.ам долларыг олон талт таван хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлсэн бөгөөд эрчим хүчний хүртээмж, эдийн засгийн боломжуудыг нэмэгдүүлэхийн тулд сэргээгдэх эрчим хүчний шийдлийг санхүүжүүлэх боломжийг олгодог. Одоогийн байдлаар Монгол Улс дөрвөн цонхны аль нэгийг хүрээнд хоёр төслийн нийт 13.6 сая ам.долларын санхүүжилтийг хөтөлбөрийн хүрээнд батлуулсан бөгөөд энэ нь хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 1.7 хувийг эзэлж байна.<sup>13</sup>

Дасан зохицох сан нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц болон түүний Киотогийн протокол (КП)-ын дагуу байгуулсан санхүүгийн хэрэгсэл юм. Энэхүү сан нь иргэд, улс орон, салбаруудад нөлөөлж буй уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахын тулд КП-д заасны дагуу хөгжиж буй орнуудад тодорхой төсөл хөтөлбөрийг нутагшуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан. Сан нь Цэвэр Хөгжлийн Механизм (ЦХМ) төслийн үйл ажиллагаанаас олсон орлогоос мөн хандивлагчдын сайн дурын амлалтаар дамжуулан санхүүждэг. ЦХМ-ын эх үүсвэрээс Бохирдлын бууралтын баталгаажуулалтын (БББ)-ын орлогын 2 хувь нь ЦХМ-ын төслүүдийн үйл ажиллагаанд зарцуулагддаг. Одоогийн байдлаар зөвхөн нэг төсөл Монголд санхүүжилт авсан байна. ("Монгол дах усны аюулгүй байдлыг хангах эко системд суурилсан дасан зохицох арга зам"). Төслийг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс хэрэгжүүлдэг бөгөөд Байгаль орчны яам гүйцэтгэгч агентлаг юм.<sup>14</sup>

Даян дэлхийн Эрчим хүчний үр ашиг ба Сэргээгдэх эрчим хүчний сан (GEEREF)-г Европын Холбоо санхүүжүүлдэг, Европын хөрөнгө оруулалтын банкны удирдлага дор хэрэгждэг улсын төсвийн хөрөнгөөр дамжуулан хувийн хэвшлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор байгуулагдсан төр-хувийн хэвшлийн түншлэл юм. GEEREF нь жижиг ба дунд хэмжээний төсөл боловсруулагчид, аж ахуйн нэгжүүд хөгжиж буй орнууд, шилжилтийн эдийн засагтай орнуудад эрчим хүчний үр ашигтай, сэргээгдэх эрчим хүчний

<sup>13</sup> <https://www.climateinvestmentfunds.org/fund/scaling-renewable-energy-program>

<sup>14</sup> <https://www.adaptation-fund.org/projects-programmes/project-information/projects-map-view/>

төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулан хувийн үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт хийдэг, сангийн доторх сан байдлаар зохион байгуулагдсан.

Одоогийн байдлаар Монгол улсад санхүүжилт хийх боломжтой ТХХТ-ийн цөөхөн төслүүдийг сангаас санхүүжүүлсэн. Хувийн хэвшил эх үүсвэр татах талаар арай илүү амжилттай ажиллаж байна. Жишээлбэл, Ногоон уур амьсгалын сан (GCF) нь Монгол улсын аж ахуйн нэгжүүдэд эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглахад чиглэсэн нэг төсөл баталсан байна.

Эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг Монгол улсын аж ахуйн нэгжүүдэд зээл олгож чадварыг нэмэгдүүлэхийн тулд Хас банкинд санхүүжилт олгосон. Ногоон уур амьсгалын сангийн өөрийн санхүүжилт 19.5 сая ам.доллар, мөн Дэлхийн цаг уурын түншлэлийн сангаас санхүүжүүлсэн 20 сая доллар, Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас 15 сая ам.доллар, DWM компаниас 5 сая ам.долларын санхүүжилтийг хамтран санхүүжүүлсэн.<sup>15</sup>

## 3.6 Стратеги 4: Санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг бий болгох

### 3.6.1 Дэд стратеги: Улаанбаатар хотын төсөвт томоохон хэмжээний тогтмол татварыг бий болгох

Улаанбаатар хотын хөгжил, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд одоогийн өөрийн татвар, орлогын суурь, нэр төрөл хангалтгүй байгаа гэдэг нь ойлгомжтой. Хотын урсгал төсөв нь ихээхэн алдагдалтай, татварын орлогын нэмэгдэл эх үүсвэрийн хувьд одоогийн хууль эрх зүйн хүрээнд боломжгүй байгаа нь хотоос өөрийн бичиг, бонд, бусад үнэт цаас гаргах, зээл авах, концессын үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж байгаа юм. Өөрийн эх үүсвэр дутмаг тохиолдолд гадаадын зээл, тусламжийг татах боломж ч хүндрэлтэй.

Газрын татвар, үл хөдлөх хөрөнгийн татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг зохих хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар шийдэж болох боловч, энэ нь тухайн татвар төлөгчийн орлого, цалин хөлстэй төдийлөн хамааралтай биш, орлого багатай, эмзэг бүлгийн хувьд хүнд, сөрөг нөлөөтэй байх тул өнөөгийн нөхцөлд төдийлөн тааламжтай бус юм.

Иймд хотын төсөвт бизнесийн идэвх санаачлаг, орлого, мөнгөний урсгалтай шууд уялдсан, тогтмол, томоохон хэмжээний шинэ татварын орлогын нэр төрлийг санаачлан бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ямар нэгэн босго үгүй, буцаан олголт үгүй, хөнгөлөлт чөлөөлөлт үгүй худалдааны татварыг 2-оос 1 хувийн хэмжээтэй хэрэглэх боломжтой юм. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр хийгдэж буй бүх төрлийн борлуулалтын орлого, арилжаа, наймааны орлого, ажил, үйлчилгээний орлогоос энэхүү татварыг авах саналыг тавих нь илүү зохистой байна. Санал болгож буй худалдааны татвар бий болгох тохиолдолд Улаанбаатар хот 2 хүртэл хувиар, дүүрэг 1 хүртэл хувиар тус тус энэ татварыг аваад явах бүрэн боломжтой. Дүүрэг худалдааны татварыг 1 хувиар дүүргийн төсөвтөө авлаа гэхэд нэмж 2 хувийг нь хурааж аваад хотын төсөвт шууд хийх тул татварын албанд ч зардлын дарамт багатай байна.

Энэхүү татварын орлогыг зөвхөн хөрөнгө оруулалтын зориулалтаар захиран зарцуулах нөхцөл тавьсан ч болох юм.

Энэ арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тохиолдолд жилдээ 500 орчим тэрбум төгрөг Улаанбаатар хотын төсөвт орох боломжтой юм.

<sup>15</sup> Ногоон хөгжлийн сан.

Манай эдийн засгийн ерөнхий бүтэц энгийн бөгөөд үйлдвэрлэлийн шат дамжлага багатай. Талх үйлдвэрлэе гэхэд л дээд тал нь 3-4 үе шат дамжина. Тийм учраас татвар давхардаад хүндрэл гарах нь өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад маш бага юм.

Ер нь ийм төрлийн худалдааны татварыг орон нутгийн татвар хэлбэрээр бусад орнуудад их хэрэглэдэг бөгөөд орон нутгийн орлогын ихээхэн хэсгийг энэ татвараар дамжуулан олдог. Жишээ нь, АНУ-ын мужуудад Gross Receipt Tax (нийт орлогын татвар), Business Operation Tax (бизнес эрхэлсний татвар) гэсэн татваруудыг 0,5-8 хүртэл хувиар ногдуулдаг бөгөөд тухайн орон нутагт бизнес эрхэлж, юм зарж, орлого л олсон бол ашигтай, алдагдалтай ажилласнаас үл хамааран энэ татварыг нийт орлогоосоо төлдөг байна.

Дүүрэг энэхүү худалдааны буюу хөгжлийн татварыг 1 хувиар авсан тохиолдолд тал хэсгийг нь буюу 0,5 хувиар ногдуулсан хэсгийг нь өөрийн харьяа бүх хороодод хүн амынх нь тоогоор хуваарилан Орон нутгийн хөгжлийн сангийн жишгээр тухайн хорооны иргэдийн саналаар хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулж болох юм.

### 3.6.2 Дэд стратеги: Гарааны хөрөнгө оруулалтыг бий болгох

Улаанбаатар хотод Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-ийг хөгжүүлэх нь эдийн засгийн төрөлжилтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх улмаар хотын хүн амын амьжиргааг сайжруулахад чухал нөлөөтэй юм. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ нь нийт ажиллагсдын 50%-ыг бүрдүүлдэг гэсэн тоон мэдээлэл байдаг бөгөөд энэ харьцаа Улаанбаатар хотын хувьд адил буюу ойролцоо байх талтай.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын ЖДҮ-ийн 50 орчим хувь нь банкны зээлтэй боловч зөвхөн 13 хувь нь хөрөнгө оруулалтын зориулалтаар банкны зээл авч чадсан бөгөөд ЖДҮ-үүдийн бизнесийн орчинд тулгарч буй хамгийн их саад тотгор болж буй асуудал нь санхүүгийн Эх сурвалж дутагдал юм<sup>16</sup>.

Азийн хөгжлийн банк (АХБ)-аас Монголын ЖДҮ-үүд зээлийн найдвартай эх үүсвэр олж авахад хүндрэлтэй байдгаас гадна банкны урт хугацааны зээлийн хүү өндөр, банкнууд урт хугацаагаар зээл олгох чадвар муутай байдаг талаар дурдсан байна. Үүнээс гадна ЖДҮ-үүд зээл авахад хүндрэлтэй тулгардаг бөгөөд ерөнхийдөө санхүүгийн зах зээлийн талаар ойлголт муутай байдаг. Энэ нь эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, уул уурхайн бус салбарт ажлын байр нэмэгдүүлэх боломжийг нэмэгдүүлэхэд ЖДҮ-үүд хувь нэмрээ оруулах, өсөж дэвжихэд хориг болж байна.<sup>17</sup>

ЖДҮ-ийн салбарыг бэхжүүлэх чиглэлээр төр засгийн санаачилга, хөгжлийн түншүүдийн дэмжлэг байгаа хэдий ч Монгол Улсад хандивлагчдын хөнгөлөлттэй санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын сан, хөтөлбөрүүд цөөхөн байна. Үүний нэг жишээ нь ОУСК болон ЕСБХБ-ны хөрөнгө оруулалт бүхий хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын сан болох Монгол Улсын боломжуудын сан юм. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн зах зээлийн бодит хэмжээ, тооны талаарх мэдээллийн эх сурвалж хязгаарлагдмал, бусад бага орлоготой орнуудтай харьцуулахад зах зээл хөгжөөгүй хэвээр байна. Хөрөнгө оруулалтын зах зээл хөгжингүй байх нь нийгмийн салбар, хөдөө аж ахуй, аялал жуулчлал гэх мэт өөр өөр салбарт шинээр бизнес эхлүүлэхэд шаардагдах хөрөнгийг чиглүүлж чадна.

Санхүүгийн хүртээмжийн одоогийн тулгамдсан асуудлуудаар Монгол Улсад үүсэж буй сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь өрсөлдөх чадвар, эдийн засгийн өсөлт, төрөлжсөн байдлыг нэмэгдүүлэхэд оршино. Хөрөнгө оруулалтын сан байгуулах нь бизнесийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, ЖДҮ-ийн салбарын чадавхыг сайжруулахад хувь нэмрээ оруулах боломжтой.

Хөрөнгийн эх үүсвэрийг дайчлах бас нэг механизм бол хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх өрсөлдөөнт санхүүжилтийн хэрэгсэл боловсруулсан Сорилтын сангууд юм. Сорилтын сан нь зах зээлд

<sup>16</sup> Дэлхийн банкны аж ахуйн нэгжийн судалгаа (2013). Монгол Улсын үзүүлэлт.

<sup>17</sup> Эдийн засгийг төрөлжүүлэх болон ажлын байрыг нэмэгдүүлэхэд зээлийн батлан даалтын тогтолцоог бэхжүүлэх төсөл, АХБ 2015 он.

тулгуурласан эсхүл урамшууллын хөтлөгдсөн шийдлийг олоход улсын секторын болон хувийн сангууд, зорилтот сангуудыг ашигладаг. Энгийн үед төслийг сонгоход тогтмол шалгуур бүхий өрсөлдөөнт механизмууд ашиглагддаг бөгөөд ихэнхдээ хөдөө аж ахуйн бизнес, мэдээлэл харилцаа холбооны технологи, сэргээгдэх эрчим хүч зэрэг янз бүрийн зорилтот салбаруудын өсөлтийг дэмжихэд чиглэсэн байдаг.

Энэхүү сан санхүүжилт хүрэлцээгүй бизнесүүдэд эргэн төлөгдөх эсхүл төлөх шаардлагагүй нөхцөл бүхий буцалтгүй тусламжийн санхүүжилт олгодог ба энэхүү санг Монголд хөрөнгө босгох жишээ болгон ашиглаж болохоор байна.

Бага ба дунд орлоготой олон орнууд хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон сорилтын сангуудыг хандивлагчдын дэмжлэгтэйгээр амжилттай үүсгэн байгуулж, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүч зэрэг тэргүүлэх чиглэлийн салбаруудын жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр амжилттай ажиллаж байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, эдийн засгийг солонгоруулах үүднээс Монгол Улсын Засгийн газар төдийгүй Улаанбаатар хотын удирдлагууд хөрөнгө оруулалтын сан, хөтөлбөр эсхүл сорилтын санг бий болгох санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх одоогийн хүчин чармайлтаа хөгжлийн түншүүд болон санхүүгийн салбартай хүч хавсран өргөжүүлэх боломжтой<sup>18</sup>.

### 3.7 Стратеги 5: Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх

Хөрөнгө оруулалтын төслүүдийг ерөнхийд нь мөнгөн орлогын урсгал, эдийн засгийн өгөөж бий болох боломжтой эсвэл боломжгүй төсөл гэж ангилж болно.

Мөнгөн орлогын урсгал бий болох боломжтой төслүүдэд хувийн хэвшлийг оролцуулах олон хувилбарууд байдаг. Жишээлбэл: хог тээвэрлэх, хог устгах ажлыг хувийн компани гүйцэтгэн, хог боловсруулах үйлдвэрлэлээс ашиг хүртэх боломжтой байдаг. Мөн ийм төрлийн төслүүдэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн замаар эсвэл ирээдүйд олох ашгийн тооцоололд үндэслэн дотоодын болон гадаадын зээл, өрийн бичгээр санхүүжилт татаж болно.

Харин шууд байдлаар мөнгөн орлогын урсгал бий болох боломжгүй төслүүдийн хувьд төслийг тусгай сангаар дамжуулан санхүүжилт татах боломжтой.

Аль ч улс орны хотуудын ихээхэн хөрөнгө оруулалт шаардсан, чухал ач холбогдолтой, хөгжлийн томоохон төслүүдийн сайн туршлагаас харахад иргэд, хувийн хэвшлүүдээс хөрөнгө оруулалт татсанаар амжилттай хэрэгжүүлсэн байна. Мөн тасралтгүй явагддаг, байнгын хөрөнгө оруулалт шаарддаг төслүүдийг ч иргэд, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтаар шийддэг хандлага улам дэлгэрч байна.

Тийнхүү хөрөнгө оруулалт татах гол тулгуур нь хотын захиргаа болон иргэд, аж ахуйн нэгжүүдийн хоорондын өргөн хүрээтэй, олон талын хамтын ажиллагааг бэхжүүлж чадсанд байгаа юм. Манай улсын хувьд хотын захиргаа болон иргэд, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сул байна. Тиймээс энэ төрлийн хамтын ажиллагааг бий болгох суурь нөхцөлүүдийг дараах байдлаар бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм.

1. Хотын захиргааны холбогдох төслийн үйл ажиллагааг олон нийтэд бүрэн ил тод болгох,
2. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн төслийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд оролцох эрхийг бий болгох,
3. Хотын захиргаа болон иргэд, аж ахуйн нэгжүүдийн итгэлцлийг бий болгох,
4. Төслийн үр шимийг хүртэх эсвэл холбогдох хуулиар давуу хөнгөлөлт эдлэх боломжийг хамтран ажилласан иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгох гэх мэт суурь нөхцөлүүдийг бүрдүүлэх юм.

Ийм төрлийн санхүүжилтийн хэлбэрийг **Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоо (Community-based Financing System)** гэж нэрлэдэг. Энэ тогтолцоог дараах байдлаар схемчлэн харуулж болно (Дүрслэл 4.1).

<sup>18</sup> “Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ” 2017, НҮБХХ, АХБ, АНДХҮӨДБ

Санхүүжилт татах үйл ажиллагааг үндсэндээ дараах 4 үе шатаар хэрэгжүүлнэ.

А. Төсөл удирдах нэгж (ТУН) байгуулан, санхүүгийн удирдлагын сайн тогтолцоог бий болгох,

Б. Төсөлд зориулсан хөрөнгийн сан үүсгэх,

В. Төслийн үр шим хүртэгчдийн төлөөлөл, холбоотой (Холбоо) гурвалсан гэрээ байгуулан төслийн санхүүжилт, үйл ажиллагаанд татан оролцуулах,

Г. Зээл, тусламж, боломжит санхүүжилтүүдийг татах.

#### Дүрслэл 4.1. Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоо



Эх сурвалж: УБАК

#### **А. Төсөл удирдах нэгж байгуулан (ТУН), санхүүгийн удирдлагын сайн тогтолцоог бий болгох**

Хөрөнгө оруулалтын газраас томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ТУН буюу багийг төсөл, хөтөлбөр тус бүрд нь байгуулах хэрэгтэй.

ТУН-ийн санхүүгийн удирдлагын тогтолцоог дараах байдлаар зохион байгуулах шаардлагатай.

- **Төслийн төлөвлөлт, гүйцэтгэлийг олон нийтэд иж бүрнээр нь ил тод болгох тогтолцоо:**  
Урт хугацаанд эсвэл тасралтгүй үргэлжилдэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хувьд хөрөнгө оруулалтын орсон мөнгөн урсгал болон гарсан мөнгөн урсгал, гүйцэтгэсэн ажлуудын талаар цахим мэдээллийн хэрэгслээр тогтмол цаг хугацаанд нь хоцрогдолгүй олон нийтэд хүргэж байх хэрэгтэй.
- **Санхүүгийн үнэлгээ, хяналт хийх боломжтой нягтлан бодох бүртгэл:**  
Төслийн үйл ажиллагааны төрөл, үе шат, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн төрөл зэрэг нарийвчлан ангилсан дансны ангилал бүхий нягтлан бодох бүртгэлийн системийг ашиглан төслийн оролцогч талуудад болон цаашид хөрөнгө оруулалт, тусламж өгөх боломжтой талуудад шийдвэр гаргах боломж бүрдүүлэхүйц нарийвчилсан бүртгэл хөтөлж байх. Зохистой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах.
- **Хараат бус аудит хийлгэж, аудитын тайланг олон нийтэд ил болгох:**



Хараат бус аудит хийлгэж, хөрөнгө оруулагч, зээл олгогч нар болон иргэд олон нийтийн итгэлийг бий болгож, өргөн хүрээний хамтын ажиллагааг идэвхжүүлэх.

- *Бараа бүтээгдэхүүн худалдан авалтын хяналт, ажлын гүйцэтгэлийн чанарын шалгуурын хяналтын тогтолцоог бүрдүүлэх:*  
Төслийн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам боловсруулах
- *Засгийн газрын оролцоо, хамтран ажиллах үйл ажиллагааны тогтолцоог зохицуулах:*  
Төслийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа, эрх үүргийг тодорхой болгох.

### **Б. Төсөлд зориулсан хөрөнгийн сан үүсгэх**

Хотын хөгжил, дэд бүтцэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах олон улсын сайн туршлагуудыг суурь зарчмынх нь талаас авч үзвэл Засгийн газраас санхүүжилт татахаас гадна нэлээдгүй хувийг тухайн бүтээн байгуулалтын төслийн үр шимийг хүртэгч талуудаас үр өгөөж хүртсэн хувь хэмжээгээр санхүүжилт татах бодлого баримталдаг байна. Ингэснээр аливаа хөгжлийн төслийг хянах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэдийн идэвх оролцоог мөн нэмэгдүүлэх хөшүүрэг болдог байна.

Тухайлбал, Хөгжлийн хураамж, тохижилт сайжруулалтын хураамж, дэд бүтцийн үйлчилгээний хураамж, үл хөдлөх эд хөрөнгийн үнэ цэнийн өгөөжийн татвар, хот төлөвлөлтийн албан татвар гэх мэт төлбөрүүдийг иргэн, аж ахуйн нэгжүүдээс хураан авч, тухайн татварын орлогын эх үүсвэрийн зориулалтынх нь дагуу зарцуулдаг байна.

Гэвч манай орны хувьд ард иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар муу, эдийн засгийн нөхцөл бололцоо муу байгаагаас ийм төрлийн татваруудыг хураах боломж, нөхцөл нь бүрдээгүй байгаа юм.

Тиймээс төслийн тусгай зориулалтын санг Хөрөнгө оруулалтын газраас санаачлан үүсгэн байгуулаад, иргэд, аж ахуйн нэгжүүдээс хөрөнгө оруулалт татах урьдчилсан нөхцөлүүдийг бүрдүүлэх юм. Улмаар ТУН нь төслийн үр шимийг төслийн үр дүнг хүртэх иргэд, аж ахуйн нэгжүүдэд ухуулан сурталчилж, хамтран ажилласнаар олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх нь зөв юм.

### **В. Төслийн үр шим хүртэгчдийн төлөөлөл, холбоотой (Холбоо) гурвалсан гэрээ байгуулан төслийн санхүүжилт болон үйл ажиллагаанд татан оролцуулах**

Төслийн үйл ажиллагааны хамтын хяналт, төслийн үйл ажиллагааны томоохон шийдвэр хамтран гаргах, төслийн сангийн орлого, зарлагыг хянах гэх мэт ТУН, Холбоо хоорондын хамтын ажиллагаанууд байж болно. Мөн хамтран ажиллах компаниудаас тусгай санд тогтмол хөрөнгө оруулалт татаж болно. Төслийн сан байгуулснаар төслийг цаашид хэрэгжүүлэх гол хөшүүрэг болох ба өөрөөр хэлбэл зээлжих чадамжийг бий болгож, мөн хандив тусламж татах нөхцөл боломжийг бодитойгоор өсгөх юм. Аж ахуйн нэгжүүд, иргэдийг төслийн үйл ажиллагаанд оновчтой эрх зүйн зохицуулалтаар татан оролцуулах явдал нь төсөл хамгийн үр ашигтай, өндөр хяналттай, амьдралд хэрэгжих оновчтой шийдвэртэйгээр явагдах магадлалыг нэмэгдүүлж зээл, хандив, тусламж олгогч талуудын итгэлийг олох илүү боломж бий болох давуу талтай байдаг.

### **Г. Зээл, тусламж, боломжит санхүүжилтүүдийг татах**

Тусгай зориулалтын сангийн тогтмол санхүүжилтийн орлого, бас төслийн ирээдүйд өгөх эдийн засгийн өгөөж нь зээлжих чадварыг тодорхойлох ба ТУН-ийн найдвартай, ил тод үйл ажиллагаа нь арилжааны банкнууд болон олон улсын байгууллагуудаас урт хугацаатай, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авах, олон улсын байгууллагуудаас тусламж авах шалгууруудыг хангах юм.

Хэрэв тусгай санд төслийг хэрэгжүүлэх хангалттай хэмжээний санхүүжилт татах боломжгүй бол улсын төсөв, хотын төсөв, орон нутгийн хөгжлийн сан гэх мэт хөрөнгөөс тусгай санд хуримтлуулж болох юм.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн дагуу хэрэгжүүлэхээр батлагдсан 90 төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүлэх ач

холбогдлоор эрэмбэлж үзлээ. Эдгээр эрэмбэлэгдсэн төслүүдээс доорх 2 төслийг сонгон авч санхүүжилтийн аргачлалыг туршиж үзлээ.

1. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах (Эмээлт)
2. Гэр хорооллын дахин төлөвлөлт

### **3.7.1 Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоо: Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хувьд**

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл (ГХДТТ) нь тэргүүлэх ач холбогдлын хувьд өндөр, хөрөнгө оруулалтын шаардлагатай хэмжээ нь бусад төслүүдтэй харьцуулахад хамгийн их байгаа тул санхүүжилт татах дээрх арга зарчмыг хэрхэн ашиглаж болохыг жишээ болгон энэ хэсэгт оруулж байна.

ГХДТТ нь гэр хорооллын иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна хотын агаарын бохирдлыг бууруулах асуудал болон бусад дагалдах олон асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх зорилготой юм.

Энэ төслийг хэрэгжүүлэхэд саад болж буй томоохон асуудлуудын нэг нь Улаанбаатар хотын цахилгаан, дулааны станцууд хүчин чадал хүрэлцэхгүй байгаа явдал юм. Мөн зах зээл дээр борлогдож байгаа орон сууцнуудын үнэ хэт өндөр байгаагаас орон сууцны борлуулалт муу байна.

Тиймээс ГХДТТ-ийг санхүүжүүлэх арга, зарчмыг боловсруулахад дараах зүйлсийг онцгой анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- А. Орон сууцнуудыг бага өртгөөр барьж, хямд үнээр борлуулах,
- Б. Цахилгаан, дулааны бичил эх үүсвэрүүд барих,
- В. Төслийн эхлэлтийн хөрөнгийг гаднын зээл, тусламжаар татах.

Эдгээр асуудлуудын талаар дэлгэрэнгүй авч үзье.

#### **А. Борлуулалтын үнэ, өртөг**

Төслийн хүрээнд баригдах орон сууцнуудын үнийг нийгмийн дунджаас доод түвшний, байнгын орлоготой иргэд авч болох хэмжээнд тогтоож чадвал төслийн үр дүн гэр хорооллын зорилтод иргэдэд хүрч, төсөл бүрэн хэрэгжих юм. Өнөөгийн орон сууцны үнийн хэт өсөлтийг дагаж газрын үнэ бас хэт өндөр болоод байна.

Орон сууцны барилгын үнийн өсөлтөд барилгын материалын зардлаас гадна дараах зардлууд голчлон нөлөөлж байна.

#### **а. Зээлийн хүү**

Барилгын салбар нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг тул барилгын компаниудын өөрийн хөрөнгө хангалтгүй байдаг. Орон сууцны захиалгын урьдчилгаа төлбөрийг барилгын ажлын явцад худалдан авагч нараас авдаг ч иргэдийн захиалгын тоо маш бага байдаг. Барилгын компаниуд шаардлагатай хөрөнгө оруулалтын дийлэнхийг арилжааны банкнуудаас авсан зээлээр хийхээс өөр арга зам байдаггүй. Гэтэл арилжааны банкнуудын зээлийн жилийн хүү дунджаар 18%-иас 25% байдгаас зээлийн хүүгийн зардал барилгын өртөгт жинтэй хувийг эзэлдэг байна. Хэрэв төслийн хөрөнгө оруулалтыг иргэд, олон улсын хөнгөлөлттэй санхүүжүүлэгч талуудаас татвал зээлийн хүүгийн зардал ихээр багасгах юм.

#### **б. Орон сууц борлуулагч компанийн ашиг**

Барилгын компаниуд нь ашгийн байгууллага тул барилгын өөрийн өртөг дээр ихээхэн хэмжээний ашиг нэмж, борлуулах үнээ тогтоодог. ТУН нь ашгийн бус бөгөөд Холбоотой хамтран ажиллах тул борлуулах үнэд нөлөөлдөг энэ хүчин зүйл байхгүй болно.

#### **в. Газрын үнэ**

Дээрх шалтгаануудын улмаас орон сууцны зах зээлийн үнэ өндөр байгаа тул газар эзэмшигч иргэд газраа өндөр үнээр үнэлдэг. Мөн нөгөө талаасаа барилга барих талбай нь зайлшгүй хэрэгцээтэй байдаг тул барилгын компаниуд өндөр үнээр авахаас өөр арга байдаггүй.

Хэрэв газар эзэмшигч нар төслийн ажилд хөрөнгө оруулагч болон идэвхтэй оролцож, мөн өөрсдөө орон сууцны захиалагч нь болсноор барилгын өртгийг хамгийн бага байлгах хамгийн ашигтайгаар төслийг хэрэгжүүлэх түлхэц болно.

Хэрэв төр, иргэд аль аль талдаа ашигтайгаар, үр дүнтэй хамтран ажиллаж чадвал, хямд өртөг бүхий зээл, тусламжийн хөрөнгө босгож, төр, иргэдийн хамтарсан хөрөнгө оруулалтаар эдгээр зардлуудын борлуулалтын үнэд үзүүлэх нөлөөг арилгаж болно.

### **Б. Цахилгаан, дулааны эх үүсвэр**

Хэдийгээр барилгын хөрөнгө оруулалтын асуудлуудыг шийдвэрлэсэн ч хотын дулаан, эрчим хүчний үйлдвэрлэлийн өнөөгийн хүчин чадал нь гэр хорооллуудад нэмж барихад хүрэлцэхээргүй байна. Тиймээс байгальд ээлтэй, өндөр үр ашигтай, хямд технологиор цахилгаан, дулааны бичил эх үүсвэрүүдийг барьж шийдвэрлэх хэрэгтэй байна.

### **В. Зээл, тусламж**

Хэрэв ТУН-ийг зохистойгоор зохион байгуулбал төслийн зээлжих чадварыг тодорхойлох боломжтой болж, төслийн санхүүжилт татах үйл ажиллагааг илүү оновчтой, хурдан шийдвэрлэх юм. Мөн энэ төслийн зорилготой холбогддог бусад төслүүдээс нэмэлт зээл, тусламж татаж, ашиглах боломжуудыг илүү нээж өгнө.

## **Санхүүжилтийн тогтолцоо**

ГХДТТ-ийн санхүүжилтийн тогтолцоог Дүрслэл 4.2-т үзүүлсэн байдлаар байгуулж болно.

**Санхүүжилт татах ерөнхий төлөвлөгөө** хэсэгт дурдсанчлан хөрөнгө оруулалтын газар, төсөл удирдах нэгж нь зохион байгуулагдан ажиллана. Харин ГХДТТ-ийн үр шим хүртэгчид нь газар эзэмшигч иргэд байна. Газар эзэмшигчдийг төсөл хэрэгжүүлэх хамтын ажиллагаанд татан оролцуулахын тулд аль аль талдаа үр ашигтай нөхцөлүүдийг Гурвалсан гэрээндээ оруулах юм.

Дараах заалтууд нь гэрээний ерөнхий нөхцөлүүд байж болно.

1. Газар эзэмшигч иргэд өөрсдийн эзэмшлийн газраараа төслийн санд хөрөнгө оруулалт хийж, газар эзэмшигчдийн холбоо (Холбоо)-нд нэгдсэнээр гурвалсан гэрээнд оролцоно.
2. Барилга угсралтын ажил гүйцэтгэгч компанийг сонгох, гэрээ байгуулах ажилд Холбоо голлох эрхийг эдэлнэ,
3. ТУН нь төслийн бүхий л үйл ажиллагааг Холбоонд цаг алдалгүй хүргэх боломжийг бүрдүүлнэ,
4. Орон сууцны дэд бүтцийн зардлыг орон сууц борлуулсан орлогоос гаргуулна,
5. Дэд бүтцийг байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай, бага өртөг, зардалтай технологиор шийдвэрлэнэ,
6. Газар эзэмшигч нарыг өргөнөөр татан оролцуулахын тулд төсөлд оролцсон иргэдийг нийгмийн үйлчилгээг хөнгөлөлтэй нөхцөлөөр үзүүлэх, татварын хөнгөлөлт үзүүлэх гэх мэт заалтуудыг оруулж болно.

## Дүрслэл 4.2. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн санхүүжилтийн схем



Эх сурвалж. УБАК

### 3.7.2 Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоо: Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн хувьд

Улаанбаатар хотод арьс, шир боловсруулах 34 үйлдвэрүүд ХУД-ийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт орон сууц, суурьшлын бүстэй хаяа залган үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн ноос, ноолуурын угаах, самнах үйлдвэрүүдийн дийлэнх хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа нь байгаль орчинд сөрөг нөлөөллийг бий болгож тус орчин дах агаар, хөрс, усны бохирдлыг үүсгэгч үндсэн шалтгааны нэг болж байна. Иймээс шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлсэн, байгаль орчинд халгүй үйлдвэрүүдийн нэгдлийг бий болгох “Эмээлт Парк”-ийг бүтээн байгуулах зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Нөгөө талаасаа Монгол улсын нийт малын тоо дэлхийн нийт малын 1.4 хувийг эзэлж буй бөгөөд 2016 онд малын тоо 61.5 сая толгойд хүрсэн байна. Одоогийн байдлаар дотоодын арьс, шир боловсруулалтын 80%, ноосны 43%, ноолуурын 62% -д анхан шатны боловсруулалт хийж экспортолж байна. Энэ нь эдийн засгийн хувьд үр өгөөжгүй байгаагаас гадна анхан шатны боловсруулалтын арга нь технологийн хувьд маш сул тул байгаль орчинд таагүй нөлөө үзүүлж байна. Иймээс үйлдвэрүүд дотооддоо гүн боловсруулалт хийж нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох чиглэлийн Хөнгөн аж үйлдвэржилтийн нэгдлийг бүтээн байгуулах нь чухал байна. Уг төслийг хэрэгжүүлснээр дараах бодит боломжууд бүрдэх юм. Үүнд:

- Хөнгөн үйлдвэрлэлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх.
- Байгаль орчинд халгүй үйлдвэрүүдийн нэгдлийг бий болгох.
- Үйлдвэрүүдийг кластер хэлбэрт шилжүүлж хөгжүүлэх.
- Экспортын баримжаатай импортыг орлох дотоодын үйлдвэрүүдийн тоо нэмэгдэнэ.
- Нэмүү өртгийг бий болгох замаар бүтээгдэхүүний борлуулалтын өсөлтийг хангаж, орлогыг нэг их наяд төгрөгт хүргэх.

- 10.000 орчим ажлын байрыг шинээр бий болгох.

Төслийн ТЭЗҮ-д тус төслийн эдийн засгийн үр өгөөжийг (IRR) 19% байхаар, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацааг 12 жил байхаар тооцоолсон байна. Уг төсөл нь эдийн засгийн үр өгөөж харьцангуй өндөр байхаар байгаагаас гадна нийгмийн хувьд чухал ач холбогдолтой төсөл байхаар боловсруулагджээ.

Арьс ширний үйлдвэрийн паркийг Эмээлтэд байгуулснаар хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн төрөлжсөн үйлдвэрүүдийн бааз энэ бүсэд үүсэх бөгөөд түүхий эд нийлүүлэлтийн сүлжээ бий болох, тээвэр логистикийн төвүүдийг үүсгэн хөгжүүлэх бодит боломж үүсэх бөгөөд, үүнийг дагаад орон нутагт түүхий эд нийлүүлэх ажлын байрууд бий болох, түүнийг дагаад малчид, орон нутгийн иргэдийн амьжиргаа сайжрах сайн нөлөөтэй. Үүнээс гадна Эмээлтийн парк дээр үйлдвэрүүд бий болж ажлын байрыг олноор нэмэгдүүлснээр Улаанбаатар хотын иргэдийг ажлын байраар хангах энэ бүс нутагт шинэ суурьшлын бүс үүсэх ингэснээр хотыг тэлэх, төвлөрлийг сааруулах гэх мэт хотод үүссэн олон сөрөг нөлөөг багасгахад чухал ач холбогдолтой төсөл болно.

Хэдий тийм боловч энэ төслийг хэрэгжүүлэхэд учирч болох дараах хүндрэл бэрхшээлүүдийг даван туулах, шийдвэрлэх шаардлагатай.

1. Одоогийн үйлдвэрүүдийн нүүлгэн шилжүүлэлт
2. Шаардагдах дэд бүтцийн тухайд
3. Ажиллах хүчин
4. Татвар хөнгөлөлтийн тухайд

Эдгээр асуудлуудын талаар дэлгэрэнгүй авч үзье.

#### 1. Одоогийн үйлдвэрүүдийн нүүлгэн шилжүүлэлт

Одоо Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа арьс ширний анхан шатны боловсруулалт хийж байгаа үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг Улаанбаатар хотоос гаргах шаардлагатай.

Нүүлгэн шилжүүлэхэд эдгээр үйлдвэрүүдийн Улаанбаатар хот дах үйлдвэрийн барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө, газрын худалдах, худалдан авах асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой шийдэл олох шаардлагатай.

#### 2. Шаардагдах дэд бүтцийн тухайд

Эмээлтийн паркийг байгуулахад шаардагдах дэд бүтцийн (газар, эрчим хүч, дулаан, зам, усан хангамж, ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламж) төлөвлөлтийг холбогдох бодлого болон төсвийн төлөвлөлтөд суулгах талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай уялдаж ажиллах, шийдвэр гаргуулах хэрэгтэй.

#### 3. Ажиллах хүчин

Энэ паркт ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургахад боловсрол сургалтын системийг чиглүүлэх бодлогын шийдлүүдийг гаргах хэрэгтэй болно. Мөн ажилчид энэ бүс нутагт амьдрахад зориулж шинэ суурьшлын бүсийг байгуулах түүнд шаардагдах нийгмийн дэд бүтцийн төлөвлөлтийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан хийх холбогдох шийдвэрүүдийг үе шаттайгаар гаргуулах хэрэгтэй юм.

#### 4. Татвар хөнгөлөлтийн тухайд

Энэ паркт хувийн хөрөнгө оруулалтыг татахад үйлдвэр технологийн паркийн хөнгөлөлтүүдийг үзүүлэх шаардлагатай байгаа бөгөөд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хөнгөлөлтийн хүрээнд татвар, гааль, үл хөдлөх хөрөнгө, газартай холбоотой цогц журмуудыг холбогдох байгууллагуудаас гаргуулах шаардлагатай юм.

## **Санхүүжилтийн тогтолцоо**

Эмээлтийн үйлдвэр технологийн паркийн санхүүжилтийн тогтолцоо нь дараах Дүрслэл 4.3-д үзүүлсэн байдлаар зохион байгуулж болно.



Төслийн удирдах нэгж нь гурвалсан гэрээний дагуу санхүүжилтийг төвлөрүүлж төслийн гүйцэтгэлийг хангуулах ажлыг зохион байгуулна.

Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн холбоо болон төслийн удирдах нэгж нь ажил гүйцэтгэчийг сонгон хамтарсан гэрээ байгуулж ажиллана.

## БҮЛЭГ 4. ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЦЭЭ, ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДЛООР НЬ ЭРЭМБЭЛЭХ АРГАЧЛАЛ

### 4.1 Нийтлэг үндэслэл

Улаанбаатар хотын санхүүжилтийн стратегийг боловсруулахад хөгжлийн санхүүжилтийн үндсэн зарчмуудыг баримтлах бөгөөд шалгарсан тодорхой төслүүд дээр тулгуурлан хийгдэнэ. Тухайн санхүүжилтийн стратегид орох төслүүдийг сонгох, ач холбогдлоор нь эрэмбэлэхэд тодорхой аргачлал ашиглах шаардлагатай юм. Улаанбаатар хотын хөгжилд захиргаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хамгийн өндөр ач холбогдолтой, яаралтай хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж байгаа хөрөнгө нөөцөө ашиглан хөрөнгө оруулалт хийхийн тулд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрүүдийг хэрхэн ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлалын саналыг боловсруулан энэ хэсэгт дэлгэрэнгүй оруулж байна.

Энэ аргачлалыг боловсруулахдаа олон улсад бодлогын болон төслүүдийн эрэмбийг хийхэд ашиглагддаг арга, аргачлалуудыг судлан үзсэн бөгөөд эдгээрээс бидний судалгааны ажлын зорилготой хамгийн ойролцоо 2 аргачлалын товч харьцуулалтыг хийлээ. Үүнд:

1. Азийн хөгжлийн банкны захиалгаар 2005 онд ПАДКО компанийн боловсруулсан “Хот байгуулалт, орон сууцны салбарын стратеги” судалгааны ажилд тэргүүлэх хөрөнгө оруулалтыг тогтоох аргачлалыг санал болгосон байна. Гэхдээ энэ аргачлал нь барилгын салбарын төслүүдэд зориулагдсан байна.

АХБ-ны аргачлалаар үнэлгээний шалгууруудыг гаргахдаа дараах 7 хүчин зүйлүүдийг харгалзан үзэхээр заажээ. Үүнд:

- төслийн саналыг боловсруулах хариуцлага бүхий хотууд, суурин газрын төвүүд, тэдгээрийн оршин суугч олон нийт, мэргэжлийн холбогдох хүмүүст маш тодорхой, ойлгомжтой чиглэлийг өгөх;
- Засгийн газрын болон АХБ-ны бодлого, стратегийг тусгасан байх,
- ОСХХТ-ний төслүүдийн туршлага, сургамжийг тусгах;
- төслүүдийн талаар холбогдох, үнэн зөв мэдээллийг гаргах;
- төслийн үр дагаврын талаарх хамгийн гол асуудлыг харгалзах;
- стратегийн тэргүүлэх чиглэл, хэрэгцээнд нийцсэн төслийг сонгох;
- хэрэгжүүлэх нь зардал, цаг хугацаа, ажиллах хүчний хувьд боломжийн байх.

Эдгээр хүчин зүйлүүдийг харгалзан тогтоосон шалгуураар эрэмбэлэхдээ дараах 2 үе шаттайгаар гүйцэтгэхээр байна.

**Нэгдүгээр алхам: Урьдчилсан шалгаруулалт.** Тэргүүлэх төслийн сонгон шалгаруулалтад хамааруулахаас өмнө хотын захиргаа, оршин суугчдын төлөөлөл гэх мэт байгууллагуудаас тавьж байгаа шаардлагуудыг судлан үзсэнээр урьдчилсан шалгаруулалтыг хийнэ.

Мөн төслүүдийн чиглэлүүдээс хамааран төслүүдэд зайлшгүй хавсаргах шаардлагатай баримтуудын жагсаалтыг гаргана.

Урьдчилсан шалгуурын төгсгөлд Төслийн удирдах нэгжүүдэд холбогдох техникийн зөвлөгөө, туслалцаа үзүүлж, санхүүгийн боломжит эх үүсвэрүүдийг тогтооно.

**Хоёрдугаар алхам: Шалгарсан төслүүдийг зэрэглэн дараалах.** Урьдчилан шалгарсан төслүүдийг ач холбогдлоор нь зэрэглэн дараалуулахад ил тод, шударга зарчмаар, оноогоор үнэлгээ хийх аргыг дараах дарааллаар гүйцэтгэхийг санал болгосон байна. Үүнд:

- Төслүүдийн төрөл бүрд өөр өөр багц шалгууруудыг тогтоож, төсөл хэрэгжүүлэгч талуудад мэдээлэх,
- Төслүүдийн үнэ цэнийн төсөөлөл, магадлалыг тодорхойлох,
- Оноогоор үнэлгээний аргыг хэрэглэх зэрэг болно.

2. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын 2009 онд хийсэн “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа”-ны ажилд тэргүүлэх хөрөнгө оруулалтыг тогтоох аргачлалыг санал болгосон байна.

Тус аргачлалд үнэлгээний үндсэн гол шалгууруудыг сайн хэлэлцэн тогтоож, улмаар тоон зэрэглэх системтэй хослуулан хэрэглэхийг санал болгосон. Ингэхдээ дараах 5 гол шалгуурыг тодорхойлсон. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн байдал;
- Нэн шаардлагатай байдал;
- Хэрэгцээ;
- Хэрэгжих бүрэн боломжтой байдал,
- Олон нийтийн хүлээн зөвшөөрсөн байдал, дэмжлэг.

Үүнээс гадна байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзсэн. Гэвч эдгээр шалгууруудаар оноо өгөхдөө ямар аргачлал, загвар ашиглах талаар санал болгоогүй байна.

Бид өмнө дурдсантай ижил аргуудыг одоо ашиглаж байгаа засгийн газрын холбогдох газар, агентлагийн ажилтнуудтай харилцан мэдээлэл солилцож, олон улсад ашигладаг болон Монгол улсад санал болгосон аргачлалуудыг судалж үзсэний үндсэн дээр энэхүү аргачлал, загварыг санал болгож байна. Мөн тус аргачлалыг Улаанбаатар хотын захиргаанд нэгтгэн боловсруулагдсан 90 төслүүдийг эрэмбэлэхэд туршин үзсэн бөгөөд ингэснээрээ уг аргачлалын ашиглагдахуйц байдлыг анхаарч үзсэн.

## 4.2 Хамрах хүрээ, зорилго

Энэхүү аргачлалыг Улаанбаатар хотын хөгжлийн зорилтыг хангахад шаардагдах хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмбэлэхэд зориулан боловсруулсан бөгөөд эрэмбэлэлтийг хийхэд эдгээр төслүүдийн техник, эдийн засгийн судалгаа хийгдэж үнэлгээ хийхэд шаардагдах үзүүлэлтүүдийг бэлтгэх шаардлагатай болно. Мөн Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хангах хүрээнд шаардагдах хөрөнгө оруулалтын төслүүдийг үнэлэхэд энэ аргачлалыг ашиглана.

Энэхүү аргачлалын үндсэн зорилго нь Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад шаардагдах хөрөнгө оруулалтын төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэхэд чиглэгдсэн юм. Тиймээс төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хэрхэн босгох боломж, бололцооны талаар энэ аргачлалын хүрээнд авч үзээгүй ба энэ талаар санхүүжилтийн стратегийн бүлэгт олон хувилбарт стратегийн саналууд болон тодорхой жишээнүүдийг оруулсан болно.

## 4.3 Суурь зарчим

Монгол Улсад өнөө цагт нэн тэргүүнд тулгамдаж байгаа асуудлуудын суурь шалтгааныг бүсийн болон салбарын тэнцвэргүй хөгжил гэж урьд өмнө хийж байсан судалгааны ажлуудад дүгнэсэн байдаг. Товчхондоо бол хөдөө орон нутагт амьдарч буй иргэд боловсрол эрүүл мэнд, зам харилцаа зэрэг нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмжтэй үйлчилгээ авч чадахгүй байх, тогтвортой ажлын байраар хангагдаж чадахгүй байгаа зэргээс шалтгаалан хүний хөгжлийн хангагдах зарчмууд биелэгдэхгүй байгаагаас улбаалан хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин суурьшсан иргэдийн тоо нь эрчимтэй өсөж нийслэлийн хүн амын өсөлтийг хурдасгасан шалтгаан болсон ба, үүнээс үүдэн гэр хорооллын бүс тэлж, агаарын болон байгаль орчны бохирдлыг нэмэгдүүлэх, нийслэлийн иргэдийн тэр



дундаа захын хорооллын иргэдийн нийгмийн болон суурь үйлчилгээний хүртээмжид муугаар нөлөөлөх үүнээс үүдэлтэй сөрөг дам нөлөөнүүдийг үүсгээд байна. Эдгээрээс үүдэлтэй нийслэлд эрүүл мэнд, боловсролын салбаруудын ачаалал болон цахилгаан эрчим хүч, цэвэр бохир ус, замын дэд бүтцийг сайжруулан, хүчин чадлыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага хурцадсан асуудал болсон байна. Үүнээс гадна Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдол, найдвартай усан хангамжийн асуудал аюулын түвшинд хүрснийг холбогдох байгууллагууд мэдээлсээр байна.

Тиймээс Монгол хүний эрүүл аюулгүй орчинд, зохистой ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүнд чиглэгдсэн Улаанбаатар хотын хөгжлийн зорилтуудыг хангахад шаардагдах хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд дараах 8 хүчин зүйлүүдийг авч үзэх шаардлагатай. Эдгээр шалгуур хүчин зүйлүүдийг авч үзсэнээр төслүүдийн ач холбогдол болон хөгжлийн зорилтуудыг хангахад тустай юм.

Шалгуур хүчин зүйлүүд	Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан байдал
✓ <b>Бүсийн болон салбарын тэнцвэртэй хөгжил,</b>	Зорилт 10: Тэгш бус байдлыг бууруулах, Зорилт 9: Дэд бүтцийг хөгжүүлэх, Зорилт 3: Эрүүл мэндийг дэмжих, Зорилт 4: Чанартай боловсролыг дэмжих.
✓ <b>Байгаль орчинд үзүүлэх нөлөө,</b>	Зорилт 13: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг багасгах, Зорилт 7: Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, Зорилт 9: Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх.
✓ <b>Төслийн үр дүнд шууд болон шууд бусаар бий болох өгөөж,</b>	Зорилт 1: Ядуурлыг устгах, Зорилт 2: Өлсгөлөнг зогсоох мөн бусад бүх зорилтуудад тодорхой нөлөө үзүүлнэ.
✓ <b>Цаашид хэрэгжүүлэх бусад төслүүдэд түлхэц, дэмжлэг болох байдал, үр нөлөөний цар хүрээ,</b>	Бүх зорилтуудад тодорхой нөлөө үзүүлнэ.
✓ <b>Төслийн үр өгөөж бий болох хугацаа болон өгөөж өгөх үргэлжлэх хугацаа,</b>	Бүх зорилтуудад тодорхой нөлөө үзүүлнэ.
✓ <b>Ард иргэдийн хэрэгцээ болон улс төрийн хүчин зүйл талаас хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг,</b>	Бүх зорилтуудад тодорхой нөлөө үзүүлнэ.
✓ <b>Байгаль орчинд ээлтэй, өндөр бүтээмж, үр ашигтай дэвшилтэт технологи,</b>	Зорилт 8: Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих, Зорилт 13: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг багасгах, Зорилт 7: Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх, Зорилт 9: Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх.
✓ <b>Бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдсан байдал.</b>	Бүх зорилтуудад тодорхой нөлөө үзүүлнэ.

Эдгээр шалгуур хүчин зүйлүүдийг дэлгэрэнгүй тайлбарлая.

## **1.Бүсийн болон салбарын тэнцвэртэй хөгжил**

Тэнцвэртэй хөгжлийг ерөнхийдөө 2 талаас нь буюу бүсчлэл байршлаар болон салбараар нь хэмждэг. Аргачлалын энэ шалгуураар төслүүдийг үнэлэхдээ Улаанбаатар хотын дүүрэг, хороодын иргэдэд хүрч буй цэцэрлэг сургууль, эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, чанар мөн түүнчлэн тухайн байршлын бүсэд эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, зам харилцаа, мэдээлэл технологийн салбаруудын хөгжил хэр зэрэг тэнцвэртэйгээр явагдаж байгааг харгалзан үзнэ. Мөн Улаанбаатар хотын

хэт төвлөрлийг сааруулах, захын дүүрэг, хороодыг хөгжүүлэх, нийслэлийн бүсчилсэн бодлогод нийцэж байгааг шалгуур болгон авч үзэх шаардлагатай.

## **2.Төслийн үр дүнд шууд болон шууд бусаар бий болох өгөөж**

Аливаа төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тодорхой шууд үр дүнгүүд гардаг боловч ялангуяа урт хугацааны тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн томоохон төсөл, хөтөлбөрүүд нь шууд нөлөөнөөс гадна ихэвчлэн дам нөлөөллөөр нийгэм, эдийн засгийн хөгжилд үр дүнг бий болгодог. Тиймээс ийм томоохон төсөл хөтөлбөрүүдийн үр нөлөөлөл нь нийгэм, эдийн засгийн өргөн цар хүрээг хамардаг учраас тухайн төслийн үр нөлөөг тусад нь хэмжиж тодорхойлох боломжгүй байдаг. Энэ шинж чанарыг харгалзан тухайн төслийг хэрэгжүүлснээр бий болох ажлын байр, цаашид ажилчдын ажлын ур чадварыг сайжруулахад нөлөөлөх байдал, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх байдал, тухайн төслийн үр дүнгээр цаашид төсвийн орлогыг нэмэгдүүлж эсвэл зардлыг бууруулах үр нөлөөг харгалзан үзэх хэрэгтэй.

## **3.Цаашид хэрэгжүүлэх бусад төслүүдэд түлхэц, дэмжлэг болох байдал, үр нөлөөний цар хүрээ**

Тодорхой хөгжлийн зорилтыг хангахад бодлогын уялдаа, харилцан бие биеэ тэтгэх байдал эерэг үр дүнг авчрахад тулгуур зарчим болдог. Тиймээс бодлогын уялдаа эрэмбээс үүдэлтэй аливаа төслийг амжилттай хэрэгжүүлснээр дараагийн бусад төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл, боломжийг бүрдүүлэхүйц, бусад төслүүдийн суурь түлхэц болох чухал шинж чанарыг үнэлж үзэх нь чухал юм. Мөн үүний адилаар төслийн үр нөлөөний боломжит цар хүрээ хэр их байх, иргэдийн амьдралын чанарт үзүүлэх нөлөөлөл хэр их байх гэсэн шалгууруудыг үнэлгээнд харгалзан үзэх хэрэгтэй.

## **4.Төслийн үр өгөөж бий болох хугацаа болон өгөөж өгөх үргэлжлэх хугацаа**

Хөгжлийн тогтвортой үр нөлөөг хангахын тулд авч буй арга хэмжээ бодлогын шийдлүүдийн холыг харсан өргөн цар хүрээтэй найдвартай байдлыг чухалчилж үздэг. Ингэхдээ оруулж буй хөрөнгө оруулалтын үр өгөөжийг цаг хугацааны талаас нь хэмжиж үзвэл: өгөөжөө өгч эхлэх хугацаа нь хурдан байх, өгөөжөө өгөх үргэлжлэх хугацаа аль болох олон жил байхыг анхаарах шаардлагатай.

## **5.Иргэдээс болон улс төрийн хүчин зүйл талаас төсөл хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг**

Хөгжлийг урагшлуулах, хөгжлийн зорилтуудаа тодорхойлж гаргаж ирэхдээ өнөөгийн бодит байдал, иргэдийн амьдралд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн байх шаардлагатай байдаг. Тийм учраас бодлогын шийдэл хийхдээ олон нийтийн оролцоог хангах, тэдний бодит хэрэгцээнд тулгуурлах хэрэгтэй бөгөөд төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын саналууд нь ард нийтийн дэмжлэгийг авсан байх ёстой. Түүнээс гадна ийм төслүүдийг бодит ажил болгон хэрэгжүүлэхэд улс төрийн болон шийдвэр гаргах түвшний дэмжлэг чухал нөлөөтэй. Мөн түүнчлэн тухайн төслүүд нь нийгмийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, нийгмийн эмзэг бүлэг тэр дундаа ядуу өрх, иргэдэд чиглэгдсэн байдлыг тусгайлан авч үзэх хэрэгтэй бөгөөд энд чиглэсэн шалгуур үзүүлэлтийг тогтоосон.

## **6.Байгаль орчинд үзүүлэх нөлөө**

Байгаль орчинд тулгамдаж буй өнөөгийн нөхцөл байдал нь хүмүүний амьдралд шууд болон шууд бусаар сөргөөр нөлөөлж хүний эрүүл аж төрөх, аж ахуй эрхлэх бүхий л зүйлд шууд нөлөөлж байна. Иймд хүний оролцоотой аливаа үйлдлийг хийхдээ байгальд ээлтэй байх, байгаль орчныг доройтуулахгүй байх, энэ доройтлыг бууруулахад чиглэгдсэн байх зэрэг нь хүн төрөлхтний урт удаан оршин тогтнохуйтай шууд холбоотой болж байна. Иймээс авч буй бодлогын шийдэл, хөрөнгө оруулалтыг үнэлэх, эрэмбэлэхдээ байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг хамгаас чухалчилж үзэх шаардлагатай тул энэ аргачлалд байгаль орчны шалгуур үзүүлэлтийг чухалчилж өндөр жин тавьж өгсөн.

## **7. Байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай дэвшилтэд технологи**

Байгал орчны тогтвортой байдлыг хангах, байгальд ээлтэй үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд өндөр техник технологийг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага хурцаар тавигдаж байгаа бөгөөд олон улсад ийм техник, технологийн хөгжил жил бүр улам хурдасч байна. Тиймээс дээрх хүчин зүйлүүдээс гадна байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай дэвшилтэд технологийг хэрэглээнд нэвтрүүлэх төслүүд мөн өндөр ач холбогдолтой, хэрэгцээтэй болж байна.

## **8. Бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдсан байдал**

Аливаа хөгжлийн төслүүдийн бодлоготой уялдсан байдлыг үнэлэхдээ бодлогын зорилго, зорилттой харьцуулан үнэлэх матрицын аргыг хэрэглэх бөгөөд үүнийг хийхдээ төсөл тус бүрийг холбогдох бодлогын баримт бичгүүдтэй харьцуулж үнэлнэ. Энэ харьцуулсан матрицыг Хавсралт хүснэгт 11-ээс харна уу. Бодлогын уялдааг үнэлсэн энэ матриц дээр тулгуурлан төслүүдийг эрэмбэлэх нэгдсэн шалгуур үнэлгээг доорх Хүснэгт 3.1-д хийнэ.

## **4.4 Аргачлал, үнэлгээний загвар**

Төслүүдэд шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээ өгөх ажил нь үндсэндээ техник-эдийн засгийн судалгаан дээр тулгуурлан хийгддэг. Тиймээс ТЭЗҮ-ийн баримт бичигт тэдгээр шалгуур үзүүлэлтүүдийг үнэн зөв дүгнэхэд шаардагдах мэдээллийг хангалттай агуулсан байх гол нөхцөл тавигдаж байгаа юм. Төслүүдийн саналд үнэлгээ өгөхийн тулд төслийн санал боловсруулж буй талуудад төслийн агуулгад заавал багтаах мэдээллүүдийг тодорхой болгож, зааварчилгаа өгсөн байх шаардлагатай. Хэрэв төслүүдэд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл хангалтгүй бол нэмж тодруулах ажлыг үнэлгээний ажилтнууд гүйцэтгэнэ.

Төслүүдийг үнэлэхдээ дээр дурдсан шалгуур хүчин зүйлүүдийн хүрээнд үнэлэх бөгөөд тэргүүлэх ач холбогдлоор үнэлэх үнэлгээний загварт тоон зэрэглэх системийг хэрэглэх нь эрэмбэлэх ажлыг оновчтой болгох бөгөөд төслүүдийн давуу болон сул талуудыг орхигдуулж, аль нэг үзүүлэлтэд илүү ач холбогдол өгөх буюу өрөөсгөл шийдвэр гаргах магадлалыг бууруулах юм.

Мөн шалгуур үзүүлэлтүүд нь ач холбогдлын хувьд өөр хоорондоо ялгаатай тул чухал ач холбогдолтой үзүүлэлтүүдэд илүү жин өгсөн. Мөн шалгуур үзүүлэлтүүдийн агуулга нь тухайн асуудлыг бүрэн тодорхойлох боломжтой, агуулгын хувьд бүрэн байх талаас нь анхаарсан юм.

Тиймээс дээр дурдсан үндсэн найман шалгуур үзүүлэлтүүдийн дагуу нарийвчилсан асуулгаар оноо өгөхөд дараах Хүснэгт 3.1-д үзүүлсэн загварыг ашиглана.

## **4.5 Аргачлалын туршилт, хэрэглээ**

Энэхүү санал болгосон аргачлалыг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан 90 төслүүдийг эрэмбэлэхэд ашиглан туршиж үзье.

Хүснэгт 3.1-д санал болгож буй загварын дагуу төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь үнэлж, өндөр онооноос бага оноо руу эрэмбэлснийг Хавсралт хүснэгт 12.5-д нэгтгэн харуулав.

УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан төсөл, хөтөлбөрүүдийн төсвийн нэгтгэлийг Хавсралт хүснэгт 12.1-д үзүүлэв.

Энэхүү аргачлалын дагуу Тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн эхний 10 төслүүдийн мэдээллийг Хавсралт хүснэгт 12.2-д үзүүлэв. Харин эрэмбэлэгдсэн эхний 10 төслүүдийн хувьд Төсөл хэрэгжүүлэх хугацааны судалгааг Хавсралт хүснэгт 12.3-д, Төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх салбарыг Хавсралт хүснэгт 12.4-д тус тус үзүүлэв. Эдгээр төслүүдийн нэр, төлөвлөгөөт ажлын агуулга, кодчиллын тухай товч мэдээллийг Хавсралт хүснэгт 12.6-аас авч болно.

**Хүснэгт 4.1. Төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь оноо өгч, тооцоолох загвар**

Шалгуур үзүүлэлтүүд	Жин	Оноо	Нийт оноо
<b>1.Төслийн үр дүнд шууд болон шууд бусаар бий болох өгөөж</b>			
иргэдийн мэргэжил, боловсрол, ажлын ур чадварыг нэмэгдүүлнэ	3		
ажлын байрыг бодитойгоор нэмэгдүүлнэ	3		
иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ	2		
цаашид дэд бүтцийн өртгийг бууруулна	1		
<b>2.Цаашид хэрэгжүүлэх бусад төслүүдэд түлхэц, дэмжлэг болох байдал, үр нөлөөний цар хүрээ</b>			
төсөл нь дараагийн шатны хөгжлийн төслүүдийн суурь нөхцөлийг бүрдүүлнэ	3		
олон салбар эсвэл бүс нутагт эерэг нөлөө үзүүлнэ	2		
нийслэлийн хүн амын 5-аас багагүй хувьд эерэг нөлөө үзүүлнэ	1		
<b>3.Төслийн үр өгөөж бий болох хугацаа болон өгөөж өгөх үргэлжлэх хугацаа</b>			
10-аас дээш жилийн турш өгөөжөө тогтвортой өгнө	3		
1 жилээс бага хугацаанд өгөөжөө өгч эхэлнэ	2		
10-аас дээш жилийн турш тодорхой хэмжээгээр өгөөжөө өгнө	1		
<b>4.Иргэдээс болон улс төрийн хүчин зүйл талаас хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг</b>			
өндөр хэрэгцээтэй болох нь нийгэмд ил болсон	3		
улс төрийн бодлогын талаас идэвхтэй дэмжлэгтэй	2		
ядуу, эмзэг давхаргад эерэг нөлөө үзүүлнэ	2		
судалгаагаар хэрэгцээтэй болох нь тогтоогдсон	1		
<b>5.Байгаль орчинд үзүүлэх нөлөө</b>			
агаарын бохирдлыг бууруулна	3		
хүлэмжийн хий ялгаралтыг бууруулна	3		
газар, хөрсний бохирдлыг бууруулна	3		
усны бохирдлыг бууруулж, нөөцийг хамгаална	3		
<b>6.Байгаль орчинд ээлтэй, өндөр үр ашигтай дэвшилтэд технологи</b>			
хэрэглээнд нэвтрүүлэх шинэ технологийн бүтээмж нь өндөр ба зардал ихээр хэмнэнэ	3		
хэрэглээнд нэвтрүүлэх шинэ технологийг 10-аас дээш жил тасралтгүй ашиглах боломжтой	2		
хэрэглээнд нэвтрүүлэх шинэ технологи нь сүүлийн 5 жилийн хугацаанд бий болсон	1		
<b>7.Бүсийн тэнцвэртэй хөгжил</b>			
төсөл хэрэгжүүлэх тухайн бүсэд үүссэн хэрэгцээ нь бусад бүсүүдтэй харьцуулахад харьцангуй нэн шаардлагатай байгаа	3		
хотын бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцэж байгаа	2		
<b>8. Бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдсан байдал</b>			
холбогдох хөгжлийн зорилтуудтай уялдсан, тэдгээрийг хангахад чиглэгдсэн байдал	3		
<b>Нийт оноо</b>			

Эх сурвалж. УБАК

**Хүснэгт 4.2.Үзүүлэлт, онооны хүснэгт**

Үзүүлэлт	Оноо
Маш их	3
Их	2
Бага	1
Мэдэгдэхгүй эсвэл тодорхойлох боломжгүй бол	0

Эх сурвалж. УБАК

## БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын өнөөгийн нэн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх өндөр ач холбогдол бүхий төслүүдийг санаачлан хэрэгжүүлэхээр төр, захиргааны байгууллагууд зорин ажиллаж байгаа хэдий ч, олон талын томоохон асуудал, саад бэрхшээлүүд байгаа нь энэхүү судалгааны ажлын дүгнэлтээс харагдаж байна.

Тэдгээр асуудлыг шийдвэрлэж, санхүүжилтийг татан, төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бидний санал болгосон стратеги, бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй ба үүний тулд хууль, эрх зүй, төрийн захиргааны удирдлагын тогтолцооны шинэчлэл хийх шаардлагатай байна.

Улаанбаатар хотын хөгжлийн зорилтыг хангахад шаардагдах төслүүдийг үр өгөөж болон хэрэгжих боломжит байдлаар нь судлан боловсруулж, төслүүдийн эдийн засгийн болон нийгмийн үр нөлөөгөөр нь эрэмбэлэн хэрэгжилтэд чиглэсэн арга хэмжээ, шийдлүүдийг гаргах шаардлагатай.

### **Санхүүжилтийн стратегийн хүрээнд:**

- (1) хууль, эрх зүйн орчныг сайжруулах,
- (2) хөрөнгө оруулалтын удирдлага, менежментийг сайжруулах,
- (3) Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн тогтолцоонд иргэд, олон нийтийн оролцоог хангах,
- (4) Хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
- (5) Гадаад эх үүсвэрийг татах,
- (6) Улаанбаатар хотын орлогын шинэ эх үүсвэрийг бий болгох,
- (7) Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоог бий болгох зэрэг саналыг дэвшүүлж байна.

Бид “Олон нийтэд түшиглэсэн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх” 5 дах стратегийн хүрээнд санал болгосон санхүүжилтийн тогтолцоог бий болгох аргачлалыг хэрхэн ашиглах талаар 2 тодорхой төсөл дээр жишээ болгон авч үзсэн. Мөн “Хөгжлийн төслүүдийг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх” аргачлалыг боловсруулж, түүнийг хэрхэн ашиглах туршилтыг хийн, жишээн дээр дэлгэрэнгүй тайлбарласан болно.

## ХАВСРАЛТУУД

**Хавсралт хүснэгт 1. Улаанбаатар хотын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний цаглабар, хяналтад баримтлах шалгуур (Төсвийн жил: нэгдүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31)**

Хугацаа	Үйл ажиллагаа болон хариуцах байгууллага	Төсөв, хөрөнгө оруулалтын төслийг хянахад баримталдаг шалгуур	Холбогдох хууль, журам
<b>Төсөв боловсруулах</b>			
1-6 сар хүртэл	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын удирдлага дор Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө (ҮАХТ), үйл ажиллагааны хөтөлбөрийг (ҮАХ) боловсруулна.	1.Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /сонгуулийн дараа 6-9 сар хүртэл боловсруулна./, тухайн төсвийн жилийн нийгэм, эдийн засгийн зорилт; эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /6-10 сар хүртэл боловсруулна/ 2.улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого;4.салбарын хөгжлийн бодлого; 5.бүсчилсэн хөгжлийн бодлого; 6.орон нутгийн хөгжлийн хэрэгцээ;	ТТХ 2011.12.23  Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн заалтыг тусгах
5 дугаар сарын 1-ны дотор	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам (СЯ) төсвийн хүрээний мэдэгдлийг УИХ-д өргөн барина.	СЯ Монгол улсын ирэх оны төсвийн хүрээний мэдэгдлийг дараах шалгуур үзүүлэлтийг үндэслэн тооцож төлөвлөнө. 1.дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ; 2.хэрэглээний үнийн өсөлтийн түвшин; 3.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ; 4.нэгдсэн төсвийн нийт зарлагын нийт хэмжээ; 5. нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ; 6.Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл; 7.нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ; 8.улсын өрийн нийт хэмжээ; 9.төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ;	ТТБТХ 2010.06.24
7 дугаар сарын 1-ний дотор	СЯ ирэх оны төсөв боловсруулах удирдамж, төсвийн хүрээний мэдэгдлийг хүргүүлнэ.	Төсвийн удирдамжид дараах шаардлага шалгуурыг тусгасан байна. 1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоо болон гаргасан шийдвэрийн тайлбар; 2.Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаар; 3.улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний талаарх бодлогын удирдамж;	ТТХ 2011.12.23

		<p>4.хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага;</p> <p>5.төсвийн төслийн санхүүжилтийн хүсэлт гаргах ерөнхий нөхцөл;</p> <p>6.төсвийн төсөл бэлтгэх тусгай маягт, түүний заавар;</p> <p>7.төсвийн төсөл хүргүүлэх хугацаа;</p>	
7 дугаар сарын 1-ний дотор	<p>(1) Улаанбаатар хотын орон нутгийн төсөвт байгууллагууд ирэх оны төсвийн орлого, зарлагын төслөө боловсруулан, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналын хамт нийслэл, дүүрэгт хүргүүлнэ. (2) Нийслэлийн харьяа байгууллагууд (боловсрол, эрүүл мэнд, авто зам гм салбар бүрээр) хөрөнгө оруулалтын саналаа боловсруулан НЗДТГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтэс (НБТХ)-т хүргүүлнэ. (3) Дүүргийн хөрөнгө оруулалтын мэргэжилтэн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн дүүргийн удирдлага, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн нийслэлд хүргүүлнэ. (4) Дүүргээс төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл, арга хэмжээний саналаа боловсруулж НБТХ-т хүргүүлнэ.</p>	<p><u>Төсвийг төлөвлөх үндсэн шалгуур:</u></p> <p>1.төсвийн зарчмыг мөрдлөг болгох;</p> <p>2.макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх;</p> <p>3.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх;</p> <p>4.жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх;</p> <p>5.төсвийн төслийг хөтөлбөр, зориулалт арга хэмжээ бүрээр тодорхойлсон байх;</p> <p>6.төсвийн хязгаарыг урсгал болон хөрөнгийн зардлаар тогтоосон байх;</p> <p>7.хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинэ болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгасан байх;</p> <p><u>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үндсэн шалгуур:</u></p> <p>1.улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого;</p> <p>2.эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж;</p> <p>3.нийгмийн ач холбогдол;</p> <p>4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл;</p> <p>5.төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт;</p> <p>6.салбарын хөгжлийн бодлого;</p> <p>7.бүсчилсэн хөгжлийн бодлого;</p> <p>8.орон нутгийн хөгжлийн хэрэгцээ;</p> <p>9.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл;</p> <p>10.нийслэл, дүүргийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр;</p>	ТТХ 2011.12.23
7 дугаар сарын 25-ны дотор			
8 дугаар сарын 10-ны дотор	<p>(1) Дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс (СТСХ) төсвийн төслөө хянаж нэгтгэн, урсгал төсвийн саналаа НЗДТГ-ын СТСХ-т, (2) НБТХ нийт саналыг</p>	<p><u>Төсвийг төлөвлөх үндсэн шалгуур:</u></p> <p>1.төсвийн зарчмыг мөрдлөг болгох;</p> <p>2.макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх;</p>	ТТХ 2011.12.23



(2) 8 дугаар сарын 1-ний дотор	хүлээн авч салбар бүрээр эрэмбэлэн улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн саналын жагсаалтыг объект, арга хэмжээ нэг бүрээр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ирэх оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар салбарын яамдад хүргүүлнэ.	3.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх; 4.жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх; 5.төсвийн төслийг хөтөлбөр, зориулалт арга хэмжээ бүрээр тодорхойлсон байх; 6.төсвийн хязгаарыг урсгал болон хөрөнгийн зардлаар тогтоосон байх; 7.хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинэ болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгасан байх;	
8 дугаар сарын 1-ний дотор	Нийслэл төсвийн төслөө нийслэлийн хэмжээгээр нэгтгэж боловсруулан урсгал төсвийн саналаа СЯ-нд, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналаа холбогдох улсын төсвийн ерөнхийлөн захирагч (салбарын яамд)-д хүргүүлж хянуулна.	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үндсэн шалгуур: 1.улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого; 2.эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж; 3.нийгмийн ач холбогдол; 4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл; 5.төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт; 6.салбарын хөгжлийн бодлого; 7.бүсчилсэн хөгжлийн бодлого; 8.орон нутгийн хөгжлийн хэрэгцээ; 9.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл; 10.нийслэл, дүүргийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр;	ТТХ 2011.12.23
8 дугаар сарын 20-ны дотор	Төсвийн ерөнхийлөн захирагч (салбарын яамд)-д харьяалах багцын хөрөнгө оруулалтын жагсаалтыг тухайн төсвийн жилийн хөрөнгө оруулалтын зардлын хязгаарт багтаан СЯ-нд хүргүүлж хянуулна.	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үндсэн шалгуур: 1.улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого; 2.эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж; 3.нийгмийн ач холбогдол; 4.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл; 5.төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандарт; 6.салбарын хөгжлийн бодлого; 7.бүсчилсэн хөгжлийн бодлого; 8.орон нутгийн хөгжлийн хэрэгцээ; 9.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл; 10.нийслэл, дүүргийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр;	ТТХ 2011.12.23

9 дүгээр сарын 15-ны дотор	<p>(1) Улсын төсвийн хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл, арга хэмжээний саналыг салбарын сайдын төсвийн багцад багтаан төлөвлөн, СЯ нэгтгэнэ.</p> <p>(2) СЯ салбарын сайдын багц бүрээр хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн саналыг хүлээж аваад улсын төсвийн хөрөнгө оруулалтын хязгаар, орлогын боломжид үндэслэн хянаж салбарын сайдын багц бүрээр, объект, арга хэмжээ бүрээр жагсаалт гарган тухайн жилийн төсвийн төслийн хамт Засгийн газарт өргөн мэдүүлнэ.</p>	<p>СЯ Монгол улсын ирэх оны төсвийн төслийг боловсруулахдаа дараах тусгай шаардлага, шалгуурын хангасан байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1.нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;</li> <li>2.нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;</li> <li>3.тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээх хэтрэхгүй байх;</li> <li>4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.</li> <li>5. Засгийн газрын өрийн хязгаар нь эрчим хүч, төмөр зам, уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газар хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй;</li> <li>6. Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй.</li> </ol>	ТТХ 2011.12.23
10 дугаар сарын 1-ний дотор	СЯ Монгол Улсын ирэх оны төсвийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлнэ	<p>УИХ-д Засгийн газрын өргөн барьсан төсөв дараах шаардлагыг хангасан байна:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.макро эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээ, ирээдүйн чиг хандлагын төсөөлөл, тооцоо;</li> <li>2.макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах талаар Засгийн газраас тухайн жилд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлыг төсвийн төсөлд тусгасан байдал;</li> <li>3.төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг тооцсон байдал;</li> <li>4.төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээ;</li> <li>5.төсвийн жилийн татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөлөл;</li> </ol>	ТТХ 2011.12.23

		<p>6.хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/;</p> <p>7.санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар;</p> <p>8.гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, объект, үнийн дүнгээр/;</p> <p>9.тусгай сангийн орлого, зарлагын тооцоо;</p> <p>10.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ;</p> <p>11.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга;</p> <p>12.төсвийн тусгай шаардлагад болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж байгаа талаарх тайлбар;</p> <p>13.төсвийн тусгай шаардлагыг түр баримтлахгүй тохиолдолд түүний үндэслэл, санал;</p> <p>14.нэгдсэн төсвийн орлого, зарлагын үзүүлэлтийн хураангуй тайлбар;</p> <p>15.төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон байдал;</p> <p>16.төсөв алдагдалтай төлөвлөгдсөн бол уг алдагдлыг санхүүжүүлэх тухай санал;</p> <p>17.Засгийн газрын өрийн үлдэгдэл, төслийн зээлийн дотоод эх үүсвэрийн хэмжээ, Засгийн газраас гаргасан баталгаа, түүний дүн;</p> <p>18.нэгдсэн төсвийн орлогын нэг хувиас хэтэрсэн дүнтэй тэнцэх болзошгүй өр төлбөр, түүнээс учирч болзошгүй эрсдэлийн тооцоо;</p>	
11дүгээр сарын 15-ны дотор	УИХ Монгол улсын төсвийг хэлэлцэн батална	<p>Монгол улсын төсөв батлах тухай хууль дараах төсвийг хуульчлан батална.</p> <p>1.Монгол улсын төсөвт тухайн төсвийн жилд төвлөрүүлэх орлогын хэмжээ ерөнхийлөн захирагч түүний харьяа болон бусад байгууллагын дүнгээр;</p> <p>2.Монгол улсын төсөвт тухайн жилд төвлөрүүлэх тэнцвэржүүлсэн орлогын нийт дүн;</p> <p>3.Монгол улсын төсвөөс тухайн төсвийн жилд нийт зарлагын дүн;</p>	ТТХ 2011.12.23

		4.Монгол улсын төсвийн хөрөнгөөр тухайн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, төсөл арга хэмжээний жагсаалт; 5.Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг;	
<b>Төсөв өргөн мэдүүлэх</b>			
(1) 12 дугаар сарын 1-ны дотор	(1) УИХ-аар улсын төсөв баталсны дараа СЯ нийслэлийн улсад төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутгийн төсөв батлах бодлого, чиглэлийн талаар удирдамж хүргүүлнэ.	Төсвийн удирдамжид дараах шаардлага тусгана. 1.улсын төсөв батлахад төсвийн орлогын талаар баримталсан бодлого; 2.төсвийн зарлагад баримталсан бодлого; 3.нийслэлийн төсвөөс тухайн төсвийн жилд улсад төвлөрүүлэх орлогын хэмжээ; 4.нийслэлийн төсөвт ОНХНС-аас нийслэлийн ОНХС-д олгох шилжүүлгийн хэмжээ;	
(2) 11 дүгээр сарын 25-ны дотор	(2) Дээрх удирдамжийг үндэслэн нийслэл төсвийн төслөө дахин боловсруулж, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-д өргөн барина.		
<b>Төсөв хэлэлцүүлэх ба батлах</b>			
(1) 12 дугаар сарын 5-ны дотор	(1) Нийслэл төсвийн төслөө Нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлнэ. (2) Нийслэлийн ИТХ төсөв баталсны дараа нийслэлийн төсөвтэй шууд харилцагч байгууллага, дүүргүүдэд төсөв баталсан шийдвэр, хэрэгжүүлэх чиглэлийн талаар удирдамж хүргүүлнэ. (3) Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийг объект нэг бүрээр Нийслэлийн ИТХ-аар батална.	1.нийслэлийн шууд төсөвт тухайн төсвийн жилд орох орлогыг орлого бүрдүүлэгч байгууллага, орлогын нэр төрлөөр; 2. Төсвийн урсгал зардлыг тухайн байгууллагад төсвийн жилд олгох зардлыг нийт дүнгээр; 3 Тухайн төсвийн жилд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийг объект нэг бүрээр санхүүжилтийн эх үүсвэрээр нь тухайн төсвийн жилд олгох санхүүжилтийн дүнгээр; 4.Нийслэлийн төсвөөс дүүрэгт олгох санхүүгийн дэмжлэгийг дүүрэг бүрээр нийт дүнгээр нь; 5.Нийслэлд орлого төвлөрүүлдэг дүүргийн төвлөрүүлэх орлогын хэмжээг дүүрэг бүрээр дүнгээр нь; 6.Нийслэлийн төсвөөс улсад төвлөрүүлэх орлогын хэмжээг хуульд заасан дүнгээр; 7.Нийслэлийн ОНХС-аас дүүргүүдэд олгох ОНХС-ийн хэмжээг дүүрэг бүрээр, дүнгээр нь;	ТТХ 2011.12.23
(2) 12 дугаар сарын 10-ны дотор	Дүүргийн ЗДТГ-аас ИТХ-д төсөв өргөн барина.		

		8.Дүүргүүдэд олгох тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг салбарын сайдын багцаар ТЗШ тус бүрээр нийт зардал, өөрийн үйл ажиллагааны орлогын дүнгээр;	
12 дугаар сарын 20-ны дотор	Дүүргийн ИТХ Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төслийг хэлэлцэж батална.	1.дүүргийн төсөвт тухайн төсвийн жилд орох орлогыг орлого бүрдүүлэгч байгууллага, орлогын нэр төрлөөр; 2. Төсвийн урсгал зардлыг тухайн байгууллагад төсвийн жилд олгох зардлыг нийт дүнгээр; 3 Тухайн төсвийн жилд дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийг объект нэг бүрээр, санхүүжилтийн эх үүсвэрээр нь тухайн төсвийн жилд олгох санхүүжилтийн дүнгээр; 4.Нийслэлийн төсвөөс дүүрэгт олгох санхүүгийн дэмжлэгийг нийт дүнгээр нь; 5.Нийслэлд орлого төвлөрүүлдэг дүүргийн төвлөрүүлэх орлогын хэмжээг дүнгээр нь; 7.Нийслэлийн ОНХС-аас дүүрэгт олгох ОНХС-ийн хэмжээг дүнгээр нь; 8.Дүүргийн тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг салбарын сайдын багцаар ТЗШ тус бүрээр байгууллага нэг бүрээр нь нийт зардал, өөрийн үйл ажиллагааны орлогын дүнгээр;	
12 дугаар сарын 25-ны дотор	Улсын төсөв батлагдсаны дараа салбарын сайд бүртэй гэрээ байгуулна.	Тухайн төсвийн жилд нийслэлийн сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг, соёлын төв, номын сан зэрэг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын урсгал зардал болон нийслэлд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын дагуу салбарын сайд бүртэй гэрээ байгуулна.	ТТХ 2011.12.23
<b>Төсвийн гүйцэтгэл ба тайлагналт</b>			
Батлагдсанаас хойш нэг долоо хоногийн дотор	Нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн жилийн төсвийн сарын хуваарийг хийж батлан мөрдөж ажиллана. Гэрээний дагуу хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлэх ажлыг нийслэл зохион байгуулна.	Нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн жилийн төсвийн сарын хуваарийг батлан мөрдөж ажиллах бөгөөд сарын хуваарьт шаардлага гарсан тухай бүр өөрчлөлт оруулан санхүүжүүлэх эрхтэй.	
Сар бүр төсвийн гүйцэтгэлийн	Улсын төсвийн байгууллага хагас, бүтэн жилээр санхүүгийн тайлан болон		

мэдээ, хагас жил болон жилийн тайлан	бүтээгдэхүүний анги тус бүрээр тоо хэмжээ, чанар, өртөг болон хугацааны биелэлтийг тусгасан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг гаргана.		
Санхүүгийн жил дууссанаас хойш дараа жилийн 3 дугаар сарын 25-ны дотор	(1) Засаг дарга орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнана. (2) Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан үнэн зөв болохыг тодорхойлж Засаг дарга, орон нутгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч гарын үсэг зурна.		
Аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор	(1) Засаг дарга жилийн эцсийн санхүүгийн тайланг орон нутгийн төрийн аудитын байгууллагын аудитын дүгнэлтийн хамт тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ. (2) Тайлан батлагдсанаас хойш 7 хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.		
<b>Төсвийн хяналт, шинжилгээ үнэлгээ</b>			
Төсвийн жилийн турш	Нийслэл болон дүүргийн засаг дарга үр дүнгийн гэрээнд заасан орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, санхүүгийн үр дүнд хяналт тавина.	(1) төсөв, үйл ажиллагааны хөтөлбөр, үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө; (2) нэгдсэн төсвөөс санхүүжигдэж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, өртөг нь бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээтэй нийцэж байгаа эсэх.	

Эх үүсвэр: ТТХ 2011.12.23

**Хавсралт хүснэгт 2. Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн саналын баталгаажуулалтын судалгаа**

Салбар, төрөл	Улсын төсөвт тусгуулахаар СЯ, салбарын яамдад нийслэлээс хүргүүлсэн саналаар			Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд тусгагдсанаар		
	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг /сая төг/	2016 /сая төг/	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг /сая төг/	2016 /сая төг/
<b>БОЛОВСРОЛ, СОЁЛЫН САЛБАР</b>						
Саналд тусгаагүй				34	91,822	23,929
Саналыг баталсан	8	17,104	4,362	8	16,636	5,368
Саналыг хассан	167	201,280	166,700			
<b>НИЙТ</b>	<b>175</b>	<b>218,384</b>	<b>171,062</b>	<b>42</b>	<b>108,458</b>	<b>29,297</b>
<b>ЭРҮҮЛ МЭНД, СПОРТ, БИЕЙН ТАМИРЫН САЛБАР</b>						
Саналд тусгаагүй				17	88,315	14,321
Саналыг баталсан	6	56,169	19,897	6	55,097	7,128
Саналыг хассан	65	162,603	101,810			
<b>НИЙТ</b>	<b>71</b>	<b>218,772</b>	<b>121,707</b>	<b>23</b>	<b>143,412</b>	<b>21,448</b>
<b>ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД</b>						
Саналд тусгаагүй				6	14,190	7,000
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	34	56,544	34,157			
<b>НИЙТ</b>	<b>34</b>	<b>56,544</b>	<b>34,157</b>	<b>6</b>	<b>14,190</b>	<b>7,000</b>
<b>БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАР</b>						
Саналд тусгаагүй				8	43,182	6,515
Саналыг баталсан	1	793,060	251,166	1	5,000	50
Саналыг хассан	183	481,994	287,506			
<b>НИЙТ</b>	<b>184</b>	<b>1,275,054</b>	<b>538,671.5</b>	<b>9</b>	<b>48,182</b>	<b>6,565</b>
<b>ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР</b>						
Саналд тусгаагүй				11	32,393	2,319
Саналыг баталсан	8	1,123	1,123	1	1,598	280
Саналыг хассан	49	63,388	57,388			
<b>НИЙТ</b>	<b>57</b>	<b>64,510</b>	<b>58,510</b>	<b>12</b>	<b>33,991</b>	<b>2,599</b>
<b>ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАР</b>						
Саналд тусгаагүй				11	57,526	3,689

Салбар, төрөл	Улсын төсөвт тусгуулахаар СЯ, салбарын яамдад нийслэлээс хүргүүлсэн саналаар			Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд тусгагдсанаар		
	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг /сая төг/	2016 /сая төг/	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг /сая төг/	2016 /сая төг/
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	130	1,642,258	871,178			
<b>НИЙТ</b>	<b>130</b>	<b>1,642,258</b>	<b>871,178</b>	<b>11</b>	<b>57,526</b>	<b>3,689</b>
<b>МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ, ОНЦГОЙ БАЙДАЛ</b>						
Саналд тусгаагүй				4	2,758	1,910
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	19	19,292	19,122			
<b>НИЙТ</b>	<b>19</b>	<b>19,292</b>	<b>19,122</b>	<b>4</b>	<b>2,758</b>	<b>1,910</b>
<b>ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН САЛБАР</b>						
Саналд тусгаагүй				1	200	200
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	56	57,491	46,897			
<b>НИЙТ</b>	<b>56</b>	<b>57,491</b>	<b>46,897</b>	<b>1</b>	<b>200</b>	<b>200</b>
<b>ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР</b>						
Саналд тусгаагүй				1	1,351	464
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	7	151692.8	55420.3			
<b>НИЙТ</b>	<b>7</b>	<b>151,692.8</b>	<b>55,420.3</b>	<b>1</b>	<b>1,351</b>	<b>464</b>
<b>БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР</b>						
Саналд тусгаагүй				1	682	334
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	50	31,592	18,330			
<b>НИЙТ</b>	<b>50</b>	<b>31,592</b>	<b>18,330</b>	<b>1</b>	<b>682</b>	<b>334</b>
<b>БҮГД</b>	<b>783</b>	<b>3,735,589</b>	<b>1,935,055</b>	<b>110</b>	<b>410,750</b>	<b>73,505</b>
Саналд тусгаагүй				94	332,418	60,680
Саналыг баталсан	23	867,455	276,548	16	78,331	12,825
Саналыг хассан	760	2,868,135	1,658,508			



**Хавсралт хүснэгт 3. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын шинэчилсэн жагсаалтын харьцуулалт**

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	НЗДТГ-ын санал			НИТХ-аар батлагдсан		
	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
<b>НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>						
<b>Нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	7	9,187	6,230	7	10,168	5,773
Саналыг хассан	1	4,100	295			
<b>НИЙТ</b>	<b>8</b>	<b>13,287</b>	<b>6,525</b>	<b>7</b>	<b>10,168</b>	<b>5,773</b>
<b>Хот төлөвлөлт, барилгажуулалт, шинээр дэд бүтэц бий болгох</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	13	88,981	33,122	13	95,120	68,972
Саналыг хассан	4	39,301	1,319			
<b>НИЙТ</b>	<b>17</b>	<b>128,282</b>	<b>34,442</b>	<b>13</b>	<b>95,120</b>	<b>68,972</b>
<b>Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт</b>						
Саналд тусгаагүй				4	4,800	2,900
Саналыг баталсан	26	32,567	24,635	26	32,595	26,842
Саналыг хассан	3	2,106	2,106			
<b>НИЙТ</b>	<b>29</b>	<b>34,673</b>	<b>26,741</b>	<b>30</b>	<b>37,395</b>	<b>29,742</b>
<b>Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах</b>						
Саналд тусгаагүй				2	23,834	2,250
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>23,834</b>	<b>2,250</b>
<b>Бэлчээрийн менежмент хийх</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	1	2,773	2,008	1	2,813	2,388
Саналыг хассан	-	-	-			
	<b>1</b>	<b>2,773</b>	<b>2,008</b>	<b>1</b>	<b>2,813</b>	<b>2,388</b>
<b>Ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж бий болгох</b>						

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	НЗДТГ-ын санал			НИТХ-аар батлагдсан		
	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
Саналд тусгаагүй						
Саналыг баталсан	3	2,250	1,484	1	86	86
Саналыг хассан	1	4,816	23	3	2,832	2,132
<b>НИЙТ</b>	<b>4</b>	<b>7,066</b>	<b>1,507</b>	<b>4</b>	<b>2,918</b>	<b>2,218</b>
<b>Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	3	3,637	3,637	3	3,707	3,236
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>3</b>	<b>3,637</b>	<b>3,637</b>	<b>3</b>	<b>3,707</b>	<b>3,236</b>
<b>Үерийн хамгаалалтыг зохион байгуулах</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	3	50,069	1,421	3	51,092	3,099
Саналыг хассан	1	798	300			
<b>НИЙТ</b>	<b>4</b>	<b>50,867</b>	<b>1,721</b>	<b>3</b>	<b>51,092</b>	<b>3,099</b>
<b>Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	1	798	300			
<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>798</b>	<b>300</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийтийн тээврийн үйлчилгээ</b>						
Саналд тусгаагүй				4	11,350	11,350
Саналыг баталсан	-	-	-	-	-	-
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>11,350</b>	<b>11,350</b>
<b>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	1	980	727	1	1,000	500
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>980</b>	<b>727</b>	<b>1</b>	<b>1,000</b>	<b>500</b>
<b>Нийслэлийн доторх томоохон авто зам, гүүр, тэдгээрийн гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох байгууламжийг бий болгох</b>						

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	НЗДТГ-ын санал			НИТХ-аар батлагдсан		
	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
Саналд тусгаагүй						
Саналыг баталсан	7	41,045	23,349	1	1,200	500
Саналыг хассан	-	-	-	7	40,633	25,683
<b>НИЙТ</b>	<b>7</b>	<b>41,045</b>	<b>23,349</b>	<b>8</b>	<b>41,833</b>	<b>26,183</b>
<b>Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	3	10,181	9,730	3	11,125	9,525
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>3</b>	<b>10,181</b>	<b>9,730</b>	<b>3</b>	<b>11,125</b>	<b>9,525</b>
<b>Нийслэлийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, хэвийн үйл ажиллагааг хангах</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	4	7,219	4,640	4	7,219	4,322
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>4</b>	<b>7,219</b>	<b>4,640</b>	<b>4</b>	<b>7,219</b>	<b>4,322</b>
<b>НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН</b>	<b>82</b>	<b>300,810</b>	<b>115,326</b>	<b>83</b>	<b>299,573</b>	<b>169,556</b>
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>						
<b>Авто замын өргөтгөл, шинэчлэлт, шинээр барих ажил</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	3	30,527	17,350	3	30,564	17,387
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>3</b>	<b>30,527</b>	<b>17,350</b>	<b>3</b>	<b>30,564</b>	<b>17,387</b>
<b>Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт</b>						
Саналд тусгаагүй				-	-	-
Саналыг баталсан	12	15,233	15,233	12	15,196	15,196
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>12</b>	<b>15,233</b>	<b>15,233</b>	<b>12</b>	<b>15,196</b>	<b>15,196</b>
<b>Бусад</b>						
Саналд тусгаагүй				-	-	-

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	НЗДТГ-ын санал			НИТХ-аар батлагдсан		
	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
Саналыг баталсан	2	1,396	1,396	2	1,396	1,396
Саналыг хассан	-	-	-			
<b>НИЙТ</b>	<b>2</b>	<b>1,396</b>	<b>1,396</b>	<b>2</b>	<b>1,396</b>	<b>1,396</b>
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН</b>	<b>17</b>	<b>47,156</b>	<b>33,979</b>	<b>17</b>	<b>47,156</b>	<b>33,979</b>
<b>БҮГД</b>	<b>99</b>	<b>347,966</b>	<b>149,305</b>	<b>100</b>	<b>346,730</b>	<b>203,535</b>
Саналд тусгаагүй				12	41,270	17,086
Саналыг баталсан	88	296,046	144,961	88	305,460	186,449
Саналыг хассан	11	51,920	4,344			

**Хавсралт хүснэгт 4. Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, сая төгрөг, 2010-2015 он, салбараар**

	2010	2011	2012	2013	2014	2015
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	1,144,697.9	1,357,866.8	1,878,786.4	2,572,044.9	2,965,360.5	3,091,999.1
Уул уурхай, олборлох үйлдвэр	2,102,157.9	2,536,239.6	2,742,750.5	2,849,415.3	3,661,031.2	3,955,963.0
Боловсруулах үйлдвэр	664,815.3	931,377.5	1,248,666.3	1,672,313.0	1,950,933.7	1,768,221.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	190,211.6	212,394.1	233,858.6	270,514.2	313,587.1	379,866.7
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	31,210.6	44,994.4	72,529.7	77,534.0	86,481.1	103,956.1
Барилга	250,230.7	402,828.3	837,487.5	979,689.0	988,960.7	977,999.2
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1,199,007.2	1,973,260.4	2,231,148.5	2,267,231.1	2,544,761.3	2,670,254.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	677,906.2	802,897.1	894,427.6	843,617.4	1,109,154.6	1,210,594.9
